

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 28-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2023 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 28-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 28-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2023 оны 06 дугаар сарын 28-ны өдөр, Лхагва гараг

| | |
|--|-------|
| <i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i> | 1 |
| <i>Хуралдааны товч тэмдэглэл:</i> | 1-20 |
| <i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i> | 21-62 |
| <hr/> | |
| 1.“Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2023.06.16-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/ | 23-46 |
| 2.“Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл | 46-47 |
| 3.Боловсролын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2021.06.24-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг, үргэлжлэл/ | 47-60 |
| 4.Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2021.10.15-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, үргэлжлэл/ | 61-62 |

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 28-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы
06 дугаар сарын 28-ны өдөр /Лхагва гараг/-ийн нэгдсэн
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 73 гишүүнээс 37 гишүүн хүрэлцэн ирж, 50.7 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 19 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: Ш.Адьяа, Г.Амартүвшин, Э.Бат-Амгалан, Б.Бат-Эрдэнэ, Д.Батлут, С.Бямбацогт, Ж.Ганбаатар, С.Ганбаатар, Г.Ганболд, Т.Доржханд, Б.Дэлгэрсайхан, Б.Жавхлан, Х.Нямбаатар, Л.Оюун-Эрдэнэ, Б.Пүрэвдорж, Д.Сарангэрэл, Б.Саранчимэг, Н.Учрал, Ч.Хүрэлбаатар, Б.Чойжилсүрэн, Б.Энх-Амгалан;

Чөлөөтэй: Ё.Баатарбилэг;

Эмнэлгийн чөлөөтэй: Ц.Мөнхцэцэг, Ц.Цэрэнпунцаг;

Хоцорсон: Т.Аубакир- 04 минут, Ж.Батсуурь- 03 минут, Б.Баттөмөр- 05 минут, Х.Булгантуяа- 58 минут, Г.Мөнхцэцэг- 04 минут, М.Оюунчимэг- 03 минут, Д.Өнөрболор- 03 минут, О.Цогтгэрэл- 05 минут.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэнгээс албан бичиг ирүүлснийг танилцуулж, Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн үг хэлж, Боловсролын ерөнхий хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг хэлэлцэх асуудлын дараалалд оруулж хэлэлцүүлэх талаар горимын санал гаргав.

Г.Занданшатар: Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэнгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 22
Бүгд: 43
48.8 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Г.Мөнхцэцэгийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Г.Занданшатар: Улсын Их Хурлын гишүүн Г.Мөнхцэцэгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 26
Татгалзсан: 17
Бүгд: 43
60.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Г.Занданшатар: Горимын санал дэмжигдсэн тул дээрх дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулья.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 18

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 28-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

Бүгд: 43
58.1 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Боловсролын ерөнхий хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг хэлэлцэх асуудлын гуравдугаарт хэлэлцэхээр тогтов.

Нэг. “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2023.06.16-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Сайнзориг, мөн яамны Хууль зүйн бодлогын газрын ахлах шинжээч Ш.Цолмон, Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын Хөгжлийн загвар, шинэтгэлийн хэлтсийн ахлах шинжээч Х.Оюунцэцэг, Монголбанкны Удирдлага, төлөвлөлтийн газрын Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх асуудал хариуцсан ахлах референт Б.Гантуяа, Авлигатай тэмцэх газрын Тамгын хэлтсийн дарга З.Баасанням, мөн газрын Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн Ажлын албаны дарга Д.Дуламсүрэн, Судалгаа шинжилгээний албаны дарга Ц.Шинэбаяр, Мөрдөн шалгах хэлтсийн Гуравдугаар албаны дарга Ч.Жаргалбаатар, Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтсийн Мэдүүлгийн бүрдүүлэлт, дүн шинжилгээний албаны дарга Б.Баярсайхан, Судалгаа шинжилгээний албаны ажилтан Л.Хангарьд нар оролцов.

Хуралдаанд Улсын Их хурлын Тамгын газрын Тэргүүн дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Алтанцэцэг, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, Хууль зүйн байнгын хороо хариуцсан референт П.Хулан нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Өнөрболор, Т.Энхтүвшин, Ж.Батжаргал, Д.Ганбат, О.Цогтгэрэл, Г.Тэмүүлэн нарын тавьсан асуултад Хууль зүйн байнгын хорооны дарга Б.Энхбаяр, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Сайнзориг нар хариулж, тайлбар хийв.

“Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх Улсын Их Хурлын гишүүнээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Нэг.Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн санал:

Тогтоолын төсөлтэй холбоотой санал

Г.Занданшатар: 1.Улсын Их хурлын гишүүн Б.Энхбаярын гаргасан, Тогтоолын төслийн “43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсэг” гэснийг “5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг” гэж өөрчлөн, 1 дэх заалтын “1 дүгээр хавсралтаар, “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г 2 дугаар” болон “тус тус” гэснийг хасаж, тогтоолын төсөлд доор дурдсан агуулгатай 2 дахь заалт нэмэх:

“2.“Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г 2023 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор батлах, хөтөлбөрийг

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 28-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг жил бүрийн улсын төсөвт тусгаж батлуулахыг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-г даалгасугай.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 21
Бүгд: 42
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэнгийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Г.Занданшатар: Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэнгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 19
Бүгд: 42
54.8 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Г.Занданшатар: Горимын санал дэмжигдсэн тул дээрх дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулья.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 18
Бүгд: 42
57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаярын гаргасан, Тогтоолын төслийн 2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, дугаарыг 3 болгон өөрчлөх:

“Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрт тусгагдсан зорилт, үйл ажиллагааг улсын болон аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдлагад, хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах, нэгдсэн удирдлагаар ханган хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/, Авлигатай тэмцэх газар /З.Дашдаваа/-г тус тус үүрэг болгосугай.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 17
Бүгд: 42
59.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Тогтоолын төслийн хавсралттай холбоотой санал

Г.Занданшатар: 1.Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаярын гаргасан, Тогтоолын төслийн хавсралтын гарчгийн дараа доор дурдсан агуулгатай хэсэг нэмж, төслийн заалт бүрийн өмнөх “Үйл ажиллагаа” гэснийг хасах:

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 28-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

“Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр /цаашид “Хөтөлбөр” гэх/ нь “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх суурь нөхцөлийг бүрдүүлэх, үндэсний шударга ёсны тогтолцоог бэхжүүлэх замаар авлига, албан тушаалын гэмт хэргийг бууруулж, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх эрх зүйн орчныг бэхжүүлэх, нийгмийн бүх түвшинд шударга ёсыг эрхэмлэсэн хандлагыг төлөвшүүлэн, шударга ёсны засаглалыг бэхжүүлэхэд чиглэсэн, “Шинэ сэргэлтийн бодлого”-той уялдсан, 2023-2030 онд хэрэгжих дунд хугацааны зорилтот хөтөлбөр юм.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 17
Бүгд: 42
59.5 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаатар, Д.Цогтбаатар нарын гаргасан, Тогтоолын төслийн хавсралтын зорилт 1.1 дэх хэсгийн үйл ажиллагааны 1.1.4 дэх заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 18
Бүгд: 42
57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаярын гаргасан, Тогтоолын төслийн хавсралтын зорилт 1.2 дахь хэсгийн 1.2.2 дахь заалтын “Улс төрийн” гэсний өмнө “Төрийн” гэж нэмж, “албан тушаалтныг” гэсний дараах “өөрийн” гэснийг “хувийн” гэж, зорилт 1.4 дэх хэсгийн 1.4.1 дэх заалтын “механизмыг” гэснийг “тогтолцоог” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 18
Бүгд: 42
57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаярын гаргасан, Тогтоолын төслийн хавсралтын зорилт 1.5 дахь хэсгийн 1.5.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1.5.2.Улсын Их Хурлын гишүүн өөрөө эцсийн өмчлөгч, эсхүл нөлөө бүхий хувьцаа эзэмшиж байгаа хуулийн этгээдийн явуулж байгаа аж ахуйн үйл ажиллагаатай холбогдох хууль тогтоомжийн төсөл санаачлах, санал гаргахыг хязгаарласан эрх зүйн орчныг бүрдүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 18
Бүгд: 41
56.1 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаярын гаргасан, Тогтоолын төслийн хавсралтын зорилт 2.1 дэх хэсгийн 2.1.6 дахь заалтын “сайжруулах” гэсний дараа “, хариуцлагыг нэмэгдүүлэх” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 28-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 17
Бүгд: 41
58.5 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаярын гаргасан, Тогтоолын төслийн хавсралтын зорилт 2.1 дэх хэсгийн 2.1.2 дахь заалтын “хөгжүүлнэ” гэснийг “хөгжүүлж, холбогдох эрх зүйн орчныг боловсронгуй болгоно” гэж, 2.1.5 дахь заалтын “төрийн албанд ёс зүйг төлөвшүүлнэ” гэснийг “чадахуйн зарчимд суурилсан, мэргэшсэн төрийн албыг төлөвшүүлнэ” гэж, 2.1.7 дахь заалтын “төлүүлж, хяналт тавина” гэснийг “төлүүлэх, хяналт тавих тогтолцоог бүрдүүлнэ” гэж, “2.1.8” дахь заалтын дугаарыг зорилт 2.4 дэх хэсгийн “2.4.2” болгон өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 18
Бүгд: 41
56.1 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаярын гаргасан, Тогтоолын төслийн хавсралтын зорилт 2.1 дэх хэсгийн 2.1.3 дахь заалтын “гол” гэснийг, 2.1.7 дахь заалтын “бий болгож,” гэсний дараах “гөрд учруулсан” гэснийг, 2.1.4 дэх заалтыг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 20
Бүгд: 42
52.4 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаярын гаргасан, Тогтоолын төслийн хавсралтын зорилт 2.2 дахь хэсгийн “механизмыг” гэснийг “тогтолцоог” гэж, 2.2.2 дахь заалтын “орчныг бүрдүүлнэ” гэснийг “зохицуулалтыг боловсронгуй болгоно” гэж, зорилт 2.3 дахь хэсгийн 2.3.1 дэх заалтын “зохих хэмжээний зарлагаа” гэснийг “нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх буюу түүнээс дээш хэмжээний зарлагыг” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 18
Бүгд: 42
57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаярын гаргасан, Тогтоолын төслийн хавсралтын зорилт 2.4 дэх хэсэгт доор дурдсан агуулгатай 2.4.3 дахь заалт нэмэх:

“2.4.3.Монгол Улсын Үндсэн хууль болон олон улсын гэрээнд заасан албан тушаалтнуудаас бусад хуулиар тогтоосон албан тушаалын халдашгүй байдлын хүрээг хязгаарлана.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 18
Бүгд: 42
57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 28-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

10.Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаярын гаргасан, Тогтоолын төслийн хавсралтын зорилт 2.5 дахь хэсгийн 2.5.3 дахь заалтын “бүрэн цахимжуулна” гэсний өмнө “үе шаттайгаар” гэж нэмж, мөн хэсгийн “Төрд байгаа” гэснийг “Төрийн үйл ажиллагааны” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 17
Бүгд: 42
59.5 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаярын гаргасан, Тогтоолын төслийн хавсралтын зорилт 3.3 дахь хэсгийн 3.3.3 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3.3.3.Ашгийн бус салбар дахь терроризмыг санхүүжүүлэх үндэсний эрсдэлийн үнэлгээний аргачлалыг боловсруулах, Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)-ын Техник хэрэгжилтийн зөвлөмжид нийцүүлэн ашгийн бус байгууллагыг хамруулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 20
Бүгд: 42
52.4 хувийн саналаар дэмжигдлээ.

12.Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаярын гаргасан, Тогтоолын төслийн хавсралтын зорилт 5.6 дахь хэсгийн 5.6.2 дахь заалтын “хараат бус,” гэсний өмнө “улс төрөөс” гэж, зорилт 6.1 дэх хэсгийн 6.1.4 дэх заалтын “Хураасан,” гэсний өмнө “Хөрөнгө буцаасан,” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 18
Бүгд: 42
57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуралдаан даргалагчаас 13.Тогтоолын төслийн хавсралтын зорилт 5.1 дэх хэсгийн 5.1.6 дахь заалтын “хориглоно” гэснийг “хориглох эрх зүйн орчныг бүрдүүлнэ” гэж, зорилт 5.2 дахь хэсгийн 5.2.1 дэх заалтын “шинэ шатанд хүргэнэ” гэснийг “өргөжүүлнэ” гэж, зорилт 5.4 дэх хэсгийн 5.4.3 дахь заалтын “олон улсын” гэснийг “гадаад” гэж өөрчилж, зорилт 6.1 дэх хэсгийн 6.1.5 дахь заалтын “мөнгө угаах,” гэснийг хасах гэсэн саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

14.Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаярын гаргасан, Тогтоолын төслийн хавсралтын зорилт 6.1 дэх хэсгийн 6.1.6 дахь заалтын “тооцно” эснийг “тооцдог болох эрх зүйн орчныг бий болгоно” гэж өөрчилж, 6.1.8 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“6.1.8.Авлигын гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийн хувьд ногдох хөрөнгийг хураах нэмэгдэл ялын төрөл бий болгох асуудлыг судалж, санал боловсруулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 19

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 28-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

Бүгд: 41
53.7 хувийн саналаар дэмжигдлээ.

15.Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаярын гаргасан, Тогтоолын төслийн хавсралтын зорилт 6.1 дэх хэсгийн 6.1.11 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“6.1.11.Хахууль өгсөн, зуучилсан хүн, хуулийн этгээд гэмт үйлдлээ илчилсэн, нотлох баримт гаргаж өгсөн, хамтран ажилласан тохиолдолд эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлэх, чөлөөлөх эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 17
Бүгд: 42
59.5 хувийн саналаар дэмжигдлээ.

16.Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаярын гаргасан, Тогтоолын төслийн хавсралтын зорилт 6.1 дэх хэсгийн 6.1.12 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 20
Бүгд: 42
52.4 хувийн саналаар дэмжигдлээ.

17.Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаярын гаргасан, Тогтоолын төслийн хавсралтын зорилт 6.1 дэх хэсгийн 6.1.15 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“6.1.15.Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)-ын 40 зөвлөмж, үр дүнтэй байдлын шууд хэрэгжилтийн 11 шалгуурыг хангаж, санхүүгийн бус бизнес мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдийн үйл ажиллагаанд тавих хяналтыг нэмэгдүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 17
Бүгд: 41
58.5 хувийн саналаар дэмжигдлээ.

18.Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаярын гаргасан, Тогтоолын төслийн хавсралтын зорилт 6.2 дахь хэсгийн 6.2.4 дэх заалтын “шийдвэрлүүлнэ” гэснийг “шийдвэрлүүлэх эрх зүйн орчныг бататгана” гэж, 6.3.1 дэх хэсгийн “болгоно” гэснийг “болгох эрх зүйн орчныг бүрдүүлнэ” гэж өөрчилж, 6.2.5 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“6.2.5.Эдийн засаг, авлига, хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг болон мөнгө угаах өндөр эрсдэлтэй гэмт хэргийг суурь гэмт хэрэгт хамааруулах, гэмт хэргийн шинж, зохицуулалтыг Нэгдсэн Үндэстний Байгууллагын гэрээ, конвенц, олон улсын стандартад нийцүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 17

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 28-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

Бүгд: 41
58.5 хувийн саналаар дэмжигдлээ.

19.Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаярын гаргасан, Тогтоолын төслийн хавсралтын зорилт 6.4 дэх хэсгийн 6.4.3 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 16
Бүгд: 41
61.0 хувийн саналаар дэмжигдлээ.

20.Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаярын гаргасан, Тогтоолын төслийн хавсралтын зорилт 6.4 дэх хэсгийн 6.4.6 дахь заалтын “суллахгүй байх” гэсний өмнө “шүүхээс” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 17
Бүгд: 41
58.5 хувийн саналаар дэмжигдлээ.

21.Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаярын гаргасан, Тогтоолын төслийн хавсралтын зорилт 6.4 дэх хэсгийн 6.4.12 дахь заалтын “механизмыг” гэснийг “үйл ажиллагааг” гэж өөрчлөн, 6.4.11 дэх заалтын “нэгжийг” гэсний дараах “тодорхой тооны мөрдөгчтэйгээр” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 16
Бүгд: 41
61.0 хувийн саналаар дэмжигдлээ.

22.Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаярын гаргасан, Тогтоолын төслийн хавсралтын зорилт 7.1 дэх хэсгийн 7.1.8 дахь заалтын “жендерийн мэдрэмжтэй,” гэсний өмнө “хүний эрх,” гэж нэмж, 7.1.5 дахь заалтын “суурилж батлан” гэснийг “суурилсан эсэхийг хянах тогтолцоог бүрдүүлж,” гэж өөрчилж, 7.1.11 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“7.1.11.Төсвийн захирагчийн албан тушаалд нэр дэвшигчдийг бодлого, хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрөөр өрсөлдүүлэх зарчмыг баримтлан сонгон шалгаруулж, төсвийн ерөнхийлөн болон төвлөрүүлэн захирагчид нэр дэвшигчийн сонголыг зохион байгуулж хэвшинэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 17
Бүгд: 42
59.5 хувийн саналаар дэмжигдлээ.

23.Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаярын гаргасан, Тогтоолын төслийн хавсралтын зорилт 7.1 дэх хэсгийн 7.1.13 дахь заалтын “төрийн аудитын” гэсний дараа “байгууллага” гэж нэмж, “таргана” гэснийг “таргадаг үйл ажиллагааг тогтмол болгоно” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 28-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

Зөвшөөрсөн: 26
Татгалзсан: 16
Бүгд: 42
61.9 хувийн саналаар дэмжигдлээ.

24.Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаярын гаргасан, Тогтоолын төслийн хавсралтын зорилт 7.3 дахь хэсгийн “тусламж, тусгай сангийн” гэснийг “тусгай сан, гадаадын зээл, тусламжийн” гэж, 7.3.5, 7.3.6 дахь заалтыг 7.3.2, 7.3.3 болгон дугаарлалтыг өөрчилж, 7.3.4 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“7.3.4.Эрүүл мэнд, Нийгмийн даатгалын сангийн төсөв, хөрөнгийн удирдлага ил тод, хараат бус, олон нийтийн хяналтад байх тогтолцоог бүрдүүлж, холбогдох яам, агентлаг, үндэсний зөвлөлийн эрх хэмжээ, хяналт, хариуцлагыг нэмэгдүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 17
Бүгд: 42
59.5 хувийн саналаар дэмжигдлээ.

25.Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргилын гаргасан, Тогтоолын төслийн хавсралтын зорилт 8.1 дэх хэсэгт доор дурдсан агуулгатай 8.1.6 дахь заалт нэмэх:

“8.1.6.Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх төсвийн зарлага, төрийн оролцоог үе шаттай бууруулж, Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийг шинээр байгуулахыг хязгаарлана.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 26
Татгалзсан: 16
Бүгд: 42
61.9 хувийн саналаар дэмжигдлээ.

26.Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаярын гаргасан, Тогтоолын төслийн хавсралтын зорилт 9.4 дэх хэсгийн 9.4.2 дахь заалтын “болгож, контентыг шүүлтүүртэй” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 26
Татгалзсан: 15
Бүгд: 41
63.4 хувийн саналаар дэмжигдлээ.

27.Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаярын гаргасан, Тогтоолын төслийн хавсралтын зорилт 9.5 дахь хэсгийн 9.5.1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“9.5.1.Төрийн албан хаагч, удирдах албан тушаалтнуудад авлигын эсрэг сургалтыг үе шаттай зохион байгуулах, ёс зүй, манлайллын хөтөлбөр хэрэгжүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 17
Бүгд: 41

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 28-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

58.5 хувийн саналаар дэмжигдлээ.

28. Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаярын гаргасан, Тогтоолын төслийн хавсралтад доор дурдсан агуулгатай Зорилго 11 нэмэх:

“Зорилго 11. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх, хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, тайлагнах, зохион байгуулалт, удирдлагын тогтолцоог сайжруулна.

Зорилт 11.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийн зохион байгуулалт, тайлагналт, хяналт-шинжилгээ, үнэлгээний үр нөлөөг дээшлүүлнэ.

11.1.1. Монгол Улсын Засгийн газар Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг баталж, санхүүжүүлнэ. Яам, агентлаг, нутгийн өөрөө удирдах болон захиргааны байгууллага, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн авлигатай тэмцэх үйл ажиллагааны хэрэгжилтийг уялдуулан зохицуулах, хяналт тавих чиг үүргийг Засгийн газар хариуцан ажиллана.

11.1.2. Авлигатай тэмцэх газрын бүтцэд хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах, дэмжлэг үзүүлэх, хяналт тавих, тайлан мэдээг нэгтгэн хэрэгжилтийг үнэлэх, зөвлөмж өгөх, иргэд, олон нийтэд мэдээлэл хүргэх чиг үүрэг бүхий Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх Ажлын алба ажиллана.

11.1.3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилт хариуцсан байгууллагууд хэрэгжилтийн тайланг жил бүрийн 02 дугаар сарын 01-ний дотор Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Авлигатай тэмцэх газарт тус тус хүргүүлнэ.

11.1.4. Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Авлигатай тэмцэх газар нь Хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг нэгтгэн хэрэгжүүлэгч байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үр дүнг үнэлэн, санал, дүгнэлтээ Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороонд танилцуулна.

11.1.5. Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо тайлан, үнэлгээ, санал, дүгнэлтийг хэлэлцэж, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, зөрчлийг арилгах, ажлаа эрчимжүүлэх талаар чиглэл өгч болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 26

Татгалзсан: 15

Бүгд: 41

63.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Хоёр. Хууль зүйн байнгын хороо дэмжээгүй санал:

Г. Занданшатар: 1. Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаярын гаргасан, Тогтоолын төслийн хавсралтын зорилт 7.1 дэх хэсгийн 7.1.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“7.1.2. Тухайн жилийн Төсвийн тухай хуулийг эрх бүхий байгууллагаас боловсруулж өргөн мэдүүлэх, хэлэлцэн батлахдаа төсвийн ерөнхийлөн захирагч бүрийн төвлөрүүлэх орлого, зарцуулах зардлыг нийт дүнгээр нь, түүнчлэн эдийн засгийн ангилал,

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 28-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

төрөл, зориулалт тус бүрээр тусгана.” гэсэн Хууль зүйн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 20
Бүгд: 41
51.2 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргилын гаргасан, Тогтоолын төслийн хавсралтын “Зорилго 8” гэснийг “Зорилго 3” болгон өөрчлөх гэсэн Хууль зүйн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 26
Татгалзсан: 15
Бүгд: 41
63.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Найруулгын санал:

Г.Занданшатар: 1.Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаярын гаргасан, Тогтоолын төслийн хавсралтын зорилт 1.2 дахь хэсгийн 1.2.1 дэх заалтын “төлбөргүй” гэсний өмнө “үнэ” гэж, зорилт 9.2 дахь хэсгийн 9.2.1 дэх заалтын “төлөвшүүлнэ” гэсний өмнө “олон нийтэд” гэж, зорилт 9.4 дэх хэсгийн 9.4.4 дэх заалтын “Боловсролын” гэсний дараа “сургалтын” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 17
Бүгд: 41
58.5 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаярын гаргасан, Тогтоолын төслийн хавсралтын зорилт 1.5 дахь хэсгийн 1.5.3 дахь заалтын “зохицуулалт, механизмыг” гэснийг “зохицуулалтыг” гэж, зорилт 3.1 дэх хэсгийн 3.1.3 дахь заалтын “тавих” гэснийг “тавивгдах” гэж, зорилт 3.2 дахь хэсгийн 3.2.4 дэх заалтын “иргэдийн шууд хяналт, мониторинг хэрэгжүүлэх” гэснийг “иргэд шууд хяналт тавих боломжийг” гэж, зорилт 3.3 дахь хэсгийн 3.3.2 дахь заалтын “дэмжлэг” гэснийг “тусламж” гэж, зорилт 5.1 дэх хэсгийн 5.1.6 дахь заалтын “батлагдсан төсвийн хэмжээнээс” гэснийг “батлагдсан төсвөөс” гэж, зорилт 5.4 дэх хэсгийн 5.4.4 дэх заалтын “хүний нөөцийн чадавхыг бий болгоно” гэснийг “хүний нөөцийг бэхжүүлнэ” гэж, зорилт 6.2 дахь хэсгийн 6.2.3 дахь заалтын “яллах ажиллагаа дахь” гэснийг “яллах ажиллагааны явцад” гэж, мөн заалтын “эзэмшүүлнэ” гэснийг “эзэмших нөхцөл боломжийг бий болгоно” гэж, 6.2.4 дэх заалтын “гадаад оронд” гэснийг “гадаад улсад” гэж, зорилт 6.4 дэх хэсгийн 6.4.5 дахь заалтын “ил тод байдлыг бий болгох” гэснийг “ил тод байдлыг бий болгоно” гэж, 6.4.9 дэх заалтын “санхүүгийн мэдээлэл,” гэснийг “санхүү, орлогын эх үүсвэрийн” гэж, зорилт 7.1 дэх хэсгийн “Төсвийн төлөвлөлтийг” гэснийг “Төсвийн төлөвлөлтийн тогтолцоог” гэж, мөн хэсгийн “оролцоог хангаж, тогтолцоог” гэснийг “оролцоог хангах замаар” гэж, зорилт 7.2 дахь хэсгийн 7.2.2 дахь заалтын “зохион байгуулж” гэснийг “зохион байгуулдаг тогтолцоог бүрдүүлж,” гэж, 7.2.3 дахь заалтын “данснаас хассан” гэснийг “данснаас хасагдсан” гэж, зорилт 7.4 дэх хэсгийн 7.4.3 дахь заалтын “цахим хэлбэрт бүрэн шилжүүлнэ” гэснийг “бүрэн цахимжуулна” гэж, зорилт 8.4 дэх хэсгийн 8.4.2 дахь заалтын “нээлттэй сонсгол” гэснийг “нийтийн сонсгол” гэж, зорилт 9.3 дахь хэсгийн 9.3.1 дэх заалтын “Бүх шатны сургалтын” гэснийг “Бүх түвшний

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 28-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

сургалтын” гэж, зорилт 9.4 дэх хэсгийн 9.4.3 дахь заалтын “зүйлсийг бууруулах дүн шинжилгээ хийнэ” гэснийг “зүйлсэд дүн шинжилгээ хийж, бууруулах арга хэмжээ авч хэрэгжүүлнэ” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 25

Татгалзсан: 16

Бүгд: 41

61.0 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаярын гаргасан, Тогтоолын төслийн хавсралтын зорилт 1.2 дахь хэсгийн 1.2.1 дэх заалтын “эдгээрийг амлах” гэсний өмнөх “эсхүл” гэснийг, 2.4 дэх хэсгийн “хууль,” гэснийг, 5.4.4 дэх заалтын “шаардлагатай” гэснийг, 6.2 дахь хэсгийн 6.2.3 дахь заалтын “олон улсын” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 24

Татгалзсан: 17

Бүгд: 41

58.5 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаярын гаргасан, Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн бүтэц, нэр томьёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл, заалтын дугаар, эшлэлийг нийцүүлж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23

Татгалзсан: 18

Бүгд: 41

56.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулж дуусав.

“Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 16 цаг 05 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр. “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Авлигатай тэмцэх газрын Тамгын хэлтсийн дарга З.Баасанням, мөн газрын Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн Ажлын албаны дарга Д.Дуламсүрэн, Судалгаа шинжилгээний албаны дарга Ц.Шинэбаяр, Мөрдөн шалгах хэлтсийн Гуравдугаар албаны дарга Ч.Жаргалбаатар, Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтсийн Мэдүүлгийн бүрдүүлэлт, дүн шинжилгээний албаны дарга Б.Баярсайхан, Судалгаа шинжилгээний албаны ажилтан Л.Хангарьд нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, Хууль зүйн байнгын хороо хариуцсан референт П.Хулан нар байлцав.

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 28-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

Төслийг хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Г.Занданшатар: Байнгын хорооны саналаар “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 19
Бүгд: 41
53.7 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 16 цаг 10 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Боловсролын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2021.06.24-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг, үргэлжлэл/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Боловсрол, шинжлэх ухааны дэд сайд Г.Ганбаяр, Боловсрол, шинжлэх ухааны яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга О.Хуягцогт, мөн яамны Ерөнхий боловсролын бодлогын удирдлага, зохицуулалтын газрын Сургуулийн өмнөх боловсролын хэлтсийн дарга Ж.Мягмар, Боловсролын нэгдсэн бодлого төлөвлөлтийн газрын ахлах шинжээч А.Цолмон, шинжээч Ж.Нарантуяа, Төрийн захиргааны удирдлагын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн ахлах шинжээч Ч.Баярмаа, Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн секторын эрхлэгч У.Туяа, Монголын боловсрол, шинжлэх ухааны үйлдвэрчний эвлэлийн холбооны дарга З.Цогтгэрэл нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Р.Болормаа, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, референт Н.Монголмаа нар байлцав.

Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дарга Д.Тогтохсүрэн Боловсролын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төслийн асуудлаар Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгээс авсан завсарлага дууссаныг мэдэгдэв./16:11/

Боловсролын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төслийн талаар Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Г.Занданшатар: 1.Төслийн 12 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“12 дугаар зүйл. Багш, ажилтны мэргэжлийн хөгжлийн тогтолцоо

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 28-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

12.1.Багш, ажилтан нь боловсролын хууль тогтоомж, Хөдөлмөрийн тухай хуулийн 17.6-д заасан ажил мэргэжлийн стандарт, албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргийг хэрэгжүүлнэ.

12.2.Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангид багш мэргэжлийн сонгон бүлэг хичээллүүлж, амжилттай төгсөгчийг багш бэлтгэх дээд боловсролын сургалтын байгууллагад элсэн суралцахад нь төрөөс дэмжлэг үзүүлнэ.

12.3.Энэ хуулийн 12.2-т заасан дэмжлэг үзүүлэх журмыг Засгийн газар батална.

12.4 Багш, ажилтны мэргэжлийн хөгжлийн үйл ажиллагаа, багш мэргэжлийн сонгон бүлэг байгуулах журам, сургалтын хөтөлбөрт тавих шаардлагыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

12.5.Дээд боловсролын сургалтын байгууллага магадлан итгэмжлэгдсэн хөтөлбөрөөр багшийг бэлтгэнэ. Багшаас бусад мэргэжилтэй иргэн багш бэлтгэх хувилбарт сургалтад хамрагдан багшаар ажиллаж болно.

12.6.Багш бэлтгэх сургалтын хөтөлбөр нь энэ хуулийн 5.1.4-т заасан зарчимд үндэслэсэн, Хөдөлмөрийн тухай хуулийн 16.7-д заасан ажил мэргэжлийн стандартад нийцсэн байна

12.7.Багш бэлтгэх сургалтын хөтөлбөрөөр амжилттай суралцсан суралцагчид сургалтын төлбөрийн хөнгөлөлт, дэмжлэг төрөөс үзүүлнэ.

12.8.Сургуулийн өмнөх ерөнхий боловсрол, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын багш нь багшлах эрхийн гэрчилгээтэй байна.

12.9.Багшийн хөгжлийг дэмжих тухай хуулийн 8.5-д заасан багшлах эрхийг энэ хуулийн 12.8-д заасан багшлах эрхийн гэрчилгээгэд тооцно.

12.10.Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн сул орон тоонд аймаг, сум, баг, дүүрэг, тосгоны удирдлагын захиалгаар, эсхүл өөрийн хүсэлтээр 3-аас доошгүй жил мэргэжлээрээ ажиллах гэрээ байгуулсан багшид төрөөс дэмжлэг үзүүлнэ.

12.11.Багшийн мэргэжлийн хөгжлийн үйл ажиллагааг үндэсний болон орон нутгийн түвшинд тухайн түвшний боловсролын сургалтын байгууллага багш бэлтгэх дээд боловсролын сургалтын байгууллагыг түшиглэн боловсролын харилцаанд оролцогч талуудтай хамтран зохион байгуулна.

12.12.Багшийн мэргэжлийн хөгжлийн цахим системтэй байна.

12.13.Багшийн хөгжлийг дэмжих тухай хуулийн 3.1.3-т заасан төв нь багш, ажилтны мэргэжлийн хөгжлийн үйл ажиллагааг зохион байгуулах бие даасан нэгжтэй байх бөгөөд нэгжийн жишиг бүтэц, орон тоог боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

12.14.Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежийн багш, удирдах ажилтныг өөртэй нь тохиролцон тухайн аймаг, сум, дүүрэг, баг, тосгоны боловсролын сургалтын байгууллагын адил чанарын өөр ажилд шилжүүлэн ажиллуулж болно.

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 28-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

12.15.Энэ хуулийн 12.14-т заасан багш, удирдах ажилтныг шилжүүлэн ажиллуулах хугацаа, журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

12.16.Багш бэлтгэл дээд боловсролын сургалтын байгууллагын төгсөх ангийн суралцагчийг цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багшийн сул орон тоонд Хөдөлмөрийн тухай хуулийн 62 дугаар зүйлд заасан дагалдан багшаар ажиллуулж болно.

12.17.Багш нь үндсэн ажлын цагаас бусад цагт өөр ажил олгогчтой зэрэгцсэн хөдөлмөрийн гэрээ байгуулж, нэмэлт орлого олж болно. Энэ харилцааг Хөдөлмөрийн тухай хуулийн 57 дугаар зүйлд заасны дагуу зохицуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25

Татгалзсан: 16

Бүгд: 41

61.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Г.Занданшатар: 2.Төслийн 13 дугаар зүйлийн 13.2.11 дэх заалтын “ажил хаялт” гэснийг “суралцагчийн эрхийг зөрчих” гэж өөрчилж, мөн заалтын “удирдах ажилтан” гэсний өмнө “багш” гэж, 13.2.12 дахь заалтын “асран хамгаалагч” гэсний дараа “харгалзан дэмжигч” гэж, 13.3.3 дахь заалтын “нийгмийн ажилтан” гэсний дараа “хоол зүйч, сэтгэл зүйч” гэж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 13.2.17, 13.2.18, 13.2.19, 13.3.7, 13.3.8 дахь заалт, 13.9 дэх хэсэг нэмэх:

“13.2.17.Суралцагч болон сургалтын мэдээллийг цахим мэдээллийн санд хугацаанд нь бүртгэх, тайлагнах;

13.2.18.Ажлын гүйцэтгэлийн үнэлгээнд хамрагдах, үр дүнд үндэслэн мэргэжлийн хөгжлийн хэрэгцээг тодорхойлж, төлөвлөх, хэрэгжүүлэх;

13.2.19.Суралцагч, эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчтэй хамтран ажиллах, зөвлөн туслах;

13.3.7.Дээд боловсролын сургалтын байгууллагын багш, ажилтан өндөр насны тэтгэвэр тогтоолгоход Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу тэтгэмжийг тухайн боловсролын сургалтын байгууллагаас олгох;

13.3.8.Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежид 15-аас доошгүй жил тасралтгүй ажилласан багш, ажилтны нэг хүүхдийг тэргүүлэх, эрэлттэй мэргэжлээр төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагад үнэ төлбөргүй, хөнгөлөлттэй нөхцөлөөр суралцуулах бөгөөд холбогдох журмыг Засгийн газар батлах;

13.9.Боловсролын болон хөдөлмөрийн хууль тогтоомжид зааснаас бусад чиг үүргийг багшаар гүйцэтгүүлэхийг хориглоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 27

Татгалзсан: 14

Бүгд: 41

65.9 хувийн саналаар дэмжигдлээ.

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 28-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

Г.Занданшатар: 3.Төслийн “ТУРАВДУГААР БҮЛЭГ”-ийн нэрийг “БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА” гэж өөрчилж, 17 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 19, 20 дугаар зүйлийг төслөөс хасах.

17.1.Боловсролын байгууллага нь боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн үнэлгээний, чанарын баталгаажуулалт-магадлан итгэмжлэлийн, боловсролын сургалтын, насан туршийн суралцахуйн төвөөс бүрдэнэ.

17.2.Боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллага нь боловсролын бодлогын суурь, хавсарга судалгаа, шинжилгээ, инновац, арга зүйн болон сургалт эрхлэх чиг үүргийг хэрэгжүүлнэ.

17.3.Боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллагыг Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд заасны дагуу байгуулна.

17.4.Энэ хуулийн 17.2-т заасан байгууллага нь сургуулийн өмнөх, ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, сургалтын арга зүй, үнэлгээ, сурах бичгийн тохирц, нийцлийг шалган турших түшиц цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуультай байж болно.

17.5.Боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллага энэ хуулийн 17.4-т заасан түшиц цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийг сонгон туршилт зохион байгуулж болно.

17.6.Насан туршийн суралцахуйн төв нь иргэний албан, албан бус сургалтаар боловсрол эзэмших, бие даан суралцахад мэдээллээр ханган, зөвлөн туслах, удирдан зохион байгуулах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Насан туршийн суралцахуйн төв нь боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын харьяанд байна.

17.7.Насан туршийн суралцахуйн төв нь бичиг үсгийн болон ерөнхий боловсрол нөхөн эзэмшүүлэх сургалтыг төлбөргүй зохион байгуулна.

17.8.Энэ хуулийн 17.6-д заасан төв нь танхимын сургалтад хамрагдах боломжгүй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд боловсрол, эрүүл мэнд, нийгмийн халамжийн цогц үйлчилгээг Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд заасан түншлэлийн гэрээгээр хэрэгжүүлж болно.

17.8.Боловсрол, эрүүл мэнд, хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь хамтран хөгжлийн бэрхшээлтэй хүний боловсрол эзэмшихэд дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий дэмжих төв ажиллуулж болно.

17.9.Энэ хуулийн 17.8-д заасан дэмжих төвийн үйл ажиллагааны зардлыг боловсрол, нийгмийн хамгаалал, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран санхүүжүүлнэ.

17.10.Боловсролын үнэлгээ, арга зүйн байгууллага нь боловсролын бүх түвшний үнэлгээ, элсэлтийн шалгалт зохион байгуулах, хүний мэдлэг, чадвар, чадамжийг үнэлэх, хүлээн зөвшөөрөх, баталгаажуулах, үнэлгээний хөгжлийг хангах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

17.11.Энэ хуулийн 17.10-т заасан үнэлгээ, элсэлтийн шалгалтын журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 28-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

17.12.Боловсролын чанарын баталгаажуулалт-магадлан итгэмжлэлийн байгууллага нь боловсролын сургалтын байгууллага, сургалтын хөдөлмөрийн чанарыг эрх бүхий байгууллагын баталсан стандарт, шаардлагын дагуу магадлан итгэмжлэх, чанарын баталгаажуулалтыг удирдлага, арга зүйгээр хангах, мэргэшлийн үндэсний шаталсан бүтцийг эрхлэн хариуцах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

17.13. Энэ хуулийн 17.12-т заасан байгууллага нь магадлан итгэмжлэх хийх эрхийг дотоодын байгууллагад олгох, Зөвшөөрлийн тухай хуулийн 8.2 дугаар зүйлийн 7.9-д заасны дагуу гадаадын хуулийн этгээдэд зөвшөөрөл олгох, гадаад улсын, олон улсын эрх бүхий байгууллагатай хамтран магадлан итгэмжлэл хийх, олон улсад магадлан итгэмжлэгдсэн хөтөлбөрийг баталгаажуулах, бүртгэх үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

17.14.Энэ хуулийн 17.12-т заасан байгууллага олон улсын гэрээ, хэлэлцээрийн хүрээнд боловсролын зэрэг, баримт бичгийг харилцан хүлээн зөвшөөрөх судалгаа, үнэлгээ хийх, баталгаажуулах сантай байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 28

Татгалзсан: 13

Бүгд: 41

68.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар 4.Төслийн 21-26 дугаар зүйлийг 21-24 дүгээр зүйл болон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“21 дүгээр зүйл. Зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгох

21.1.Боловсролын сургалтын байгууллагыг энэ хууль, Зөвшөөрлийн тухай хууль болон холбогдох стандарт, техникийн зохицуулалтын шаардлага хангасан этгээд байгуулж болно.

21.2.Боловсролын сургалт эрхлэх үйл ажиллагаатай холбогдох зөвшөөрлийг Зөвшөөрлийн тухай хуульд заасны дагуу эрх бүхий этгээд олгоно.

21.3.Орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежийг байгуулах, өөрчлөх, татан буулгах асуудлыг Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд заасны дагуу шийдвэрлэнэ.

21.4.Зөвшөөрөл олгосон эрх бүхий этгээд нь Зөвшөөрлийн тухай хуульд заасан үндэслэлээр зөвшөөрлийг түдгэлзүүлж, хүчингүй болгоно.

21.5.Гадаад улсад Монгол Улсын үндэсний сургалтын хөтөлбөрөөр боловсролын сургалтын үйл ажиллагаа эрхлэх асуудлыг тухайн улсын эрх бүхий байгууллагын шийдвэрийг үндэслэн Монгол Улсын хилийн чанадад ажиллаж байгаа Дипломат төлөөлөгчийн газар, гадаад хэргийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.” гэсэн саналыг хойшлуулав./16:33/

Г.Занданшатар: 5.Төслийн 33 дугаар зүйлийн 33.1.4, 33.1.6, 33.1.7, 33.1.9 дэх заалт, 33.3, 33.4 дэх хэсэг, 33.5.3, 33.6.3 дахь заалтыг хасаж, 33.1.5 дахь заалтын “боловсролын” гэсний дараа “сургалтын” гэж, 33.1.12 дахь заалтад доор дурдсан агуулгатай тайлбар,

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 28-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

33.1.19 дэх заалт, 33.7, 33.8, 33.9 дэх хэсэг нэмж, 33.5.1, 33.6.1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“Тайлбар: Ерөнхий боловсролын сургуулийн хоол, үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн 3.1.4-т заасан “сургуулийн орчин” гэсэн тодорхойлолтод бүх түвшний боловсролын сургалтын байгууллагын орчин хамаарна.

33.1.19.зайн болон цахим сургалтын чанар, үр дүнг сайжруулах үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;

33.7.Аймаг, Нийслэлийн боловсролын газрын дарга сонгон шалгаруулалтын дүнг үндэслэн харьяа нутаг дэвсгэр дэх төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэгийн эрхлэгч, ерөнхий боловсролын сургуулийн захирлыг томилж, хуульд заасан үндэслэлээр чөлөөлнө.

33.8.Нийслэлийн боловсролын газрын дарга дүүргийн боловсролын хэлтсийн даргыг сонгон шалгаруулалтын дүнг үндэслэн томилж, хуульд заасан үндэслэлээр чөлөөлнө.

33.9.Боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас баталсан аргачлалын дагуу хамран сургах тойргийг боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллага тогтооно.

33.5.1.Боловсролын сургалтын байгууллагад 10-аас доошгүй жил, үүнээс боловсролын сургалтын байгууллагын багш, удирдах эсхүл нийгмийн ажилтнаар 5-аас доошгүй жил ажилласан, магистр зэрэгтэй байх;

33.6.1.Боловсролын сургалтын байгууллагад 10-аас доошгүй жил, үүнээс боловсролын сургалтын байгууллагын багш, удирдах эсхүл, нийгмийн ажилтнаар 5-аас доошгүй жил ажилласан байх;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн, Ж.Батжаргал нар үг хэлэв.

| | |
|-------------|----|
| Зөвшөөрсөн: | 22 |
| Татгалзсан: | 18 |
| Бүгд: | 40 |

55.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Г.Занданшатар: 6.Төслийн 43 дугаар зүйлийн 43.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“43.2 Хувьсах зардлын хэмжээ, бүрэлдэхүүнийг сургуулийн байршил, мэргэжлийн чиглэл, сургалтын хөтөлбөр, суралцагчийн ялгаатай хэрэгцээг харгалзан суралцах тэгш боломж олгох зорилгоор боловсролын сургалтын байгууллагын түвшин бүрээр тогтоож санхүүжүүлэх журмыг Засгийн газар батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

| | |
|-------------|----|
| Зөвшөөрсөн: | 27 |
| Татгалзсан: | 13 |
| Бүгд: | 40 |

67.5 хувийн саналаар дэмжигдлээ.

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 28-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

Г.Занданшатар: 7.Төслийн 43 дугаар зүйлийн 43.4.1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“43.4.1.Холбогдох хууль тогтоомжид заасны дагуу өмчийн хэлбэр үл харгалзан цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежийн нэг суралцагчид олгох хувьсах зардал;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 27
Татгалзсан: 13
Бүгд: 40
67.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Г.Занданшатар: 8.Төсөлд доор дурдсан агуулгатай 43.11 дэх хэсэг нэмэх:

“43.11.Энэ хуулийн 43.4.1-т заасан зардлыг үндэсний хөтөлбөр хэрэгжүүлж байгаа төрийн бус өмчийн ерөнхий боловсролын сургуульд гэрээний гүйцэтгэлд үндэслэн олгох бөгөөд гэрээний үр дүнгийн шалгуурыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 27
Татгалзсан: 13
Бүгд: 40
67.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Г.Занданшатар: 9.Төслийн 6 дугаар зүйлийн 6.2.1, 6.2.2, 6.2.3 дахь заалт, 6.3 дахь хэсгийг төслөөс хасаж, 6 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 6.5, 6.6 дахь хэсэг нэмэх:

“6.5.Сонсголгүй суралцагчийн боловсрол эзэмших сургалт, үйл ажиллагааны хэл нь Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан хэл байна.

6.6.Боловсролын сургалтын байгууллагад судлах гадаад хэл нь сургалтын үндэсний хөтөлбөрийн үзэл баримтлалд заасан хэл байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар, Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням, Ж.Чинбүрэн, О.Цогтгэрэл, Т.Аубакир нар үг хэлэв.

Хуралдаан даргалагчаас дээрх санал хураалтыг хойшлуулав./17:01/

Уг асуудлыг 17 цаг 01 минутад хэлэлцэж дусав.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Төмөр замын тээврийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл, мөн Иргэний нисэхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хууль санаачлагч нь байхгүй тул хойшлуулсан талаар мэдэгдэв./17:14/

Дөрөв.Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2021.10.15-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, үргэлжлэл/

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 28-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Батжаргал, мөн газрын ахлах мэргэжилтэн Ө.Бодьгэрэл нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Мажигсүрэн, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Нийгмийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Цогзолбаяр нар байлцав.

Төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаярын тавьсан асуултад Нийгмийн бодлогын байнгын хорооны дарга П.Анужин, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Батжаргал нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны ирц хүрэхгүй болсон тул Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг хэлэлцэхийг хойшлуулав./17:21/

Бусад. Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд, Ж.Батжаргал, Ц.Туваан нарын урилгаар Төв аймгийн Жаргалант сумын тариалан эрхлэгч залуучуудын төлөөлөл Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцав.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 4 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа нар хариуцан ажиллав.

Хуралдаан 3 цаг 03 минут үргэлжилж, 73 гишүүнээс 49 гишүүн хүрэлцэн ирж, 67.1 хувийн ирцтэйгээр 17 цаг 22 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Л.ӨЛЗИЙСАЙХАН

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 28-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 06 дугаар сарын 28-ны өдөр,
Лхагва гараг
Төрийн ордон “Их Хуралдай” танхим
14 цаг 19 минут.

**НЭГДСЭН ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Г.Занданшатар: Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы 06 дугаар сарын 28-ны өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

1-д, “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

2 дугаарт, “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.

3 дугаарт, Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлэг явуулна.

4-д, Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд.

5 дугаарт, Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үргэлжлүүлэн хэлэлцэнэ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13.4-д гишүүн энэ хуулийн 9.5-д заасан нэгдсэн хуралдаанаар хэлэлцэхээр тогтсон асуудлыг хойшлуулах, дараалал өөрчлөх, асуудал нэмэх горимын санал гаргах бол Улсын Их Хурлын даргад нэгдсэн

хуралдааны өмнөх өдрийн 17 цагаас өмнө үндэслэл бүхий саналаа бичгээр ирүүлнэ гэж заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Жигжидсүрэнгийн Чинбүрэнгээс албан бичиг ирүүлсэн байна.

6 дугаар сарын 28-ны өдрийн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудалтай холбогдуулан асуудал нэмэх чиглэлээр үг хэлэх хүсэлтэй байгаа тул зохих журмын дагуу зөвшөөрөл олгоно уу. Улсын Их Хурлын гишүүн Чинбүрэн гэсэн байна.

Жигжидсүрэнгийн Чинбүрэн гишүүн үг хэлнэ.

Ж.Чинбүрэн: Баярлалаа. Эрхэм гишүүддээ энэ өдрийн мэнд хүргэе. Бид хаврын чуулган дуусах гээд нэлээн ачаалалтай, хөтөлбөр нэлээн шахуу явж байгаа хэдий ч бид бас чухал чухал асуудлуудаа энд хэлэлцэж ярих шаардлагатай байна. Тухайлах юм бол дэлхий нийтийг хамарсан ковид цар тахлын үед эмнэлгийн хэрэгсэл ховордож зах зээл дэх эмийн хүртээмж хомсдол үүссэн. Түүнийг дагаад үүний хэт хөөргөдөл бий болж, эмийн хүртээмжийн анхаарал татсан асуудлыг бид саяхан болсныг мартаагүй байгаа.

Эрүүл мэндийн яам болон Азийн хөгжлийн банкны санаачилгаар 2017 онд Монгол Улсын эмийн үнэ, хүртээмж, худалдан авах боломж гэсэн сэдвээр судалгаа хийгдээд зайлиггүй шаардлагатай эмийн хүртээмж Монгол Улсад ердөө улсын хэмжээнд 53,6 хувь, хувийн байгууллагын хангамж 68,9 хувь, эмийн эргэлтийн сангийн хангамж 51,2-хон хувьтай байсан. Тийм учраас энэ тус судалгаанаас үзэхэд манай улс ДЭМБ-аас гаргасан зөвлөмжийн дагуу зайлиггүй шаардлагатай эмийн 80 хувийн хүртээмжтэй байлгах зорилгод хүрч чадахгүй байна. Ийм учраас мөн дөнгөж саяхан тайлангаа тавьсан Хүний эмийн чанар, хуурамч болон стандарт бус эмийн үйлдвэрлэл, нийлүүлэлтийн асуудлаарх Хянан шалгах түр хорооноос хүний эмийн

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 28-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

чанар, стандартыг шалгах явцад эмийн үнийн асуудлыг нарийвчлан судлах, зах зээл дээр худалдаалагдаж байгаа болон Эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт үзүүлэх зайлшгүй шаардлагатай эмийн үнийн өсөлтийн бодит шалтгаан нөхцөлийг харилцан уялдаатайгаар хяналт шалгалтыг цаашид үргэлжлүүлэн хийх шаардлагатай гэх дүгнэлтийг гаргасан. Үүнтэй уялдуулаад миний бие болон бас бусад 27 гишүүдтэй хамтраад эмийн чанар, үнэ, хяналт шалгалт хийх ийм түр хороо байгуулахаар хүсэлт гаргасны дагуу Байнгын хороогоор хэлэлцээд, дэмжигдээд Үндсэн хуульд харилцах зүйл байхгүй гэдэг ийм зүйл гарсан. Тэгэхээр энэ тогтоолыг та баталж өгөх жагсаалтад оруулж өгөхийг хүсэж байна.

2 дахь хүсэж байгаа зүйл бол энэ Боловсролын ерөнхий хуулийн асуудлаа бас бид энэ хаврын чуулганаараа хэлэлцээд дуусгачихмаар байна. Тийм учраас энэ хэлэлцэх асуудал дотор эцсийн хэлэлцүүлгийг хийж оруулж өгөхийг хүсэж байна.

Тэгээд энэ нийгэмд бас нэлээн том асуудал болоод байгаа англи хэлийг сургадаггүй, үзүүлдэггүй гэх нэртэй хэдэн гишүүд сурахыг хүсэж байгаа нэг хэдэн гишүүд гэсэн нэг ийм яриа нийгэмд талцал үүсгэж байгаа. Тэгвэл би бас энд хариуцлагатай хэлмээр байгаа юм. Өнөөдөр энэ хуулийг хэлэлцэх явцад, төслийг хэлэлцэх явцад энэ зааланд сууж байгаа нэг ч гишүүн англи хэлийг бага насанд сурахыг хориглож байгаа, хүсэхгүй байгаа нэг ч гишүүн байхгүй. Тийм учраас бид энэ хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгтээ ярилцмаар байна. Ер нь Зундуйн Дорж гуайн хэлсэн нэг айхтар үг байдаг шүү дээ. Ер нь Монголын баялаг бол хэл, хил, мал 3 гэж хэлсэн байдаг. Тэгэхээр бид Монгол хүнээ шинэ Монгол хүн бий болгох энэ том боловсролын ялгаатай, зөрөөтэй, алагчилдаг энэ тогтолцоог илүү чанартай, сайн болгох, хүүхдүүдэд

боловсролыг жигд олгох энэ тогтолцоог бий болгох энэ том шинэчлэлийн том бодлогыг оруулж ирсэн Засгийн газрын энэ төслийг дэмжээд ингээд энэ чуулганыхаа энэ үлдсэн хугацаандаа багтаад өнөөдөртөө бүүр хэлэлцэх асуудалдаа оруулж өгөөч гэж хүсэх гэсэн юм. Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Чинбүрэн гишүүн 2 асуудал тавилаа. Төрийн байгуулалтын юу Нийгмийн бодлогын байнгын хороо чинь энэ асуудлыг хэлэлцчихсэн үү. Хэлэлцээд дэмжчихсэн үү? Тэгвэл Даргын зөвлөл дээр хэлэлцээд маргааш хэлэлцэх асуудалд оруулчихъя. Өнөөдөр амжих нь уу? Хоёуланг нь зэрэг оруулж болохгүй байх.

2 дахь нь Боловсролын хууль. Ерөнхий хууль оруулчих юм уу. Энэ чинь тэгэхдээ байна шүү дээ, Тогтохсүрэн дарга аа. Би ч маргааш хөдөө явчихна бас, хэрвээ оруулах бол

Тэгвэл Чинбүрэн гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулъя, өнөөдөр оролцуулъя гэж. Харин Боловсролын хуулийг оруулчихъя гээд санал хураалт явуулчихъя. Горимын санал байхгүй. Энэ албан бичгээр 17 цагаас өмнө Чинбүрэн гишүүн л хэлэлцэх асуудалтай холбогдуулж үг ирүүлсэн. Тэр эмийн түр хорооны асуудал байна. Боловсролын хуулийг эхлээд хэлсэн. Тэгээд тэр хяналт шалгалтын түр хороо хэлсэн. Тэгээд Боловсролын хуулиа. Хоёуланг нь оруулах амжихгүй байх.

Боловсролын ерөнхий хуулийг Байнгын хорооны дарга нь оруулъя гэж байгаа юм байна, сайд оруулъя гэж байгаа юм байна. Маргааш чинь бас боловсролын нөгөө бас, 3 хууль байгаа шүү дээ. Яах вэ, шахуу явах нь зөв байх, тэгээд амжвал. 3 дээр оруулбал амжих л юм байна.

Баяр наадмын хуулиа маргааш өглөө л оруулахгүй бол горимын санал гаргасангүй л дээ.

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 28-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

Санал хураалт явуулъя, эхлээд. Боловсролын ерөнхий хуулийг нэмчих юм бол маргааши наадах чинь ингээд орчихно шүү дээ.

Боловсролын ерөнхий хуулийг хэлэлцэх асуудалд нэмье гэсэн горимын саналаар санал хураалт явуулъя. Анхны хэлэлцүүлгийг үргэлжлүүлнэ. Зургаахан санал хураалттай юм байна гэж сая хэлсэн.

Боловсролын ерөнхий хуулийг аваад ир дээ, энэ чинь эцсийн хэлэлцүүлэг үү? Тэгвэл энэ 7 хоногт хэлэлцэх асуудлаас ингээд хасагдах нь байна шүү дээ, тийм ээ. Ирэх 7 хоногт болох уу, хасах юм уу.

Энэ нөгөө эхний санал хураалт хийсэн болохоор энэ төхөөрөмжийнхөө бүрэн бүтэн. Энэ Гомпилдоогийн Мөнхцэцэг гишүүн, Жигжидсүрэнгийн Чинбүрэн гишүүн, Лувсанцэрэнгийн Энх-Амгалан гишүүдийн микрофон ажиллаагүй горимын санал өгсөн. Нэг нь төлөөлөд хэлчих. Гомпилдоогийн Мөнхцэцэг гишүүн.

Г.Мөнхцэцэг: Сая Боловсролын ерөнхий хуулийн эцсийн хэлэлцүүлгийг хийе гэдэг дээр, санал хураалт дээр миний кноп ажиллаагүй учраас, тоног төхөөрөмж ажиллаагүй учраас энэ саналыг дахин хураалгаж өгнө үү гэж хүсэж байна.

Г.Занданшатар: Хүчингүйд тооцож өгнө үү гэж. Гишүүд анхааралтай байгаарай. Ингээд Гомпилдоогийн Мөнхцэцэг гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулъя. Санал хураалт.

60,5 хувийн саналаар санал дэмжигдлээ. Гомпилдоогийн Мөнхцэцэг гишүүний гаргасан горимын санал дэмжигдсэн учраас санал хураалтыг дахин хураая. Эцсийн хэлэлцүүлэг юм байна. Би эхний хэлэлцүүлэг гэж бодоод. Санал хураалт, анхаараарай.

Санал хураалт. 58,1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Тэгээд хэлэлцэх асуудлын 3-д гэсэн тийм ээ, 3-д Чинбүрэн гишүүн 3-д гэж хэлсэн үү. 3-д оруулах санал нь дэмжигдлээ.

Ингээд хэлэлцэх асуудалдаа оръё.

1-д “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Дамдины Цогтбаатар танилцуулна.

Д.Цогтбаатар: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурал 2023 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаараа хэлэлцэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлсэн.

Байнгын хороо 2023 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуралдаанаараа тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явууллаа. Тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир, Ш.Раднаасэд нар тогтоолын төсөл болон зарчмын зөрөөтэй саналын томъёололтой холбогдуулан асуулт асууж, хариулт авсан болно.

Хууль зүйн байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан саналуудыг нэг бүрчлэн хэлэлцэж, дараах санал, дүгнэлтийг

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 28-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

нэгдсэн хуралдаанд танилцуулж байна.
Үүнд:

Монгол Улсын Засгийн газар Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2023 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор батлах.

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг жил бүрийн улсын төсөвт тусгаж батлуулах.

Нийтийн албан тушаалтан I сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 250 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх буюу түүнээс дээш хэмжээний зарлагыг мэдүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх.

Монгол Улсын Үндсэн хууль болон олон улсын гэрээнд заасан албан тушаалтнуудаас бусад хуулиар тогтоосон албан тушаалын халдашгүй байдлын хүрээг хязгаарлах.

Авлигын гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийн хувьд ноогдох хөрөнгийг хураах, нэмэгдэл ялын төрөл бий болгох асуудлыг судалж, санал боловсруулахаар тогтоолын төслийн хавсралтад тусгах.

Түүнчлэн Улсын Их Хурлын гишүүн хууль тогтоох төрийн дотоод, гадаад бодлогын үндсийг тодорхойлох, хууль тогтоомжийн биелэлтийг хянан шалгах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэхээс бусад тохиолдолд төрийн байгууллагын үйл ажиллагаанд оролцохыг хориглож, хэрэгжилтийг хангана гэж заасныг төслөөс хасах зэрэг зарчмын зөрөөтэй саналыг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүд дэмжсэн.

“Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрөөтэй саналыг та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрөөтэй саналыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу? Өнөрболор гишүүнээр тасаллаа. Ганзоригийн Тэмүүлэн гишүүнээр тасаллаа. Дамдинсүрэнгийн Өнөрболор гишүүн. Асуулт асуулт асуухын өмнө түр байж байгаарай.

Ажлын хэсгийг танилцуулчихъя.

Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Пүрэвжавын Сайнзориг, Монголбанкны Удирдлага төлөвлөлтийн газрын Мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх асуудал хариуцсан ахлах референт Базаргүрийн Гантуяа, Авлигатай тэмцэх газрын Тамгын хэлтсийн дарга, эрхэлсэн комиссар Загараагийн Баасанням, Авлигатай тэмцэх газрын Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн ажлын албаны дарга, эрхэлсэн комиссар Доржсүрэнгийн Дуламсүрэн, Авлигатай тэмцэх газрын Судалгаа, шинжилгээний албаны дарга, эрхэлсэн комиссар Цэдэнишийн Шинэбаяр, Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтсийн 3 дугаар албаны дарга, ахлах комиссар Чимэддоржийн Жаргалбаатар, Авлигатай тэмцэх газрын Хяналт шалгалт дүн шинжилгээний хэлтсийн Мэдүүлгийн бүрдүүлэлт, дүн шинжилгээний албаны дарга, ахлах комиссар Батмөнхийн Баярсайхан, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын ахлах шинжээч Шагдарсүрэнгийн Цолмон, Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого төлөвлөлтийн газрын Хөгжлийн загвар шинэтгэлийн хэлтсийн

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 28-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

ахлах шинжээч Хорлоогийн Оюунцэцэг, Авлигатай тэмцэх газрын судалгаа шинжилгээний албаны ажилтан, комиссар Лхагважавын Хангарди.

Дамдинсүрэнгийн Өнөрболор гишүүн асуулт асууна.

Д.Өнөрболор: Гишүүдийнхээ энэ өдрийн мэндийг хүргэе. Авлигын эсрэг үндэсний хөтөлбөрийг бид нар хэлэлцэж байна. Монгол Улсын ер нь урагшлах эсэх нь энэ авлигыг бид нар цэгцэлж чадах уу, эс цэгцэлж чадах уу гэдэгтэй шууд хамааралтай. Тэгээд манай улс төрчид энэ эрх баригчид энэ асуудлыг үргэлж ярьсаар ирсэн хэр нь яг бодитоор тийм ээ, өнөөдөр урагшлахгүй байгаа. Тэгээд энэ авлигын индексээр ухралттай байгааг олон улсын байгууллагууд тайлан дүгнэлтээ байнга бид нарт сануулж байгаа.

Тэгээд Улсын Их Хурал энэ асуудал дээр орж ирэх үед нь бас нэлээдгүй ингээд л ярьчихаад л тэгээд л мартчихдаг. Асуудал үүсэхэд нь гал унтраах төдийгөөр аргалсаар. Ингээд авлигын энэ намагтаа өнөөдөр бид нар шигдсэн хэвээрээ байна. Үүнийг бас юутай холбоотой вэ гээд ингээд аваад үзэхээр төрийн байгууллагын чадамж, тэдний албан хаагчдын эрх, үүргийн чадамжаас бас тодорхой хэмжээгээр хайх ёстой гэж бас энэ судалгаанаас харж болно. Тухайлах юм бол энэ 22 оны хэрэгжилтийн тайлангаас харахад хамгийн шударга байх ёстой, авлигыг илрүүлэх ёстой хяналтын байгууллагууд нь хамгийн шударга бус гэсэн үнэлгээг удаа дараа авсан байгааг бид нар энэ тайлангаас харж болно. 12 оноос хойш энэ төрийн байгууллагуудын 8 удаагийн шударга байдлын үнэлгээгээр харахаар гааль, мэргэжлийн хяналтын байгууллага 5 удаа, Ашигт малтмал, газрын тосны газар, Биеийн тамир, спортын улсын хороо 4 удаа, энэ цагдаагийн болон татварын байгууллага 3 удаа хамгийн сүүлийн байрт бичигдсэн байна.

Эндээс эрсдэлийг шууд харж болно. Нэн ялангуяа энэ нүүрсний гэх асуудалтай шууд холбогдохоор харагдаж байгаа энэ хяналтын байгууллагууд, мэргэжлийн хяналт, гааль, татвар, цагдаа гээд тийм ээ, энэ байгууллагууд бол ард түмний баялаг энэ нийтийн өмчид тавих хяналт ер нь ямар байгааг энэ байгууллагуудын энэ үнэлэлт, дүгнэлтээс харж болох юм. Тийм учраас энэ эрсдэлд тооцдог ер нь арга механизм гэж ер нь байна уу? Энэ байгууллагуудад ер нь авлигын эсрэг бууруулах ер нь яг ямар бодитой арга хэмжээ авах ёстой вэ. Энэ дээр ямар бодлого төлөвлөгөөтэй байгаа вэ гэдгийг асууя.

Дараа нь энэ Монгол Улсын хууль, хүчнийхэн, шүүх, прокурорын авлигын асуудалгүй гэсэн одоо үнэмлэхүй энэ дүгнэлт гарсны дараа л авлигын асуудал нэг мөр шийдэгдэх эхлэл тавигдана гэж хаа хаагүй ард түмэн, нийгэм тэр чигээрээ л шүүмжилж байна. Тэгээд салбарынхан ч бас ярьж байна. Тэгээд ер нь юм мэддэг улсууд энэ Прокурорын дэргэдэх мөрдөн байцаах алба, энэ хууль хүчнийхнийг хянадаг мөрддөг албаа устгаад бас их олон жил болж байна. Тэгээд энэ байгууллагыг сэргээх, энэ дээр шинэ дархлаа үүсгэх, хууль хүчнийхээ байгууллагын улсуудыг цэвэршүүлэх тийм ээ, энэ нийгмээ эрүүлжүүлэх энэ бодитой алхмыг ер нь хийх юм уу, үгүй юм уу гэдэг асуудлыг ард түмэн бас хариултыг нэхэж байгаа ийм асуудал байна.

Дараагийн нэг асуудал энэ ... /минут дуусав/

Г.Занданшатар: Эхлээд зочид танилцуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Жигжидийн Батжаргал, Нямаагийн Энхболд, Цэвэгдоржийн Туваан нарын урилгаар Төв аймгийн Жаргалант сумын тариалан эрхлэгч залуучуудын төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Тариаланч залуучууддаа үр тариа нь арвин байж,

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 28-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

ургац арвин байхын өлзийтэй ерөөлийг өргөн дэвшүүлээд, хамгийн сайн сайхан бүхнийг Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс хүсэн ерөөе.

Асуултад Байнгын хорооны дарга Баттөмөрийн Энхбаяр хариулна.

Б.Энхбаяр: Өнөрболор гишүүний асуултад хариулъя. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр 2030 он хүртэлх ирэх 7 жилийн хугацаанд Улсын Их Хурал, Засгийн газар, мөрдөх алба, иргэний нийгмийн байгууллагуудын хүрээнд авлигаас урьдчилан сэргийлэх, энэ төрлийн эвлэрэхгүй байх эрх зүйн орчин хийгээд нийт иргэдийн хүрээнд ямар ажлууд хийгдэх вэ гэдэг цогц ерөнхий стратеги байгаа юм. Энэ стратеги маань 9 дэд салбарын хүрээнд нэлээн удаан хугацаанд Авлигатай тэмцэх газраас санаачлаад Засгийн газрын бүх яамдын төлөөлөл орсон 40 хүний бүрэлдэхүүнтэй, иргэний нийгмийн байгууллагууд орсон олон улсын хөндлөнгийн эксперт зөвлөгөө орсон. Нэлээн ийм сайн цогц бодлогын баримт бичиг байгаа. Энд таны хөндсөн асуудлууд бүгд орсон. Ер нь энэ өмнөх хөтөлбөрүүд бол үр дүнгээ өгсөн, хэрэгжилтийн биелэлтийг гаргаж ирэхэд бас нэлээн үр дүн өгсөн байна аа гэдэг ийм дүгнэлт гарч ирж байгаа. Энэ ганцхан мөрдөх байгууллагуудын үр дүнгээр хэчнээн хэрэг шүүхээр ял шийтгэдэг вэ гэдгээр үр дүн нь хэмжигддэг ийм хөтөлбөр биш, ийм хөтөлбөр биш. Ер нь сүүлийн жилүүд Улсын Их Хурал ч тэр, Засгийн газар ер нь хууль хяналтын байгууллага энэ олон 20 гаруй жилийн хугацаанд бугширсан асуудлуудыг ил болгож, мэдээллийн ил тод байдлыг хангаж, ингэж хууль, шүүхээр эхнээсээ хүмүүс нь ял шийтгэлээ авч, парламентын хүрээнд ард иргэдийнхээ оролцоотойгоор нээлттэй ийм сонсох урьд хожид хийгдэж байгаагүй сонсголуд хийгдэж илчлэгдэж байгаа. Иргэд олон нийт бухимдалтай байгаа. Тэгэхдээ энэ сайн талд муу зүйлд ч гэсэн сайн тал байдаг. Урьд нь ер нь хэзээ энэ

асуудлуудыг ингэж ил тод ард иргэдээрээ Улсын Их Хурал, Засгийн газар, хууль хяналтын байгууллагатайгаа хамт нэг зүгт харж ярьдаг байсан юм. Урьд нь ерөөсөө ийм хүмүүс зүгээр хоорондоо ярьдаг болохоос биш энэ бүх асуудал мэддэггүй байсан. Одоо бол мэддэг болсон, илчлэгддэг болсон. Мөн хуулийн цээрлэл үзүүлэгддэг болсон.

Сүүлийн 4, 5 жилийн хугацаанд гэхэд энэ Авлигатай тэмцэх газрын илрүүлж байгаа хэргийн тоо, шалгаж байгаа хэргийн тоо, цар хүрээ, мөн улсад хохирсон хохирлын барагдуулалт их наядаар хэмжигддэг болсон. Өөрөөр хэлбэл илрүүлэлт сайжирч байна, эрх зүйн орчин энэ дээр эффект өгч байна, улс төрийн бодитой дэмжлэг байгаа гэдэг энэ манлайлал бол хүчтэй харагдаж байгаа. Тийм учраас энэ асуудлуудаа бид нар эрх зүйн орчны хүрээнд ч гэсэн өнгөрсөн онд Улсын Их Хурал бүр хээл хахууль авсан, улс төрд нөлөө бүхий этгээдийг бүх насаар нь хорих ял шийтгэнэ гэдэг хамгийн дээд Эрүүгийн хуульд байгаа ял шийтгэлийн бодлогоо хүртэл Улсын Их Хурал баталж, Монгол Улсын парламент бол авлигын гэмт хэрэгтэй эвлэрэхгүй байх энэ улс төрийн манлайллаа бас үзүүлж явж байгаа.

Одоо бас Хөгжлийн банкны сонсгол, Улсын Их Хурлын парламентын хяналтын сонсголуд хийгдсэн. Одоо бас нүүрсний хулгайтай холбоотой сонсгол нээлттэй сонсгол хийгдэнэ. Энд нэг зүйл харагдаж байгаа. Ажлын хэсэг гарсан. Нээлттэй сонсгол хийх чиглэлээр ажлын хэсгийн дүгнэлт гарсан. Энэ намар хийнэ, энэ намар хийнэ.

Ардчилсан намын бүлгийн саналын дагуу өчигдөр Монгол Ардын намын бүлгийн гишүүд дэмжээд ковидын үеийн төсөвтэй холбоотой хяналтын сонсгол хийе гэдэг мөн шийдвэр тогтоол өчигдөр гаргасан.

Г.Занданшатар: Төмөртоогоогийн Энхтүвшин гишүүн.

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 28-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

Т.Энхтүвшин: Баярлалаа. Энэ авлигатай тэмцэнэ гэдэг бол ганц Авлигатай тэмцэх газрын хийх ажил биш л дээ. Ерөөсөө л бүх нийтээрээ л энэ авлигатай тэмцэх ёстой. Тэгээд энэ Авлигатай тэмцэх газрын энэ судалгааг хараад үзэхэд ер нь жилийн жилд л юу гэдэг юм, энэ улс төрийн албан тушаалтан болон эрх бүхий албан тушаалтны энэ авлигад оролцсон тоо хэмжээ нэмэгдсэн байна. Хэрэгт орсон. Тухайлбал 2021 онд 96,2 тэрбум төгрөгийг нөхөн төлүүлсэн бол 2022 онд 2,4 их наядыг л төлүүлсэн байна шүү дээ. Тэгэхээр жилээс жилд энэ авлигын хэрэг нэмэгдэж байна гэж миний хувьд харж байна. Тэгэхээр бид нар хамгийн гол нь хөтөлбөр гаргадаг, маш олон хөтөлбөрийг гаргаж байсан. Хөтөлбөр маань голдуу ингээд тунхгийн чанартай, хөрөнгө мөнгийг нь тавьж өгдөггүй, иймэрхүү байдалтай л бусад хөтөлбөрүүд бас гараад явж байсан. Тийм учраас энэ Авлигатай тэмцэх газрын үндэсний хөтөлбөрийг баталж байгаа юм чинь бид энэ хүний нөөцийн асуудал, ялангуяа энэ төсөвт хөрөнгө, төсвийн асуудлыг нь давхар шийдээд явах хэрэгтэй. Жил болгоны төсөвт энэ авлигатай тэмцэхэд хэдэн төгрөг хэрэгтэй байгаа юм, тэрийг нь суулгаж өгдөг. Хэдий хэрийн хүн хүчний нөөц хэрэгтэй байгаа юм. Тэрийг нь бас бэлдэж өгдөг. Энэ асуудлыг шийдэж байж л энэ хөтөлбөр бас хэрэгжээд явахад бас нэлээн их амжилт олох болов уу л гэсэн ийм бодолтой байж байна.

Тэгээд сүүлийн жилүүдэд яах вэ, үндсэндээ нэг нууцын гэрээ гээд бүх юмаа л нуудаг болсон л доо. Одоо бол бүх юмыг ил болгох хэрэгтэй. Ялангуяа энэ батлан хамгаалахтай холбоотой материаллаг баазыг л юу гэдэг юм нууцын зэрэглэлтэй байлгаад бусад нууцын зэрэглэлтэй байгаа бүх юмыгаа ил болгож байж л бид цаашидаа энэ авлигатай тэмцэнэ гэж миний хувьд харж байгаа юм.

Тэгээд Улс төрийн намуудын хууль байна. Улс төрчдийн ёс зүйн асуудал

байж байна. Улс төрийн намуудын санхүүжилтийн асуудлыг ч гэсэн ил тод, үүнийг шалгах энэ эрх зүйн орчныг ч гэсэн үүгээр бас нээж өгч байгаа байх гэж миний хувьд бас бодож байна.

Тийм учраас энэ “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг миний бие дэмжиж байна. Тэгээд хөрөнгө мөнгөтэй холбоотой асуудал, хүний нөөцтэй холбоотой асуудал, цаашидаа энэ хөтөлбөр батлагдаад явбал жил жилийн төсөвт суулгаад явах ийм бололцоо боломж байгаа юу гэж энэ ийм асуултыг тавьж байна.

Г.Занданшатар: Баттөмөрийн Энхбаяр Хууль зүйн байнгын хорооны дарга.

Б.Энхбаяр: Хөтөлбөрийн онцлог бол хөтөлбөр хэрэгждэг байх ёстой, тунхаг бичиг. Тийм учраас Энхтүвшин гишүүний хэлж байгаа төсөв хөрөнгийнх нь асуудлыг нь шийдэх, хүн хүчнийх нь асуудлыг нь шийдэх, хэрэгжих боломжтой байдлаар хөтөлбөрийг батлах учиртай. Тийм ч учраас энэ бол ганцхан Улсын Их Хурал, Байнгын хороо, ажлын хэсэг яриад бас шийдэх бололцоогүй. Тийм учраас энэ хөтөлбөрийг батлаад, баталж байгаа тогтоолдоо бид ямар заалт ер нь оруулах гэж байна вэ гэхээр хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг төсөв, хуваарь, хэрэгжилт, хэрэгжилтийг тооцох үр дүнгийн хэмжүүртэйг нь хамт Засгийн газар төсвийнх нь тооцоог хийгээд Эдийн засгийн хөгжлийн яамаар хянуулаад оруулж ир гэдэг даалгавар Засгийн газарт өгөх гэж байгаа. Бидний урьдчилсан тооцоогоор энэ 7 жилийн хугацаанд авлигатай тэмцэх энэ хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд 30 гаруй тэрбум төгрөг шаардлагатай гэдэг тооцоо гарсан. Яг шууд хүн хүчний хувьд мэдээж ер нь яг тодорхой төрлийн гэмт хэргийг хянан шийдэх ялангуяа авлигын төрлийн гэмт

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 28-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

хэргийг шалгахад Авлигатай тэмцэх газрын хүн хүч хүрэлцэхгүй болж байгаа зүйл байгаа. Ялангуяа сүүлийн үеийн том хэргүүд дээр хүн хүч хүрэлцэхгүй байгаа. Тийм ч учраас хөтөлбөрийг хэрэгжүүлэх тогтоол дээр бас Авлигатай тэмцэх газрын энэ хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд бас энэ ажлын алба, хүн хүчнийх нь хувьд анхаарсан ийм тогтоолын төслийг дагуулж оруулж ирж байгаа. Тэгэхээр энэ тогтоолыг бас гишүүд маань дэмжиж өгөхийг бас хүсье.

Г.Занданшатар: Жигжидийн Батжаргал гишүүн.

Ж.Батжаргал: Баярлалаа. Байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрөөтэй саналуудаас тодруулах зүйлүүд байгаад байгаа юм. Бид энэ Улс төрийн намын тухай хууль, Сонгуулийн хууль энэ тэрдээ нийгмийн бүлэг, давхаргууд, сегментүүдийн оролцоог хангана, тэдний төлөөллийг хангана гээд яриад байх. Тэгээд янз бүрийн хөтөлбөр юман дээрээ болохоор зэрэг санал гаргах, хууль санаачлах эрхийг нь хязгаарлана гээд байх. Уг нь бол юм мэддэг улсуудаар нь уг салбарын юмыг шийдүүлье л гэж л ярьцаасан. Тэгж л одоо ерөнхий төсөөлөл буусан гэж хардаг. Тэгээд таны юу Байнгын хорооны оруулж ирж байгаа 4 дүгээр саналын томъёолол буюу 1.5.2 энэ тэр чинь их тийм сонин заалт болж байгаа байхгүй юу. Ер нь энэ балансыг ер нь яаж хангаж, яаж зөв зохицуулж явах ёстой юм бэ? Үүнийг ер нь нэг талд нь нэг мөр болгож ойлгохгүй бол энэ зөрөөтэй нэг тийм ойлголт л яваад байх болчихлоо. Сүүлийн үед.

2 дахь зүйл. Төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн байгууллагуудын талаар зохицуулсан харилцаанууд энэ юун дотор орж ирсэн байгаад байгаа юм. Тэгээд түүн дотор тэр ил тод байдлыг нь хангах асуудал, үйл ажиллагаа санхүү 2 дээрээ хоёуланд нь 1, 2 дугаарт тэр олон нийтийн оролцоо хяналтыг хангах зохицуулалтынх нь

асуудал. Тэгээд залгуулаад ерөөсөө энэ татварын дараах ашиг хуваарилалтын асуудлыг нь тодорхой болгохгүй бол энэ төрийн өмчтэй компаниуд гэдэг юм уу, тэрний ТУЗ-ууд дэндүү дур зоргоороо авирлаж байгаа. Жаал ашиг гаргачхаад тэгээд хувьцаа эзэмшигч нарт хувьцааны ноогдол ашиг олгохгүй гээд дуугарч байгаа явдал бол дэндүү бүдүүлэгдэж байгаагийн үйл хэрэг. Тийм учраас үүнийг эрх зүйн хувьд нь зөв тодорхой болгож өгөх ёстой. Ингэж байж хүмүүс энэ төрийн болон орон нутгийн өмчтэй компанийн хувьцаа тавих анхаарал, түүний оролцоо, хяналт нэмэгдэж, үр өгөөж дээшлэх түүгээр дамжиж ашиг нэмэгдэх бололцоо бүрдэх ёстой. Энэ өнөөдөр эрх зүйн хувьд бүдэг байгаатай холбогдоод оролцоогүй олон нийтийн засаглал үүсчхээд байгаа юм. Үүн дээр ямар бодлого санал байна вэ гэдэг асуудал.

3 дахь асуудал. Манай энэ авлигатай тэмцэх байгууллагуудынхаа чиг үүргийг нэмэгдүүлэх тухай асуудал байгаад байгаа юм. Орон нутагт салбарын тухай ярьж байгаа юм, хэдүүлээ, тусгайлсан төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр нэгжүүд байгуулах тухай ярьж байгаа юм. Зөв байж магадгүй. Гэхдээ үүний одоо цаад бодит боломж, чадамжийнх нь тухай асуудал. Энэ юмнуудыг ер нь ямархуу байдлаар тогтоож судалсан бэ гэдэг нэг асуудал байна.

2 дугаарт, ерөөсөө энэ хууль хяналтын байгууллагуудынхаа үйл ажиллагаанд өөрт нь тавьдаг хяналт тэр тусгай мөрдөлтийн үйл ажиллагааг нь яаж зохицуулах юм бэ? Үүнийг нийгэм нэлээн их анзаарч харж байгаа шүү. Үүн дээр хэдүүлээ ямар гаргалгаа юм хийх ёстой юм бэ. Нэг ийм хэдэн зүйл дээр тодорхой хариулт авчихъя гэж.

Г.Занданшатар: Баттөмөрийн Энхбаяр Хууль зүйн байнгын хорооны дарга.

Б.Энхбаяр: Батжаргал гишүүний асуултад хариулъя. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн тэр 1.5.2-ыг дээр тодруулж асууж байна. Төслийн орж ирсэн заалт нь бол ийм заалт байгаа юм. Улсын Их Хурлын гишүүний өгсөн саналыг батлагдсан бодлого шийдвэртэй уялдуулж хянах хариуцлагын тогтолцоог бүрдүүлнэ гээд байгаа юм. Тэгээд энэ бол Үндсэн хуультай зөрчилдөөд байна. Их Хурлын гишүүний яах вэ, ямар хууль дээр ямар санал өгснөөр нь хянаад тэгээд 1 хариуцлага тооцох ч юм шиг ийм болохгүй заалт болчхоод байгаа юм. Энэ бол Үндсэн хуультай нийцэхгүй гэж үзэж байгаа, ард түмний мандат.

Тийм учраас энэ заалтыг өөрчилсөн юм. Өөрчилж оруулж ирж байгаа хувилбар нь юу вэ гэхээр бид ийм байдлаар өөрчилъе. Улсын Их Хурлын гишүүн өөрөө эцсийн өмчлөгч эсхүл нөлөө бүхий хувьцаа эзэмшиж байгаа хуулийн этгээдийн явуулж байгаа аж ахуйн үйл ажиллагаатай холбогдох хууль тогтоомжийн төсөл санаачлах, санал гаргахыг хязгаарласан эрх зүйн орчныг бүрдүүлье гэдэг агуулгаар өөрчилж байгаа юм. Өөрчлөх саналтай байгаа юм. Улсын Их Хурлын гишүүд бол ямар нэгэн байдлаар ерөөсөө аж ахуйн үйл ажиллагаатай холбоотой санал гаргаж болохгүй гэж бичиж мэдээж аргагүй. Төсвийн хууль гэхэд л бүх ААН, хувийн хэвшлийн үйл ажиллагаатай холбогдоно. Зүгээр ингээд жишигээр хувийн сургуультай гишүүд Боловсролын хууль дээр өөрийнхөө сургуулийн эрх ашгийн үүднээс хууль санаачлаад санал гаргаад байж болохгүй л гэж үзэж байгаа юм. Хувийн шатахуун колонкийн бизнестэй гишүүд ийм шатахууны импортын бизнестэй холбоотой асуудлаар хууль санаачлаад, санал гаргаад байж болохгүй л гэж байгаа юм. Өөрсдөө гүйгээд байж болохгүй гэж байгаа юм. Газар тариалангийн бизнес эрхэлдэг гишүүн газар тариалангийн бизнест татвараас татаас өгөх, татварыг хөнгөлөх хууль санаачлаад өөрөө гүйгээд байж болохгүй л гэж байгаа юм. Ийм жишиг рүү оръё

гэдэг ийм санаачилгыг гаргаж байгаа юм. Эрчим хүчин дээр ч гэсэн эрчим хүчний бизнестэй гишүүд эрчим хүчний ийм бизнес дээр татварын хөнгөлөлт үзүүлэх ийм хууль санаачлах санаачилга гаргаад санал гаргаад яваад байж болохгүй л гэж байгаа юм.

Тийм учраас энэ өөрсдөөсөө эхэлье гэдэг ийм санаачилгыг Байнгын хороо оруулж ирж, одоо санал хураалгах гэж байгаа агуулга энэ байгаа юм. Хэрвээ энэ санал дэмжигдэхгүй бол хуучнаараа бүр ийм утгагүй Их Хурлын гишүүний гаргасан саналынх нь дээрээ хянаж хариуцлага тооцно гэдэг ийм I ерөнхий юу нь мэдэгдэхгүй, Үндсэн хуультай нийцэхгүй ийм томъёолол үлдэх гээд байгаа юм.

Прокурорын мөрдөнгийн хувьд Эрүүгийн юу, ХЭҮК-ын 23 оны, 22 оны тайлан хэлэлцэсэнтэй холбоотой Улсын Их Хурал тогтоол гаргасан. Энэ дээр тодорхой заалт орсон. Тусгай субъектүүд буюу хууль хяналтын байгууллагуудаас эрүүдэн шүүсэн асуудлыг хянах бие даасан нэгж байгуулах шаардлага байна гэдэг асуудлаар Улсын Их Хурлын тогтоол гарсан. Эрүүдэн шүүж байгаа асуудлаар. Тийм. Тийм учраас Улсын Их Хурал бас энэ дээр бас өөрийнхөө бодлогыг тодорхойлоод бие даасан эрүүдэн шүүсэн асуудал дээр энэ бие даасан хяналтын тогтолцоо байх ёстой гэдгээр явж байгаа.

Ер нь Засгийн газар мөрдөх албаны тогтолцоог боловсронгуй болгох тэр дотроо үүнтэй холбоотойгоор прокурорын хяналтын асуудлыг миний ойлгож байгаагаар бол Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн төслийг боловсруулж байгаа юм байна лээ, Засгийн газар дээр. Энэ дээр яаж орж ирэхийг би мэдэхгүй байна. Урьдчилсан байдлаар боловсруулж байгаа төсөл дээр нь урьдчилсан байр суурь илэрхийлэх нь бас боломжгүй, зохимжгүй байгаад байгаа гэдгийг та бас ойлгож хүлээж авахыг хүсье.

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 28-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

Авлигын гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийн хувьд ноогдох хөрөнгийг хураах, хөрөнгийг нь хураах, хувьд ноогдох хөрөнгийг нь хураах, нэмэгдэл ял бий болгох асуудлыг судалж, санал боловсруулъя гэдэг ийм бас саналыг оруулж байгаа юм. Тэгэхгүй бол тэгээд баахан баяжчихсан, зүгээр торгуулаад салчихдаг, яг хувьд ноогдох нөгөө нэг орлогуудыг ... /минут дуусав/

Г.Занданшатар: Жигжидийн Батжаргал гишүүн тодруулж асууна.

Ж.Батжаргал: Тийм ээ, би бол ойлгохын хувьд ойлгоод байгаа юм. Тэгээд харин бид нарын бариад байгаа бодлого 2 салаатай болчихоод болж өгөхгүй байгаа байхгүй юу. Тодорхой бүлэг давхаргуудын төлөөллийг оруулж ирье. Юм мэддэг улсаар нь салбарынх нь эрх зүйн зохицуулалт юмыг илүү боловсронгуй болгоё гэдэг юм яваад байгаа байхгүй юу. Тэгсэн хэр нь нөгөө талдаа өөрийнх нь үйл ажиллагаа, чиглэлтэй холбоотой асуудлыг нь тэр нөхдөөр хууль ч санаачлуулахгүй, санал ч гаргуулахгүй гэж хэлж байгаа байхгүй юу. Тэгэхээр ямар юмных нь өнөө мэргэжлийн ур чадвар ашиглах юм чинь орж ирж чадах юм бэ. Тэгэхээр үүнийг хэдүүлээ ер нь яаж балансжилтыг нь зөв олох юм бэ гэдэг л асуудал бий болчихоод байна л даа. Энэ талаасаа нэг ямархуу байдалтай юм гэж.

2 дахь зүйл. Яах аргагүй одоо авлигын юу гэдэг юм эрсдэлийнхээ үнэлгээ гэдэг юм уу энэ юмаар энэ цаг үед энэ төрийн ... /минут дуусав/

Г.Занданшатар: Баттөмөрийн Энхбаяр Хууль зүйн байнгын хорооны дарга.

Б.Энхбаяр: Төрийн өмчийн компаниудын хувьд Батжаргал гишүүн бид санал нэг байгаа. Ажлын хэсгийн хүрээнд Улсын Их Хурлаас Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль. Төрийн онолын орон нутгийн өмчит компанийн тухай хуулийн ажлын хэсэг байгуулагдсан. Миний бие өөрөө үүнийг

ахалж ажиллаж байгаа. Батжаргал гишүүн бас энэ дээр бас манлайлж ажиллаж байгаа.

Улсын Их Хурлын энэ оны намрын чуулганаар өмчийн болон компанийн багц хууль батлагдана. Ажлын хэсэг намар гэхэд бүх саналын томьёолол юмнуудаа бэлтгэхээр төлөвлөгөөгөө гаргаж ажиллаж байгаа. Энэ хүрээнд таны асуудал шийдэгдэнэ.

Мөн энэ авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр дээр Байнгын хорооноос бас ийм саналын томьёолол шинээр оруулах санал гаргаж байгаа. Санал хураалтын 25-д байгаа. ДНБ-д эзлэх төсвийн зарлага төрийн оролцоог үе шаттай бууруулж төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийг шинээр байгуулахыг хязгаарлана гэдэг ийм санал оруулж ирж байгаа юм. Энэ тодорхой санал оруулж ирж байгаа юм. Шинээр байгуулахгүй гэдэг ийм Улсын Их Хурлын шийдвэр гаргуулах гэж байна.

Г.Занданшатар: Дашдондогийн Ганбат гишүүн.

Д.Ганбат: Энэ бас л нэг ээлжит хөтөлбөр баталъя гэсэн л ийм л юм явж байна л даа. Энэ авлига үнэхээр асуудал болсон. Авлига зүгээр байдаг л юм болчихсон шүү дээ, ийм л байгаа. Тэгээд энэ хөтөлбөр нь үр дүнтэй байх уу, яах вэ гэдэг ийм асуудал байна.

Уул нь авлигатай тэмцвэл болдог л доо. Намайг Хууль зүйн байнгын хорооны дарга 2014, 2015 онд байхад бол Монгол Улс авлигын индексээр 72-т орж ирж байсан, одоо хэдэд байгаа билээ, 119-д байна уу, 118-д байна уу, тийм л байгаа байх. Цаашидаа ч нэмэгдэх байх. Энэ нэг нам олонх болоод 62, 65 суудалтай болоод сүүлийн 8 жил авлига гаарсан. Өнөөдөр энэ төрөөс төрж байгаа тэрбумтнууд бүр төрөлжчихсэн шүү дээ. Гаалиас гарч байгаа тэрбумтан, бас сангуудаас гарч байгаа тэрбумтан. Ийм л байгаа.

Дээр үед ярьдаг байсан. Чингис хааны үед Евро Азид тийм сайхан амар амгалан тогтжээ. Дүүрэн алттай илжиг унасан эмэгтэй хүн 18 настай тайван зорчиж, Европоос Ази хүртэл явж болохоор тийм тайван байдаг байсан. Гэтэл өнөөдөр эсрэгээрээ. Сангаас төрсөн энэ төрийн сангуудаас төрсөн шүү дээ. Тэр тэрбумтны хүүхэд гэр бүлээс гарсан хүүхэд бол дүүрэн мөнгө ачсан жийпэнд суугаад сайд ч болж болж байна шүү дээ. Ийм л орчинд бид нар аж төрж амьдарч байна. Өнөөдөр энэ намууд тэр дотроо эрх барьж байгаа нам, МАН энэ авлигач гэдэг үг бол бараг ард түмний хувьд адилхан болчихсон, ийм л байгаа. Нэг л юмыг хийчихвэл болно шүү дээ. Та нар хийхийг хүсэл алга. Ганцхан хуульд ганцхан өгүүлбэр оруулчихвал энэ авлига багасна. Ямар өгүүлбэр вэ гэхээр, авлига авсан, өгсөн 2-ыг хоёуланг нь шийтгэдэг биш, авлига өгснийг нь шийтгэдэггүй л байх хэрэгтэй. Аргагүй байдалд орж авлига өгсөн хүнийг шийтгэдэггүй болчихвол энэ авлига чинь бүгдээрээ ирж гарна. Ганцхан энэ заалтыг л оруулчих. Янз бүрийн тэр олон цаас энээ тэрээ юм хэрэггүй. Ийм юм оруулах хүсэлгүй байгаа байхгүй юу. Тийм мөртөө авлигатай тэмцэж байна, авлигын нөхцөл байдал сайжирна гэж бодох хэрэг байхгүй.

Энэ авлигын нөхцөл, энэ авлигажсан байдлаас чинь болж энэ Монгол Улс орноос залуучууд дайжиж байна. Ямар ч ирээдүйдээ итгэх итгэл алга байна. Зүгээр л амаараа удахгүй сонгууль болох гэж байгаа учраас ганц жил үлдсэн. Одоо нэг авлигатай тэмцээд байгаа юм шиг хэлбэр эсгэж байна. Ер нь нэр цэвэр, янз бүрийн хулгай, ЖДҮ, Хөгжлийн банк энэ юманд холбогдоогүй нь улс төрийн албан тушаалтан цөөхөн байна шүү дээ. Тухайлбал над шиг, би өөрөө нэр цэвэр болохоороо энэ дотор ингээж хэлж чадаж байгаа, ингээж ярьж чадаж байгаа. Тэр попорсон, янз бүрийн юманд холбогдсон улсууд ярьж чадахгүй байгаа шүү дээ. Ярьж байгаа үг нь ч хүчгүй. Одоо үнэнч шударга тэр хуулийн

дагуу явдаг хүн бол бараг гадуурхагддаг болчихсон, энэ улс оронд бол. Улс орон тийм байдалд орчхоод байна. Саяын миний хэлээд байгаа энэ заалтыг оруулж чадах уу? Тэгээд энэ хөтөлбөр чинь батлагдлаа гэж бодоод батлагдах л байлгүй, та нар олонх юм чинь. Тэгээд 1 ажил хийж байгаа дүр эсгэнэ. Тэглээ гээд та нарын наад авлигын индекс чинь багасах уу? Энэ Засгийн газар, Улсын Их Хуралд авлигачид чинь дүүрчхээд байна. Танай Ардын нам чинь өнөөдөр авлигачид дүүрчхээд байна. Танай Ардын намын асуудал надад хамаагүй л дээ, гэхдээ өнөөдөр эрх барьж байгаа нам учраас 8 жил ... /минут дуусав/

Г.Занданшатар: Баттөмөрийн Энхбаяр Хууль зүйн байнгын хорооны дарга хариулна.

Б.Энхбаяр: Ганбат гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр хууль тогтоогчид бас хуулиа их зөв иргэдэд ойлгуулж байхгүй бол манай Эрүүгийн хуулиар авлига өгсөн этгээд нь эрүүгийн хариуцлага хүлээдэг юм шигээр ингээд ойлголт өгөөд яваад байж болохгүй ээ. Таныг Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны даргаар ажиллаж байх үед буюу 2015 оны Эрүүгийн хуулиар авлига өгснөө сайн дураараа илчилсэн этгээдийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлнө гэдэг заалт сүүлийн 8 жилийн турш хүчинтэй үйлчилж байгаа. Та өөрөө баталсан заалт шүү дээ. Тэгчхээд ийм заалт хуульд байхгүй гэхчхэн. Ингээд юм яриад байдаг бол жоохон харамсалтай.

2 дугаарт, таны баталсан улс төрийн манлайллыг үргэлжлүүлээд одоо энэ батлах гэж байгаа Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн одоо санал хураах гэж байгаа 15-д ийм заалт бас шинээр оруулах гэж байгаа, санал болгож байгаа, одоо санал хураана. 15 дахь заалт дээр. 6.1.11 хахууль өгсөн, зуучилсан хүн, хуулийн этгээд гэмт үйлдлээ илчилсэн, нотлох баримт гаргаж өгсөн, хамтран ажилласан тохиолдолд эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлэх, чөлөөлөх эрх

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 28-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

зүйн орчныг боловсронгуй болгоно гэдэг ийм хөтөлбөрийн томъёоллыг бид одоо санал болгож дэмжих гэж байна. Үүнийг дэмжсэн тохиолдолд юу болох гэж байна вэ гэхээр ганцхан хахууль өгсөн этгээд биш ерөөсөө авлигын гэмт хэрэг дээр нотлох баримт гаргаж өгч, энэ цааз жинхэнэ бид нар нөгөө тул жаргахай гэж ярьдаг бол тэр тулыг илчилсэн, тулыг илчлэхэд үнэтэй мэдээллийг өгсөн, хамтарч ажилласан энэ хүмүүсийг бол эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх, мөн ял шийтгэлийг нь хөнгөрүүлэх. Өөрийнхөө тэр томоохон хэргүүд байлаа гэхэд хэргээ хэр зэрэг илчилж байгаа, хохирлоо хэргээ зэрэг барагдуулж байгаа, булсан, нуусан мөнгөө хэр зэрэг гудаснаас нь гаргаж байгаа, тэр байдлаас нь хамаараад бас ял шийтгэлийн бодлого дээр нь уян хатан байдаг ийм хөшүүргийг Эрүүгийн хуульд бас оруулах нь зүйтэй гэж үзэж байгаа. Тэгэхгүй бол ганцхан муйхар аргаар өөрөөр нь хэргийг нь илчлүүлэх гээд дайраад байхаар хааидаа хэргээ илчилсэн илчлээгүй одоо тэр эдэлдэг ялаа эдлээд нөгөө нуучихсан, булчихсан мөнгөө илчлэхгүй байж байгаад тэгээд авдаг ялыг нь авч ирээд, гарч ирээд булсан мөнгөө ухаад амьдарчих юм чинь гэдэг байдлаар авлигын гэмт хэргээс учруулсан хохирол барагддаггүй. Ийм байж бас таарахгүй.

Ял шийтгэлийн бодлого чинь ийм 3 зорилготой байхгүй юу. 1 дүгээрт, цээрлүүлэх, 2 дугаарт, учирсан хохирлыг сэргээх, учруулсан хохирол, зөрчигдсөн эрхийг сэргээх, хохирлыг барагдуулах гэдэг том зорилго байгаа байхгүй юу. Яг энэ чиглэлд Эрүүгийн хууль Процессын хуулийн хөгжилт явж байгаа. Урьд нь статистикаар энэ зохицуулалт орж ирэхээс өмнө 5 гэмт хэрэг тутмын 1 нь л хохирол барагддаг байсан бол одоо ийм зохицуулалтууд орж ирснээр 5 гэмт хэргийн 3 нь хохирлоо барагдуулдаг болсон. Энэ жишээлбэл Авлигатай тэмцэх газрын энэ статистик. Та хэд бас хэлбэл их сайн байна. Хохирол барагдуулалт ер нь хэд дахин нэмэгдчихсэн юм. Энэ сүүлийн үеийн

зохицуулалтуудаас. Энэ чинь 10 гаруй давхин нэмэгдээд яваад байгаа шүү дээ. Хэзээ ч ийм байгаагүй.

Тийм учраас энэ хууль гэдэг өөрөө тийм ухаалаг бөгөөд мугуйд биш тийм ээ, тийм төмөр, бетон, данх шиг ийм хатуу байж болохгүй, хатуу байж болохгүй, уян хатан тийм ээ, ингэж байж үр дүнгээ эффektээ өгдөг ийм онцлогтой байгаа.

Г.Занданшатар: Дашидондогийн Ганбат гишүүн тодруулж асууна.

Д.Ганбат: Тийм, үнэн, үнэн. Тэр 2015, 2016 онд тэр Эрүүгийн хуулийг бид нар батлаад гаргасан. Эрүүгийн бас нөгөө процессын хуулийг батлаад бэлэн болгочихсон байсан юмыг ёслохдоо та нар ёслолгүйгээр тэрэндээ өөрчлөлт оруулсан. Тийм учраас энэ авлига өгсөн хүн нь бас ямар нэгэн байдлаар шийдэгддэг ийм байдалтай байгаа. Энэ чигээрээ л явсаар байгаад л өнөөдрийг хүрсэн байгаа. Тэгээд ер нь авлигатай тэмцэх хүсэл байгаа юм уу, байхгүй юм уу. Ер нь бараг л энэ авлигыг тэгээд 1 байлгаад байх сонирхолтой. Ийм л байдалтай байгаа шүү дээ. Одоо тэгээд 1 жил хүрэхгүй хугацаанд дараагийн сонгууль болчихсон. Авлигад жигвчихсэн энэ улс орон. Тэгээд эрх биш нэг тэмцэж байгаа ч юм шиг дүр эсгэж байгаа ийм байдалтай болчихсон, ийм л байдалтай байна. Тэгэхээр саяын миний уншсан хуулийг ерөөсөө авлига өгсөн, авсан 2-ын авсан нь шийтгэгддэг, өгсөн хүн ямар ч тохиолдолд шийтгэгддэггүй тийм л байдалд оруулчих. Тэгээд л бол оо.

Г.Занданшатар: Баттөмөрийн Энхбаяр Хууль зүйн байнгын хорооны дарга хариулна.

Б.Энхбаяр: Ганбат дарга аа, би хэлээд байна шүү дээ. Хууль ухаалаг байх ёстой, бетон төмөр шиг хатуу ийм байж болохгүй. Тэгвэл энэ чинь сөрөг нөлөө үзүүлнэ. Хахууль өгснийг нь л эрүүгийн хариуцлагаас чөлөөлдөг болчихвол хүнийг зориуд хэрэгт оруулахын тулд хахууль өгч

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 28-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

байгаа байдлаар, хахууль өгч байгаа байдлаар зориуд хэрэгт оруулдаг, шантаажилдаг ийм зэвсэг болох ашиглах эрсдэлтэй. Танай намын бүлгийн Их Хуралд сууж байгаа нэг гишүүн ийм үйл хэрэгт оролцсон тохиолдол ч бий. Би хэлж байна шүү дээ. Улс төрийн зорилготой, тодорхой улс төрчийг намнах, шантаажлах ийм ажиллагаанд оролцож байсан гишүүн танай бүлэг дотор чинь байгаа. Ийм тохиолдол байна. Тийм учраас ийм зэвсэг болгож ашиглах хөшүүргийг хуулиар бас нээж өгч болохгүй.

Г.Занданшатар: Одонгийн Цогтгэрэл гишүүн.

О.Цогтгэрэл: Авлигатай тэмцэх хөтөлбөрийн тогтоол орж ирж байна л даа. Энэ өөрөө зарчмын хувьд мэдээж зөв. Гэхдээ эцсийн дүндээ бид нарт бас үр дүн хэрэгтэй. Үр дүнд хүрэхийн тулд бид нар үндсэн шалтгаан руугаа бодит байдал дээрээсээ ахиц хэрэгтэй бид нарт. Тэгэхээр өнөөдөр яг бид нарын биш олон улсын нэг ганц 2 индекс хэлэхэд авлигын олон улсын индексээр Монгол Улс сүүлийн 6, 7 жилийн хугацаанд олон улсын үнэлгээгээр 2 оронтой тоонд бас боломжийг нь орж байсан бол одоо ухарсаар байгаад 3 оронтой тоонд орчихсон. Бас олон улсын бизнес эрхлэлтийн орчны индексээр Монгол Улс яг энэ хугацаанд бас 20 орчим байраар ухарчихсан.

Тэгэхээр энэ авлигын болоод энэ нөхцөл байдал улам муудаад л байгаа. Бид нар уг нь тэмцээд байна л гээд байгаа. Гэтэл яг олон улсын мэргэжлийн байгууллагуудын индекс яг яагаад ингээд хойшлоод байна вэ? Бид нар яг үндсэн шалтгаан дээрээ дүгнэлт хийж чадсан юм уу? Одоо ингээд нэг баахан зүйл заалттай хөтөлбөр яриад байдаг. Бид нарын үндсэн шалтгаан юу вэ? Тэгэхээр энэ авлига гэдэг зүйл чинь өөрөө төртэй холбоотой, төрийн албан хаагчтай холбоотой. Тэгэхээр Монголын төр Монголын төр төрөөр дамждаг мөнгө

жилээс жилд л өсөөд байгаа юм. Жилээс жилд өссөөр байгаад төсөв нь 40 орчим хувь, Төрийн өмчит компаниудыг оролцуулах юм бол хэд ч хувь болж байгаа юм. Тэрийгээ бараг тоолж чадахгүй ийм байдалд очсон. Төрөөр дамждаг, төрийн албаар дамждаг мөнгө ихэсчихсэн. Төрийн албан хаагчийн тоо нь бараг жилдээ сүүлийн 3 жилд бараг 20, 30 мянгаар өсчихсэн. Тэгэхээр яг үндсэн шалтгаан чинь төр нь томроод байхад бид нар мянган хөтөлбөр батлаад тэр нэг авлигыг хэрвээ шарилж өвс гэвэл үндэс рүү нь усалчхаад гарч ирснийг нь хайчлаад яг ямар үр дүнд хүрэх юм бэ. Шарилжийнхаа үндэс рүү ус хийгээд байдаг, улам гоё тэжээл хийгээд байдаг, нөгөөдөх ур худаг гарч ирснийг нь хайчилдаг. Тэгээд үүнийгээ тэмцэж байна гэдэг. Тэгэхээр энэ нөхцөл байдлууд дээрээ энэ тогтоолд ямарваа нэгэн тийм шинэчлэлийн шинжтэй, үзэл санааны шинжтэй зүйл байна уу.

Авлигатай тэмцэх, авлигачтай тэмцэх гэдэг бас өөр ойлголт байх. Хулгайтай тэмцэх, хулгайчтай тэмцэх гэдэг өөр ойлголт байх. Тэгэхээр үндсэн авлигын тогтолцоо руу, хулгай гардаг тогтолцоо тэр үндэс рүүгээ бид нар бас яг ямар зүйл энэ хөтөлбөр дээр байна вэ? Би тийм зүйл олж харсангүй.

2 дугаарт нь, авлигыг бууруулах бас нэг үндсэн нэг асуудал ил тод нээлттэй байдал олон нийтийн хяналт байх. Тэгэхээр яг энэ ажил хариуцсан хүмүүс бас байна. Ер нь Монгол Улсад тэр шилэн данс гээд нэг зүйл байгаа. Шилэн дансны хэрэгжилт яг энэ авлигатай тэмцэх байгууллагуудын үнэлгээ, дүгнэлтээр шилэн дансны хөтөлөлт, хэрэгжилт өнөөдөр ямар түвшинд байдаг вэ? Миний л бодлоор төрийн алба нь жижгээрээд, улам системтэйгээр, маш нээлттэй ил тод болоод, хэрэгжих ёстой хуулиуд нь хэрэгжиххвэл бараг энэ хөтөлбөрийг чинь олон нийтэд нь өөрсдөө бид нар үүнийг чинь хэрэгжүүлээд буураад л явчих, олон 7 ажил хийх энд ер нь хэрэгцээ шаардлага маш бага юм шиг л

санагдаж байгаа юм. Маш бага юм. Харин ч хаа очиж Монголын хууль тогтоомжууд авлигын эсрэг хууль тогтоомжууд тийм их бүр нэг сул ч бас биш байх бодвол.

Тэгэхээр яг үндсэн шалтгаан руугаа бид нар яг ямар ажлууд хийгдэж байгаа вэ? Тэр ил тод нээлттэй байдлыг хангах, шилэн дансны хэрэгжилт энэ олон зүйлүүд, төрийн алба, төрийн өмчит ААН-үүдтэй холбоотой, төрийн албан хаагчийн тэр шийдвэр гаргагчдын тоотой холбоотой тэр зүйлийг л үндэс шалтгаан гэж миний хувьд л үзээд байгаа юм л даа. Тэгэхээр энэ талаар яг ямар нэмж хэлэх зүйл, энэ талаар авч байгаа арга хэмжээ энэ хөтөлбөрт юу байгаа вэ?

Г.Занданшатар: Сайнзориг 81, Пүрэвжавын Сайнзориг Төрийн нарийн бичгийн дарга.

П.Сайнзориг: Цогтгэрэл гишүүний асуултад хариулъя. Ер нь авлигын индекс, одоогоор цаашидаа гарахаа больсон хэдий ч бас гол индикаторуудын нэг байсан бизнес эрхлэхүйн индекс бас сүүлийн жилүүдэд тодорхой хэмжээнд буурсан гэдэг нөхцөл байдлыг та бас ярьж байна. Энэ маань бас хэд хэдэн нөхцөл байдлаас шууд шалтгаалж байгаа гэж дүгнэж байгаа. Шууд. Үүнд ямар асуудал байна вэ гэхээр 1 дүгээрт, энэ тендер худалдан авалтын ажиллагааг бас ил тод, процедурын хувьд нарийвчлах шаардлагыг ерөөсөө хангахгүй байна гэдэг асуудал байгаа. Энэ дээр бас Монгол Улсын Засгийн газар, Улсын Их Хурлаасаа шийдвэрлээд энэ тендер худалдан авалттай холбоотой хууль, эрх зүйн орчныг цогцоор нь шинэчилсэн. Тэгэхээр энэ чиглэлийн үйл ажиллагаа нэлээн сайжрах байх. Мэдээж энэ индикатор үзүүлэлтийг гаргахад илүү их нөлөөлнө гэж үзэж байгаа.

2 дугаарт, дараагийн суурь асуудал нь ерөөсөө улс төрийн нам түүний дагасан санхүүжилтийн асуудлыг ил тод байхгүй байгаа нь манай энэ

авлигын төсөөллийн индексийг 3 оронтой тоо руу оруулж харагдуулаад байгаа. Энэ дээр Улсын Их Хурал бас бодитой алхмууд хийж, улс төрийн намын хуулиудыг яг энэ цаг үе дээр бас хэлэлцэж байна. Энэ дээр бас тодорхой шийдлүүд яваад ирэх юм бол хэт цөөнх буюу бизнесийн бүлэглэлээс хамааралтай далд хэлбэрийн энэ санхүүжилтийг авдаг энэ намын бүтцүүд байхгүй болно гэж үзэж байгаа. Тэгэхээр энэ бас цаашидаа авлигыг төсөөллийн индексийг урагшлуулах, үүнийгээ дагаж бид нар олон улсын нэр хүнд, хөрөнгө оруулалтын орчин сайжрах ийм нөхцөл бүрдэнэ гэж харж байгаа юм.

Дараагийн том авлигын төсөөллийн индексийг хойш татаж байгаа зүйл бол төрийн өмчит компаниудын засаглал, ил тод байдлын асуудал хангалтгүй гэдэг асуудал. Түрүүн Энхбаяр дарга бас хэллээ. Энхбаяр дарга бас энэ хуулийн төслийг ахлаад явж байна. Засгийн газраас бас энэ хуулийн төслийг ой си ди-ийн зарчимд нийцүүлээд энэ засаглалыг ил тод болгох, ер нь зүгээр энэ аль болохоор ашигтай ажиллаж, ноогдол ашиг хуваарилах буюу ийм байдал руугаа явъя. Ер нь төр бас оролцох бизнестээ оролцож, бусад бүхий л салбарууд руу оролцож хувийн хэвшилтэй өрсөлддөг энэ байдлыг хязгаарласан ийм концепцоор бичигдсэн ийм хууль байгаа.

Тэгэхээр энэ төр дэх эдийн засаг дахь төрийн оролцоо буюу энэ хумигдаад ирэхээр бас авлига буурна гэсэн ийм төсөөлөл байж байна.

Дараа нь мэдээж энэ төрийн байгууллагуудын процедурыг буюу энэ үйл ажиллагааг илүү их нарийвчлан тодотгох асуудал байгаа. Энэ мэдээж энэ Төрийн албаны хууль болон бусад холбогдох хуулиудаараа шийдэгдээд явах, дээрээс нь бас иргэний нийгмийн байгууллага буюу тэр дундаа энэ ТББ-аар дамжсан янз бүрийн бас авлигын ийм нөхцөл байдлуудыг бас хяналт тавих ёстой гэдэг ийм ерөнхий ийм шаардлагуудыг бид хэд хангаж чадвал манай авлига төсөөллийн

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 28-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

индекс нэлээн урагшилна. Мэдээж хууль, шүүхийн байгууллагуудын чадавхжуулах эргээд энэ хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түргэн шуурхай шийдэх ийм асуудал бол чухал байгаа.

Улсын Их Хурлаас бас тодорхой реформуудыг дэмжээд, батлаад өгсөн, бид бас хэрэгжилтийг нь хангаад явж байна. Өнөөдөр хэдийгээр шүүгч нарын бас хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дээр бас асуудлууд үүсэж байгаа боловч нэг талдаа энэ сахилга хариуцлагын асуудал нэлээн чангарч байгаа, сайжирч байгаа. Цаашидаа дотоод итгэл үнэмшил гэдэг ийм зүйлүүдээр хаацайлж бас хууль хэрэглээний нэгдмэл байдлыг үгүй хийдэг ийм байдал дээр бас Улсын дээд шүүх, Шүүхийн ерөнхий зөвлөлтэйгөө манай яам ажиллаад бас тодорхой хуулийн төслийг тун удахгүй бас өргөн барихаар бас ажиллаж байгаа. Тэгээд ер нь гол асуудал юу вэ гэхээр бид эдийн засаг дахь төрийн оролцоог бууруулах, энэ авлигатай тэмцэхийг зөвхөн эрүүгийн ял шийтгэлийн бодлого гэдэг биш маш цогц үйл ажиллагаа тэгээд бүх талын оролцоо байх ёстой гэдгийг бид бас нийгмээрээ ойлгож тэмцэж байгаа учраас энэ дээр бас тодорхой хэмжээний ахицууд өнөөдөр ч гэсэн гарч байгаа гэж харж байгаа. Тэгээд мэдээж бас Улсын Их Хурлаас баталж өгсөн цахим хуулиудын хэрэгжилт бас нэлээн хангагдаж байна. Ил тод байдал, Шилэн дансны хуулиуд бас сүүлийн үед хэрэгжилтийг бид нар нь тийм формал түвшинд биш иргэдийн яг мэдээлэл авах чадавхтай, байнгын апдэйт хийдэг, мэдээлэл нь өөрөө үнэн зөв бодитой байх, танилцах боломжтой тийм ээ, тэр нь өөрөө цаг хугацаа орон зайнаас үл хамаарч ийм бүхий л бололцоог бас зохион байгуулалтын хувьд бас хангаад ингээд явж байгаа юм. Тэгээд мэдээж ... /минут дуусав/

Г.Занданшатар: Одонгийн Цогтгэрэл гишүүн тодруулж асууна. Нэг минут.

О.Цогтгэрэл: Тэр шилэн дансны хэрэгжилт дээр яг албан ёсны үнэлгээ хийсэн, хэрэгжилтийг нь тэр чанарын үнэлгээ хийсэн яг тайлан мэдээ баримт байдаг уу? Үүнийг ер нь хаанаас үнэлгээ нь гарч байх ёстой байдаг вэ? Үүгээр бол сайн хөтөлж байгаа байгууллага, муу хөтөлж байгаа байгууллагуудын тухай ингээд нэг ийм тодорхой мэдээлэл өгөөч, 1 дүгээрт.

2 дугаарт нь, тэр төрийн өмчийн оролцоо, төрийн оролцоо гэдэг зүйл авлигын үндэс гэдэг нь тов тодорхой л зүйл шүү дээ. Энэ шалтгаан руугаа бид нар ямарваа нэгэн ажил хийгдэхгүй л байгаад байна л даа. Миний хувьд бас төрийн өмчит ААН-үүдийг шинээр байгуулахгүй байх гэдэг тогтоолыг бас Цогтбаатар нарын гишүүд бас өргөн барьсныг нэгтгэн хэлэлцэхээр бас одоогоор дараагийн хэлэлцүүлгүүдэд орж ирэхгүй. Энэ үндсэндээ бас нэг тийм арга ядсан л хэлбэр шүү дээ. Арга ядсан нэг ийм механикаар төрийн оролцоог багасгая, ядаж өсгөхгүй байя гэдэг. Тэгэхээр үүний хүрээнд ч гэсэн олон ажлууд үүний цаана, дараа, дараа ингээд хийгдэх ёстой л гэж боддог. Тэр байтугай тэр бодит тоонууд, хэчнээн ААН-ийн тоо бол арга ядсан л хэл.

Г.Занданшатар: Баттөмөрийн Энхбаяр Хууль зүйн байнгын хорооны дарга хариулна.

Б.Энхбаяр: Цогтгэрэл гишүүн бид Мөнх-Оргил гишүүн хэлсэн, Цогтбаатар гишүүн юу, тогтоол санаачилсан энэ төрийн болон орон нутгийн өмчит компаниудыг шинээр байгуулахгүй байх тогтоолыг санаачилсан. Тэгээд энэ Улсын Их Хурал хэлэлцэх эсэхийг нь дэмжсэн. Одоо энэ заалт дээр бас хадаж өгөх гэж байгаа. Үүнийг нэн тодорхой болгоод.

Ер нь ДНБ-д төсвийн зарлага төрийн оролцоог үе шаттай бууруулах бодлогыг баримталъя гэж байгаа. Бид яах вэ, махан тоо тавихад бас хэцүү байна. Махан тоо. Бидний харж

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 28-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

байгаагаар одоо төрийн өмчийн төсвийн зарлагын оролцоо энэ ДНБ-д 35 орчим хувьтай байгаа, 37 байгаа юу. Бид бол энэ авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг одоо нэлээн шахаж явна. Ер нь нэг 20 хувь орчим хувьд бол 30 он гэхэд барих учиртай гэж төсөөлж байгаа. 2030 он. Энэ хөтөлбөрийн биелэлт гарахад 20 хувьд хүрэх ёстой, 2 дахин бууруулах гэж байна.

Г.Занданшатар: Ганзоригийн Тэмүүлэн. Байж байгаарай. Тэмүүлэн гишүүн түр байж байгаарай. Энэ гүйцээж хариулъя гэж байна. 81. Хууль зүйн байнгын хорооны дарга Шилэн дансны хэрэгжилт. 81 Төрийн нарийн бичгийн дарга Пүрэвжавын Сайнзориг.

П.Сайнзориг: Цогтгэрэл гишүүний асуултад хариулъя. Ер нь Шилэн дансны энэ хуулийн хэрэгжилт дээр тал талын байгууллагууд хянадаг. Ерөнхий байдлаараа Төрийн аудитын газар бас эдгээрт хяналт тавьж, тодорхой зөвлөмж зүйлүүдийг төрийн байгууллагад хүргүүлж, засуулж байгаа ийм асуудал байна.

2 дугаарт, бас Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг бас Сангийн яаман дээр үнэлээд бас энэ хуулийг шинэчлэх ажил явагдаж байгаа.

Дээрээс нь манай Авлигатай тэмцэх газар бас ерөнхий энэ санаачилгаараа шударга байдлын үнэлгээг төрийн байгууллагын дунд гаргахдаа энэ Шилэн дансны хөтөлөлтийг бас нэг гол үзүүлэлт авч явдаг байсан. Энэ үйл ажиллагааг бид нар бас уялдуулаад төрийн байгууллагуудын нээлттэй байдлын үнэлгээ гэдгийг манай Хууль зүй, дотоод хэргийн яам, Цахим хөгжлийн яам, Авлигатай тэмцэх газрын төлөөллүүд хамтраад энд бас иргэний нийгмийн оролцоотой ингээд хамтраад хийгээд явж байгаа. Тэгэхээр бид ер нь төрийн байгууллагуудын хуулиар хязгаарлалттай буюу хаалттай гэснээс бусад мэдээллүүдийг аль болохоор олон нийтэд нөгөө зөв форматын дагуу

андэйт хийгдсэн ийм байдлаар ил тод байлгах асуудал дээр зөвхөн шилэн данс гэхгүй ... /минут дуусав/

Г.Занданшатар: Ганзоригийн Тэмүүлэн гишүүн асуулт асууна.

Г.Тэмүүлэн: Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр батлах асуудлыг Улсын Их Хурлын тогтоолын төслийн асуудлыг зарчмын хувьд дэмжиж байгаа. Тэгэхээр бид нарын хувьд энэ хамгийн бас нийгмийн манай үнэт зүйлийн асуудал бол энэ хууль ёсны асуудал байгаад байгаа. Шударга ёсны асуудлууд байгаад байгаа. Нөгөө талдаа энэ авлигатай тэмцэх асуудлыг, засаглал тогтолцооны хувьд энэ шударга ёсны засаглалыг бэхжүүлэх, шударга ёсны тогтолцоог бэхжүүлэх асуудал дээр Улсын Их Хурлаас болоод шийдвэр гаргагчдын зүгээс онцгой анхаарч, зайлиггүй бэхжүүлэх шаардлага байгаад байгаа. Энэ авлига, албан тушаалын гэмт хэргийг бууруулах дээр үе шаттайгаар тэмцэх энэ бол бид нарын бас онцгойлж авч үзэх нэг асуудлын нэг болж байна.

Үүнтэй холбоотойгоор би зүгээр нэг зүйлийг нэг асуух гээд байгаа зүйл байгаад байгаа юм. Бид нар цаашид ер нь яг энэ хууль цааз хэрэгжих юм уу, үгүй юм уу, шударга ёс тогтох юм уу, үгүй юм уу, эсвэл энэ авлигыг байхгүй болгох юм уу гэдэг асуудал энэ суурь зарчмын асуудал дээр бид нар нэг ер нь энэ байгууллагуудын чинь бие даасан байдлыг ер нь яаж хангах ёстой юм бэ гэдэг асуудал байгаа. Хууль хүчний, хууль хяналтын байгууллагууд. Тэр дундаа авлигатай тэмцэх байгууллагуудын хараат бус бие даасан байдлыг бэхжүүлэх дээр бид нар хангалттай зохицуулалтыг нь хийж чадаж байна уу. Зорилго 5 гээд энд орж ирж байгаа. Аваад үзэхээр нэг 6, 7, 8 зүйл заалт байгаад байдаг. Нэг талдаа бид нар магадгүй энэ томилгоо, чөлөөтэй холбоотой асуудлуудыг нь ч гэсэн бие даасан байдлыг нь, хараат бус байдлыг нь бэхжүүлэх асуудлууд дээр гол

зохицуулалтуудыг нь хийж чадаж байгаа юм уу, үгүй юм уу.

Нэгдүгээрх нь. Би бол харахад учир дутагдал бас байна л гэж хараад байгаа юм. Илүү боловсронгуй болох дээр илүү тодорхой зохицуулалт заалтуудыг нарийвчилж тодорхой болгож оруулж өгөх ёстой юм шүү.

2 дахь нь, би Төсвийн байнгын хорооны даргын хувиар нэг талдаа төсвийн үр ашиг, төсвийнхөө хяналт талаасаа бас нэг заалтыг бас ярихгүй бол болохгүй болчхоод байна аа, ярихгүй бол болохгүй болчхоод байна. 5.1.6 дээр нэг ийм заалт орж ирж байгаа. Авлигатай тэмцэх газрын тухайн жилийн төсвийг өмнөх оны батлагдсан төсвийн хэмжээнээс бууруулан батлахыг хориглоно гээд байгаа юм. Өмнөх оных нь батлагдсан төсвийн хэмжээнээс бууруулан батлахыг хориглоно гэж гарчхаад байгаа юм. Сүүлийн үед нэг талдаа яг иймэрхүү утга агуулга бүхий заалтууд бас ихэвчлэн орж ирэх гээд байдаг болчихлоо. Тэгэхээр би нэг талдаа магадгүй яг яах вэ шүүх бол тусдаа асуудал. Гүйцэтгэх засаглал, хууль тогтоох, хууль хяналтын байгууллага хууль тогтоох байгууллага. Нөгөө талдаа шүүх засаглалын асуудлууд. Тэгэхээр магадгүй одоо юу гэдэг юм. Өмнөх оных нь төсөв дээр нь нэг удаагийн шинж чанартай зардал гарсных нь төлөө дараагийнх нь жил нь тэр мөнгийг нь дахиж тавина гэдэг асуудал чинь өөрөө утгагүй асуудал болчхоод байгаа байхгүй юу. Тэрийг яаж засах юм гэдэг юм уу, эсвэл магадгүй бид нар ингээд авлигатайгаа тэмцээд энэ асуудлуудыг байхгүй болгох гээд ингээд нэг 5, 10 жил тэмцэсний дараа өссөн тэлсэн зардлаа дахиад яаж бууруулах вэ гэдэг асуудал болчхоод байгаа байхгүй юу. Би шүүх засаглалтай бол үүнийг энэ асуудлыг ярихгүй байгаад байгаа юм. Энэ бол тусдаа бие даасан засаглалын асуудал.

Тэгэхээр бид нар хууль, хяналтын байгууллага болгон тусдаа ингээд орж

ирээд байвал энэ бол зарчмын хувьд би бас буруу байна гэж хараад байгаа юм. Утгагүй асуудал байна уу. Магадгүй нэг удаагийн шинж чанартай зардлууд гарчихсан байдаг, 2, 3 жил үргэлжилчихсэн байдаг. Асуудал нь байхгүй болчихсон арилсны дараа дахиад тэр зардал нь байгаад байвал бас утгагүй байхгүй юу. Тэгэхээр би жишээ нь үүнийг заавал ч үгүй ингэж оруулах шаардлага байгаа юм уу, үгүй юм уу? Энэ дээр Байнгын хороо нь яг юу гэж үзэж байгаа юм бол?

Нөгөө талдаа хууль тэгэхээр яах вэ, хууль мөрдүүлэх ёстой байгууллага маань өөрсдөө бас хуулийнхаа хүрээнд ажиллах ёстой. Тэгэхээр бид нар нэг талдаа эрх мэдлийг давж гаргаж өгөөд байгаа бол хяналт хариуцлагынх нь балансыг нь барьж байх ёстой. Тэр засаглал тогтолцоог нь бас давхар бий болгож байх ёстой байгаад байгаа юм. Чекин баланс гэдэг юм уу, хяналт хариуцлагын тогтолцоог бий болгох гэдэг юм уу, энэ тал дээрээ бас давхар ер нь яаж авч үзэж байгаа юм бол. Эрх мэдлийг ... /минут дуусав/

Г.Занданшатар: Хууль зүйн байнгын хорооны дарга Баттөмөрийн Энхбаяр хариулна.

Б.Энхбаяр: Би Тэмүүлэн гишүүнтэй санал нэг байна. Тэмүүлэн гишүүн бол ялангуяа энэ авлигын гэмт хэрэг, тэр дотроо энэ улсын төсвийн ил тод байдлыг ер нь ил тод болгоё, төсвийн хуваарилалтыг үр ашиггүй байдаг энэ дээр цавчаа юмнууд хийдэг, энэ юмыг олон нийтийн оролцоотойгоор, ил тод, үр дүнтэй, үр дүнд суурилсан ийм төсвийн менежментийг нэвтрүүлэе гээд хууль санаачилсан. Улсын Их Хурал бас хэлэлцэхийг нь дэмжсэн явж байгаа.

Тэр Авлигатай тэмцэх газрын тухайн жилийн төсвийг өмнөх оны батлагдсан төсвийн хэмжээнээс бууруулан батлахыг хориглоно гэдэг 5.1.6 дахь заалтын тухайд бол би бас зарчмын

хувьд тантай санал нэг байна. Яг хэлэлцэх эсэхийг шийдэх үед яг энэ асуудал хөндөгдөөгүй. Ажлын хэсэг дээр, Байнгын хороо дээр энэ асуудал яригдаагүй. Яах вэ, бид Шүүхийн хууль 2 жилийн өмнө 21 онд ярихад яг ийм заалт байсныг нь хассан юм. Энэ өөрөө юу тохиромжгүй юм байна, тохиромжгүй юм байна, юу яах юм байна. Яг шүүх дээр чинь зарим үед нь нөгөө барилга бариад, зарим үед нь барилга биш ингээд өөр юм яригдаад ингээд өсөж, буурах боломжтой уян хатан биш болгоод байна гэдэг энэ заалт нь эсрэгээрээ саад болоод байна гэдэг асуудал бас яригдсан юм. Тийм учраас зарчим тантай санал нэг байна. Яах вэ ерөнхий энэ чинь хууль биш байхгүй юу. Тогтоол. Ерөнхий Авлигатай тэмцэх газрын төсөв санхүүг энэ эдийн засгийн хараат бус байдлыг нь хангахуйц тийм ээ, энэ хэрэг бүртгэх, энэ мөрдөн шалгах, энэ ажлын ачаалал, энэ юмыг нь даахуйц байдаг юм уу, энд нь дэм болсон гэдэг юм уу, ямар томъёолол байдаг юм, ийм хэлбэрээр томъёолох одоо чинь энэ эхний хэлэлцүүлэг чуулган дээр явагдаж байгаа. Байнгын хороон дээр яригдаагүй, яах вэ, дарга нь чиглэл өгвөл эцсийн хэлэлцүүлэг дээр ярих бололцоотой л юм байна. Тийм, ийм байдлаар ярихад бол нэг их асуудал байхгүй. Авлигатай тэмцэх байгууллагад ч гэсэн нэг асуудал байхгүй байх. Энэ нөгөө тодорхой төсвийг нь ихэсгэж, бууруулж байгаа асуудал бас биш байгаад байгаа юм.

Бид нар шүүхийн хуульд байсныг нь бол яг таны хэлснээр 2 жилийн өмнө шүүх дээр яг ийм заалт байсныг нь эдийн засгийн хувьд бие даасан хараат бус байхаар төсөв санхүүг нь хангана гэдэг ийм ерөнхий заалтаар л бичиж байсан юм. Яг Авлигатай тэмцэх газрын тухайд бол ийм юм бичих боломжтой. Ер нь энэ нь ч зөв байх гэж бодож байгаа юм. Тийм. Тэгэхгүй ийм хатуу махан тоо тавиад явах нь яг таны хэлснээр нөгөө зарим үед энэ чинь барилга барьж болно, зарим үед барилга барихгүй, яг барилга бариад дууссаныг нь дараах жил нь нөгөө барилга барьсан төсвөөс нь бууруулж болохгүй

гэхээр бас болохгүй болчихоод байгаа ийм логик байна, дарга аа. Тэмүүлэн дарга аа, яг ийм логик байна.

Тийм учраас үүнийг яг нөгөө энэ бол нөгөө урсгал зардлыг яриад байгаагаас биш хөрөнгө оруулалт дээр чинь байнга ихсэж, буурна шүү дээ, энэ чинь. Тийм, урсгал зардлыг л бууруулахгүй байх тухай яриад байгаа байхгүй юу. Уг нь санаа нь бол тийм юм, тийм. Тэгэхээр нийтээр нь бичихээр яг нэг хөрөнгө оруулалттай давхар хамраад ингээд нэг ингэж ойлгогдохуйц болоод байгаа тал байна. Тэгэхээр дарга зөвшөөрвөл чиглэл өгчихвөл бид Байнгын хороо бас эцсийн хэлэлцүүлэг дээр Тэмүүлэн гишүүнээс ... /минут дуусав/

Г.Занданшатар: Тухайн хэлэлцэх асуудал дээр чиглэл өгөөд явчихъя.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Одоо санал хураалт явуулна. Гишүүд чуулганы танхимд цуглая.

Ер нь бас зарим гишүүд яриад байна. Авлига асар их нэмэгдсэн гэж. Улаанбаатар нэг өдөр босоогүй гэдэгтэй адилхан авлига нэг дор гэнэт бий болчихсон биш харин авлигатай тэмцэж байгаа тэмцэл, илрүүлэлт нэмэгдэж байгаа учраас л авлигын гэмт хэргийн дуулиан их гарч байгаа учраас үүнтэй Улсын Их Хурал, Засгийн газар, Авлигатай тэмцэх газар бүх нийтийн хөдөлгөөн өрнөж, улс төрийн хүсэл зорилгыг илэрхийлж, тэмцэл явж байгаа учраас олон жил бугшсан энэ ингээд энэ хулгай, зэлгий ил тод болж байгаа шүү дээ. Тэгээд ил тод болохоор хулгай, авлига нэмэгдчихсэн юм шиг яриад байдаг. Тэгтэл үнэн хэрэг дээрээ энэ бас холбогдох байгууллагууд, улс төрийн хүсэл зорилгын илэрхийлэл, үр дүн юм шүү. Харин ч энэ Үндэсний хөтөлбөрийн I дүгээр заалт нь авлигатай тэмцэх улс төрийн хүсэл зориг, манлайлал, хүчин чармайлтыг төгөлдөршүүлж

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 28-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

төлөвшүүлнэ. Тэгээд энэ санал авах ажиллагаанд ерөөсөө эх нь булингартай бол адаг нь булингартай гэж санал худалдан авдаг л энэ эхэлж байна шүү дээ. Бетон сав тараадаг, санал худалдан авдаг чинь энэ авлигын эх үндэс болж байгаа юм.

Тийм учраас энэ авлигын сонгуулиас чинь авхуулаад энэ бүх юмаа авлигагүй байж байж энэ төр чинь авлигагүй, эх үндэсгүй болно шүү дээ. Тэгэхгүй бол авлига нэг өдөр бий болчихсон юм шиг ингээд л өмч хувьчлалаас авхуулаад л яривал, ерөөсөө энэ булхай луйврыг харин илрүүлж байгаа юм. Ил болохоор хүмүүс нээ наа гэж бид ярьж байгаа юм.

Ингээд санал хураалт явуулна. Гишүүд чуулганы танхимд цуглая.

Зарчмын зөрөөтэй 33 санал байгаа.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууссан.

“Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх зарчмын зөрөөтэй саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Нэг. ХЗБХ дэмжсэн санал.

1. Тогтоолын төсөлтэй холбоотой санал.

1. Тогтоолын төслийн “43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсэг” гэснийг “5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг” гэж өөрчлөн, 1 дэх заалтын “1 дүгээр хавсралтаар, “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г 2 дугаар” болон “тус тус” гэснийг хасаж, тогтоолын төсөлд доор дурдсан агуулгатай 2 дахь заалт нэмэх:

“2. “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г 2023 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор батлах, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг жил бүрийн улсын төсөвт тусгаж батлуулахыг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай.” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Баттөмөрийн Энхбаяр.

Санал хураалт явуулна. Санал хураалт.

Тогтохсүрэн дарга.
Дуламдоржийн Тогтохсүрэн гишүүн.

Д.Тогтохсүрэн: Баярлалаа. Би сая дэмжиж санал өгсөн юм. Тэгсэн чинь эсрэг гарчихсан юм байна. Тийм учраас саяын санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулж өгөхийг хүсье. Явуулж өгөх горимын санал гаргаж байна.

Г.Занданшатар: Тогтохсүрэн гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулъя.

54,8 хувийн саналаар Тогтохсүрэн гишүүний гаргасан горимын санал дэмжигдэж, өмнөх санал хураалтыг хүчингүйд тооцсон учраас санал хураалтыг дахиж явуулъя. Санал хураалт.

57,1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2 дугаар хавсралтаа байхгүй болгочхож байгаа юм байна, тийм ээ.

2.Тогтоолын төслийн 2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, дугаарыг 3 болгон өөрчлөх:

“Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрт тусгагдсан зорилт, үйл ажиллагааг улсын болон аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 28-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

тусгаж хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдлагад, хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах, нэгдсэн удирдлагаар ханган хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/, Авлигатай тэмцэх газар /З.Дашдаваа/-т тус тус үүрэг болгосугай.” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Баттөмөрийн Энхбаяр, санал хураалт.

59,5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Тогтоолын төслийн хавсралттай холбоотой санал.

1. Тогтоолын төслийн хавсралтын гарчгийн дараа доор дурдсан агуулгатай хэсэг нэмж, төслийн заалт бүрийн өмнөх “Үйл ажиллагаа” гэснийг хасах:

“Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр /цаашид “Хөтөлбөр” гэх/ нь “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх суурь нөхцөлийг бүрдүүлэх, үндэсний шударга ёсны тогтолцоог бэхжүүлэх замаар авлига, албан тушаалын гэмт хэргийг бууруулж, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх эрх зүйн орчныг бэхжүүлэх, нийгмийн бүх түвшинд шударга ёсыг эрхэмлэсэн хандлагыг төлөвшүүлэн, шударга ёсны засаглалыг бэхжүүлэхэд чиглэсэн, “Шинэ сэргэлтийн бодлого”-той уялдсан, 2023-2030 онд хэрэгжих дунд хугацааны зорилтот хөтөлбөр юм.” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Баттөмөрийн Энхбаяр, санал хураалт.

59,5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2. Тогтоолын төслийн хавсралтын зорилт 1.1 дэх хэсгийн үйл ажиллагааны 1.1.4 дэх заалтыг хасах. Санал гарсан Улсын Их Хурлын гишүүн Лхагвын

Мөнхбаатар, Дамдины Цогтбаатар. Санал хураалт.

57,1 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

3. Тогтоолын төслийн хавсралтын зорилт 1.2 дахь хэсгийн 1.2.2 дахь заалтын “Улс төрийн” гэсний өмнө “Төрийн” гэж нэмж, “албан тушаалтныг” гэсний дараах “өөрийн” гэснийг “хувийн” гэж, зорилт 1.4 дэх хэсгийн 1.4.1 дэх заалтын “механизмыг” гэснийг “тогтолцоог” гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Баттөмөрийн Энхбаяр, санал хураалт.

57,1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4. Тогтоолын төслийн хавсралтын зорилт 1.5 дахь хэсгийн 1.5.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1.5.2.Улсын Их Хурлын гишүүн өөрөө эцсийн өмчлөгч, эсхүл нөлөө бүхий хувьцаа эзэмшиж байгаа хуулийн этгээдийн явуулж байгаа аж ахуйн үйл ажиллагаатай холбогдох хууль тогтоомжийн төсөл санаачлах, санал гаргахыг хязгаарласан эрх зүйн орчныг бүрдүүлнэ.” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Баттөмөрийн Энхбаяр, санал хураалт.

56,1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

5. Тогтоолын төслийн хавсралтын зорилт 2.1 дэх хэсгийн 2.1.6 дахь заалтын “сайжруулах” гэсний дараа “, хариуцлагыг нэмэгдүүлэх” гэж нэмэх. Санал гарсан Улсын Их Хурлын гишүүн Баттөмөрийн Энхбаяр, санал хураалт.

58,5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

6. Тогтоолын төслийн хавсралтын зорилт 2.1 дэх хэсгийн 2.1.2 дахь заалтын

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 28-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

“хөгжүүлнэ” гэснийг “хөгжүүлж, холбогдох эрх зүйн орчныг боловсронгуй болгоно” гэж, 2.1.5 дахь заалтын “төрийн албанд ёс зүйг төлөвшүүлнэ” гэснийг “чадахуйн зарчимд суурилсан, мэргэшсэн төрийн албыг төлөвшүүлнэ” гэж, 2.1.7 дахь заалтын “төлүүлж, хяналт тавина” гэснийг “төлүүлэх, хяналт тавих тогтолцоог бүрдүүлнэ” гэж, “2.1.8” дахь заалтын дугаарыг зорилт 2.4 дэх хэсгийн “2.4.2” болгон өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Баттөмөрийн Энхбаяр. Санал хураалт.

56,1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

7. Тогтоолын төслийн хавсралтын зорилт 2.1 дэх хэсгийн 2.1.3 дахь заалтын “гол” гэснийг, 2.1.7 дахь заалтын “бий болгож,” гэснийг дараах “төрд учруулсан” гэснийг, 2.1.4 дэх заалтыг тус тус хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Баттөмөрийн Энхбаяр. Санал хураалт.

52,4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

8. Тогтоолын төслийн хавсралтын зорилт 2.2 дахь хэсгийн “механизмыг” гэснийг “тогтолцоог” гэж, 2.2.2 дахь заалтын “орчныг бүрдүүлнэ” гэснийг “зохицуулалтыг боловсронгуй болгоно” гэж, зорилт 2.3 дахь хэсгийн 2.3.1 дэх заалтын “зохих хэмжээний зарлага” гэснийг “нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх буюу түүнээс дээш хэмжээний зарлагыг” гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Баттөмөрийн Энхбаяр, санал хураалт.

57,1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

9. Тогтоолын төслийн хавсралтын зорилт 2.4 дэх хэсэгт доор дурдсан агуулгатай 2.4.3 дахь заалт нэмэх:

“2.4.3.Монгол Улсын Үндсэн хууль болон олон улсын гэрээнд заасан албан тушаалтнуудаас бусад хуулиар тогтоосон албан тушаалын халдашгүй байдлын хүрээг хязгаарлана.” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Баттөмөрийн Энхбаяр, санал хураалт.

57,1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

10. Тогтоолын төслийн хавсралтын зорилт 2.5 дахь хэсгийн 2.5.3 дахь заалтын “бүрэн цахимжуулна” гэснийг өмнө “үе шаттайгаар” гэж нэмж, мөн хэсгийн “Төрд байгаа” гэснийг “Төрийн үйл ажиллагааны” гэж өөрчлөх. Санал гарсан Улсын Их Хурлын гишүүн Баттөмөрийн Энхбаяр, санал хураалт.

59,5 хувийн саналаар санал дэмжиж байна.

Тогтоолын төслийн хавсралтын зорилт 3.3 дахь хэсгийн 3.3.3 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3.3.3.Ашигийн бус салбар дахь терроризмыг санхүүжүүлэх үндэсний эрсдэлийн үнэлгээний аргачлалыг боловсруулах, Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)-ын Техник хэрэгжилтийн зөвлөмжид нийцүүлэн ашигийн бус байгууллагыг хамруулна.” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Баттөмөрийн Энхбаяр, санал хураалт.

52,4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

13. Тогтоолын төслийн хавсралтын зорилт 5.1 дэх хэсгийн 5.1.6 дахь заалтын “хориглоно” гэснийг “хориглох эрх зүйн орчныг бүрдүүлнэ” гэж, зорилт 5.2 дахь хэсгийн 5.2.1 дэх заалтын “шинэ шатанд хүргэнэ” гэснийг “өргөжүүлнэ” гэж, зорилт 5.4 дэх хэсгийн 5.4.3 дахь заалтын “олон улсын” гэснийг “гадаад” гэж өөрчилж, зорилт

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 28-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

6.1 дэх хэсгийн 6.1.5 дахь заалтын “мөнгө угаах,” гэснийг хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Баттөмөрийн Энхбаяр.

Энэ нөгөө заалт уу. Үүнийг гүйцээн боловсруулах чиглэл өгье.

Авлигатай тэмцэх газрын төсвийг бууруулж болохгүй л гэсэн юм байна шүү дээ, энэ чинь уул нь. Агуулга нь хориглох эрх зүйн орчныг. Зарим жил ингээд дээш доош савлаж хөдөлж болно гэж.

12. Тогтоолын төслийн хавсралтын зорилт 5.6 дахь хэсгийн 5.6.2 дахь заалтын “хараат бус,” гэсний өмнө “улс төрөөс” гэж, зорилт 6.1 дэх хэсгийн 6.1.4 дэх заалтын “Хураасан,” гэсний өмнө “Хөрөнгө буцаасан,” гэж тус тус нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Баттөмөрийн Энхбаяр, санал хураалт.

57,1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

14. Тогтоолын төслийн хавсралтын зорилт 6.1 дэх хэсгийн 6.1.6 дахь заалтын “тооцно” гэснийг “тооцдог болох эрх зүйн орчныг бий болгоно” гэж өөрчилж, 6.1.8 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“6.1.8.Авлигын гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийн хувьд ногдох хөрөнгийг хураах нэмэгдэл ялын төрөл бий болгох асуудлыг судалж, санал боловсруулна.” Санал гарсан Улсын Их Хурлын гишүүн Баттөмөрийн Энхбаяр, санал хураалт.

53,7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

15. Тогтоолын төслийн хавсралтын зорилт 6.1 дэх хэсгийн 6.1.11 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“6.1.11.Хахууль өгсөн, зуучилсан хүн, хуулийн этгээд гэмт үйлдлээ илчилсэн, нотлох баримт гаргаж өгсөн, хамтран ажилласан тохиолдолд эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлэх, чөлөөлөх эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Баттөмөрийн Энхбаяр, санал хураалт.

59,5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

16. Тогтоолын төслийн хавсралтын зорилт 6.1 дэх хэсгийн 6.1.12 дахь заалтыг хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Баттөмөрийн Энхбаяр, санал хураалт.

52,4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

17. Тогтоолын хавсралтын зорилт 6.1 дэх хэсгийн 6.1.15 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“6.1.15.Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)-ын 40 зөвлөмж, үр дүнтэй байдлын шууд хэрэгжилтийн 11 шалгуурыг хангаж, санхүүгийн бус бизнес мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдийн үйл ажиллагаанд тавих хяналтыг нэмэгдүүлнэ.” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Баттөмөрийн Энхбаяр, санал хураалт.

58,5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

18. Тогтоолын төслийн хавсралтын зорилт 6.2 дахь хэсгийн 6.2.4 дэх заалтын “шийдвэрлүүлнэ” гэснийг “шийдвэрлүүлэх эрх зүйн орчныг бататгана” гэж, 6.3.1 дэх хэсгийн “болгоно” гэснийг “болгох эрх зүйн орчныг бүрдүүлнэ” гэж өөрчилж, 6.2.5 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“6.2.5.Эдийн засаг, авлига, хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг

болон мөнгө угаах өндөр эрсдэлтэй гэмт хэргийг суурь гэмт хэрэгт хамааруулах, гэмт хэргийн шинж, зохицуулалтыг Нэгдсэн Үндэстний Байгууллагын гэрээ, конвенц, олон улсын стандартад нийцүүлнэ.” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Баттөмөрийн Энхбаяр, санал хураалт.

58,5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

19. Тогтоолын төслийн хавсралтын зорилт 6.4 дэх хэсгийн 6.4.3 дахь заалтыг хасах санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Баттөмөрийн Энхбаяр, санал хураалт.

61 хувийн саналаар санал дэмжигдлээ.

20. Тогтоолын төслийн хавсралтын зорилт 6.4 дэх хэсгийн 6.4.6 дахь заалтын “суллахгүй байх” гэсний өмнө “шүүхээс” гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Баттөмөрийн Энхбаяр, санал хураалт.

58,5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Тэгэхдээ ер нь зөв юм уу? Баттөмөрийн Энхбаяр гишүүн. Заавал шүүхээс, шүүх эцсийн шийдвэр гарах болохоос биш энэ чинь прокурор энэ тэр бүгдийнх нь ажиллагаа оролцоно шүү дээ. Үүнийг эцсийн найруулга дээр анхаараарай.

Энэ чинь нөгөө ял эдлэх ажиллагаанаас чинь болж суллах гэх гэж байгаа бол байхгүй шүүхээс суллана гэдэг чинь их өөр агуулга болчихно шүү дээ. Жишээлбэл хорих ял эдэлж байгаа хүнийг хорихоос суллахгүй байна гэж хэлж болно, тийм үү? Тэгэхээр ял эдлүүлэх ажиллагаанаас чөлөөлж болохгүй ч гэдэг юм уу, энэ найруулгад нь анхаарахгүй бол шүүхээс суллана гэдэг чинь нэг ийм өөр ойлголт. Суллана гэж ярих уу яах вэ? яг энэ юуг нь магадлангаар суллана гэж

тодруулахгүй бол энэ их жоохон тийм ойлгомжгүй л байна. Үүнийг эцсийн хэлэлцүүлэг дээр найруулгын хувьд анхааръя. Агуулга нь ойлгогдож байна, тийм ээ.

21. Тогтоолын төслийн хавсралтын зорилт 6.4 дэх хэсгийн 6.4.12 дахь заалтын “механизмыг” гэснийг “үйл ажиллагааг” гэж өөрчлөн, 6.4.11 дэх заалтын “нэгжийг” гэсний дараах “тодорхой тооны мөрдөгчтэйгээр” гэснийг хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Баттөмөрийн Энхбаяр, Санал хураалт.

61 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Механизмын гэдэг чинь заримдаа тогтолцоо болоод л, заримдаа үйл ажиллагаа болоод л яваад байх нь дээ.

22. Тогтоолын төслийн хавсралтын зорилт 7.1 дэх хэсгийн 7.1.8 дахь заалтын “жендерийн мэдрэмжтэй,” гэсний өмнө “хүний эрх,” гэж нэмж, 7.1.5 дахь заалтын “суурилж батлан” гэснийг “суурилсан эсэхийг хянах тогтолцоог бүрдүүлж,” гэж өөрчилж, 7.1.11 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“7.1.11.Төсвийн захирагчийн албан тушаалд нэр дэвшигчдийг бодлого, хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрөөр өрсөлдүүлэх зарчмыг баримтлан сонгон шалгаруулж, төсвийн ерөнхийлөн болон төвлөрүүлэн захирагчид нэр дэвшигчийн сонголыг зохион байгуулж хэвшинэ.” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Баттөмөрийн Энхбаяр, санал хураалт.

59,5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

23. Тогтоолын төслийн хавсралтын зорилт 7.1 дэх хэсгийн 7.1.13 дахь заалтын “төрийн аудитын” гэсний дараа “байгууллага” гэж нэмж, “гаргана” гэснийг “гаргадаг үйл

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 28-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

ажиллагааг тогтмол болгоно” гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Баттөмөрийн Энхбаяр, санал хураалт.

61,9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

24. Тогтоолын төслийн хавсралтын зорилт 7.3 дахь хэсгийн “тусламж, тусгай сангийн” гэснийг “тусгай сан, гадаадын зээл, тусламжийн” гэж, 7.3.5, 7.3.6 дахь заалтыг 7.3.2, 7.3.3 болгон дугаарлалтыг өөрчилж, 7.3.4 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“7.3.4.Эрүүл мэнд, Нийгмийн даатгалын сангийн төсөв, хөрөнгийн удирдлага ил тод, хараат бус, олон нийтийн хяналтад байх тогтолцоог бүрдүүлж, холбогдох яам, агентлаг, үндэсний зөвлөлийн эрх хэмжээ, хяналт, хариуцлагыг нэмэгдүүлнэ.” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Баттөмөрийн Энхбаяр, санал хураалт.

59,5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

25. Тогтоолын төслийн хавсралтын зорилт 8.1 дэх хэсэгт доор дурдсан агуулгатай 8.1.6 дахь заалт нэмэх:

“8.1.6.Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх төсвийн зарлага, төрийн оролцоог үе шаттай бууруулж, Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийг шинээр байгуулахыг хязгаарлана.” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Мөнх-Оргил, санал хураалт.

61,9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

27. Тогтоолын төслийн хавсралтын зорилт 9.4 дэх хэсгийн 9.4.2 дахь заалтын “болгож, контентыг шүүлтүүртэй” гэснийг хасах. Санал

гаргасан Улсын Их Хурлын гишүүн Баттөмөрийн Энхбаяр, санал хураалт.

63,4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Энэ нөгөө сошиалын хуулийг л батална гэсэн агуулга гэж ойлгогдоно.

28. Тогтоолын төслийн хавсралтын зорилт 9.5 дахь хэсгийн 9.5.1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“9.5.1.Төрийн албан хаагч, удирдах албан тушаалтнуудад авлигын эсрэг сургалтыг үе шаттай зохион байгуулах, ёс зүй, манлайллын хөтөлбөр хэрэгжүүлнэ.” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Баттөмөрийн Энхбаяр, санал хураалт.

58,5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

29. Тогтоолын төслийн хавсралтад доор дурдсан агуулгатай Зорилго 11 нэмэх:

“Зорилго 11.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх, хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, тайлагнах, зохион байгуулалт, удирдлагын тогтолцоог сайжруулна.

Зорилт 11.1.Хөтөлбөрийн хэрэгжилтийн зохион байгуулалт, тайлагналт, хяналт-шинжилгээ, үнэлгээний үр нөлөөг дээшлүүлнэ.

11.1.1.Монгол Улсын Засгийн газар Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг баталж, санхүүжүүлнэ. Яам, агентлаг, нутгийн өөрөө удирдах болон захиргааны байгууллага, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн авлигатай тэмцэх үйл ажиллагааны хэрэгжилтийг уялдуулан зохицуулах, хяналт тавих чиг үүргийг Засгийн газар хариуцан ажиллана.

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 28-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

11.1.2. Авлигатай тэмцэх газрын бүтцэд хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах, дэмжлэг үзүүлэх, хяналт тавих, тайлан мэдээг нэгтгэн хэрэгжилтийг үнэлэх, зөвлөмж өгөх, иргэд, олон нийтэд мэдээлэл хүргэх чиг үүрэг бүхий Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх Ажлын алба ажиллана.

11.1.3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилт хариуцсан байгууллагууд хэрэгжилтийн тайланг жил бүрийн 02 дугаар сарын 01-ний дотор Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Авлигатай тэмцэх газарт тус тус хүргүүлнэ.

11.1.4. Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Авлигатай тэмцэх газар нь Хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг нэгтгэн хэрэгжүүлэгч байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үр дүнг үнэлэн, санал, дүгнэлтээ Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороонд танилцуулна.

11.1.5. Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо тайлан, үнэлгээ, санал, дүгнэлтийг хэлэлцэж, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, зөрчлийг арилгах, ажлаа эрчимжүүлэх талаар чиглэл өгч болно.” Санал гарсан Улсын Их Хурлын гишүүн Баттөмөрийн Энхбаяр, санал хураалт.

63,4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

ХЗБХ дэмжээгүй санал байна.

1. Тогтоолын төслийн хавсралтын зорилт 7.1 дэх хэсгийн 7.1.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“7.1.2. Тухайн жилийн Төсвийн тухай хуулийг эрх бүхий байгууллагаас боловсруулж өргөн мэдүүлэх, хэлэлцэн батлахдаа төсвийн ерөнхийлөн захирагч бүрийн төвлөрүүлэх орлого, зарцуулах зардлыг нийт дүнгээр нь, түүнчлэн эдийн засгийн ангилал,

төрөл, зориулалт тус бүрээр тусгана.” Санал гарсан Улсын Их Хурлын гишүүн Баттөмөрийн Энхбаяр. Санал хураалт.

51,2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2. Тогтоолын төслийн хавсралтын “Зорилго 8” гэснийг “Зорилго 3” болгон өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Мөнх-Оргил. Санал хураалт.

63,4 хувийн саналаар санал дэмжигдсэн юм байна шүү дээ, Байнгын хорооны санал дэмжигдсэн байна.

Найруулгын санал.

1. Тогтоолын төслийн хавсралтын зорилт 1.2 дахь хэсгийн 1.2.1 дэх заалтын “төлбөргүй” гэсний өмнө “үнэ” гэж, зорилт 9.2 дахь хэсгийн 9.2.1 дэх заалтын “төлөвшүүлнэ” гэсний өмнө “олон нийтэд” гэж, зорилт 9.4 дэх хэсгийн 9.4.4 дэх заалтын “Боловсролын” гэсний дараа “сургалтын” гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Баттөмөрийн Энхбаяр, санал хураалт

58,5 хувийн саналаар санал дэмжигдлээ

2. Тогтоолын төслийн хавсралтын зорилт 1.5 дахь хэсгийн 1.5.3 дахь заалтын “зохицуулалт, механизмыг” гэснийг “зохицуулалтыг” гэж, зорилт 3.1 дэх хэсгийн 3.1.3 дахь заалтын “тавих” гэснийг “тавигдах” гэж, зорилт 3.2 дахь хэсгийн 3.2.4 дэх заалтын “иргэдийн шууд хяналт, мониторинг хэрэгжүүлэх” гэснийг “иргэд шууд хяналт тавих боломжийг” гэж, зорилт 3.3 дахь хэсгийн 3.3.2 дахь заалтын “дэмжлэг” гэснийг “тусламж” гэж, зорилт 5.1 дэх хэсгийн 5.1.6 дахь заалтын “батлагдсан төсвийн хэмжээнээс” гэснийг “батлагдсан төсвөөс” гэж, зорилт 5.4 дэх хэсгийн 5.4.4 дэх заалтын “хүний нөөцийн чадавхыг бий болгоно” гэснийг “хүний нөөцийг бэхжүүлнэ” гэж, зорилт 6.2 дахь

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 28-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

хэсгийн 6.2.3 дахь заалтын “яллах ажиллагаа дахь” гэснийг “яллах ажиллагааны явцад” гэж, мөн заалтын “эзэмшүүлнэ” гэснийг “эзэмших нөхцөл боломжийг бий болгоно” гэж, 6.2.4 дэх заалтын “гадаад оронд” гэснийг “гадаад улсад” гэж, зорилт 6.4 дэх хэсгийн 6.4.5 дахь заалтын “ил тод байдлыг бий болгох” гэснийг “ил тод байдлыг бий болгоно” гэж, 6.4.9 дэх заалтын “санхүүгийн мэдээлэл,” гэснийг “санхүү, орлогын эх үүсвэрийн” гэж, зорилт 7.1 дэх хэсгийн “Төсвийн төлөвлөлтийг” гэснийг “Төсвийн төлөвлөлтийн тогтолцоог” гэж, мөн хэсгийн “оролцоог хангаж, тогтолцоог” гэснийг “оролцоог хангах замаар” гэж, зорилт 7.2 дахь хэсгийн 7.2.2 дахь заалтын “зохион байгуулж” гэснийг “зохион байгуулдаг тогтолцоог бүрдүүлж,” гэж, 7.2.3 дахь заалтын “данснаас хассан” гэснийг “данснаас хасагдсан” гэж, зорилт 7.4 дэх хэсгийн 7.4.3 дахь заалтын “цахим хэлбэрт бүрэн шилжүүлнэ” гэснийг “бүрэн цахимжуулна” гэж, зорилт 8.4 дэх хэсгийн 8.4.2 дахь заалтын “нээлттэй сонсгол” гэснийг “нийтийн сонсгол” гэж, зорилт 9.3 дахь хэсгийн 9.3.1 дэх заалтын “Бүх шатны сургалтын” гэснийг “Бүх түвшний сургалтын” гэж, зорилт 9.4 дэх хэсгийн 9.4.3 дахь заалтын “зүйлсийг бууруулах дүн шинжилгээ хийнэ” гэснийг “зүйлсэд дүн шинжилгээ хийж, бууруулах арга хэмжээ авч хэрэгжүүлнэ” гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Баттөмөрийн Энхбаяр, санал хураалт.

61 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3. Тогтоолын төслийн хавсралтын зорилт 1.2 дахь хэсгийн 1.2.1 дэх заалтын “эдгээрийг амлах” гэснийг өмнөх “эсхүл” гэснийг, 2.4 дэх хэсгийн “хууль,” гэснийг, 5.4.4 дэх заалтын “шаардлагатай” гэснийг, 6.2 дахь хэсгийн 6.2.3 дахь заалтын “олон улсын” гэснийг хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Баттөмөрийн Энхбаяр, санал хураалт.

58,5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4. Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн бүтэц, нэр томъёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл, заалтын дугаар, эшлэлийг нийцүүлж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Баттөмөр Энхбаяр, санал хураалт.

56,1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Зарчмын зөрөөтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа.

“Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүллээ.

16.05 цаг

Залгуулаад **“Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.**

Төслийн талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Дамдины Цогтбаатар танилцуулна.

Д.Цогтбаатар: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдөр “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэнтэй холбогдуулан АТГ-аас 2023 оны 015902 тоот албан бичгээр уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд Монгол Улсын Их Хурлын 2019 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн 67 дугаар тогтоолд өөрчлөлт оруулах талаар санал ирүүлсэн болно.

Авлигын эсрэг хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэгт Авлигатай

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 28-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

тэмцэх газрын зохион байгуулалтын бүтэц, орон тоог Улсын Их Хурал батлах гэж заасны дагуу ХЗБХ “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулсан бөгөөд 2023 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 93 дугаар зүйлийн 93.1 дэх хэсэгт заасны дагуу тогтоолын төслийг хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийг хэлэлцэх явцад тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй бөгөөд Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 60 хувь нь “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж батлуулах нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн иийдвэрлэж, тогтоолын төслийг баталж өгөхийг та бүхнээсээ хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гишүүд. Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу. Алга байна.

Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Авлигатай тэмцэх газрын Тамгын хэлтсийн дарга, эрхэлсэн комиссар Загараагийн Баасаням, тус газрын Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн ажлын албаны дарга, эрхэлсэн ъомиссар Доржсүрэнгийн Дуламсүрэн, тус газрын Судалгаа, шинжилгээний албаны дарга, эрхэлсэн комиссар Цэдэнишийн Шинэбаяр, тус газрын Мөрдөн шалгах хэлтсийн 3 дугаар албаны дарга, ахлах комиссар

Чимэддоржийн Жаргалбаатар, тус газрын Хяналт шалгалт дүн шинжилгээний хэлтсийн Мэдүүлгийн бүрдүүлэлт, дүн шинжилгээний албаны дарга, ахлах комиссар Батмөнхийн Баярсайхан, тус газрын Судалгаа шинжилгээний албаны ажилтан, комиссар Лхагважавын Хангарди.

Байнгын хорооны саналаар “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна.

Гишүүд суудалдаа сууя. Гадаа байгаа гишүүдийг оруулъя.

Сая үндэсний хөтөлбөрөөр дэмжигдсэн саналын дагуу энэ нөгөө орон нутгийн орон тоо нэмэгдэж байгаа л асуудал байх. Итгэлцүүлж. Санал хураалт.

53,7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Та өгсөн гэж, та угаасаа ирцэд алга байна. Наад эхлээд картаа уншуул. Карт уншаагүй юм чинь яаж байх юм. Хурууны хээгээ уншуул. Одоо ингээд гадагшаа, дотогшоо дэмий тэнэсээр байгаад энэ карт чинь хүртэл танихаа больсон байна шүү. Үүн дээрээ анхаарч ажиллаарай та. Сая Казахстан яваад ирсэн үү, яасан удаан явдаг юм.

Ингээд 53,7, хувийн саналаар санал дэмжигдсэн. Тогтоолын төсөл батлагдлаа.

16.10 цаг

Дараагийн асуудалд орно.

Боловсролын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулна.

Улсын Их Хурлын гишүүн, МАН-ын бүлгийн дарга Дуламдоржийн Тогтохсүрэн гишүүн завсарлага авсан. Завсарлагын хугацаа дууссан байна. Үг хэлэх үү? Дуламдоржийн Тогтохсүрэн гишүүн үг хэлнэ.

Д.Тогтохсүрэн: Өнгөрсөн 7 хоногт Боловсролын ерөнхий хуулийг Улсын Их Хурлын нэгдсэн чуулганаар анхны хэлэлцүүлэг хийх явцад гишүүдийн дунд байр суурийн зөрөөтэй байсан учраас санал бодлыг нэгтгэх зорилгоор МАН-ын бүлэг ажлын 3 өдрийн завсарлага авсан. Завсарлагын хугацаанд бүлэг хуралдаж, саналаа нэгтгэсэн тул бүлгийн завсарлагын хугацаа дууссан гэдгээ хэлье. Тийм учраас чуулган үргэлжлүүлэхийг хүсэж байна. Баярлалаа.

Г.Занданшатар: Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрөөтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна. Зарчмын зөрөөтэй 9 санал байгаа. Манай Чинзориг гишүүн чинь кнопоо дарчхаад тэгээд үгээ хэлээрэй, асуултаа асуухаараа ямар асуудал хэлэлцэж байгаа вэ гэж асуудаг байгаа юм.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо дэмжсэн саналаар санал хураалт явуулъя.

1. Энэ чинь хэд дэх нь юм бэ?

1. Төслийн 12 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“12 дугаар зүйл. Багш ажилтны мэргэжлийн хөгжлийн тогтолцоо

12.1 Багш, ажилтан нь боловсролын хууль тогтоомж, Хөдөлмөрийн тухай хуулийн 17.6-д заасан ажил мэргэжлийн стандарт, албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргийг хэрэгжүүлнэ

12.2 Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангид багш мэргэжлийн сонгон бүлэг хичээллүүлж, амжилттай төгсөгчийг багш бэлтгэх дээд боловсролын сургалтын байгууллагад элсэн суралцахад нь төрөөс дэмжлэг үзүүлнэ

12.3. Энэ хуулийн 12.2-т заасан дэмжлэг үзүүлэх журмыг Засгийн газар батална

12.4 Багш, ажилтны мэргэжлийн хөгжлийн үйл ажиллагаа, багш мэргэжлийн сонгон бүлэг байгуулах журам, сургалтын хөтөлбөр тавих шаардлагыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална

12.5. Дээд боловсролын сургалтын байгууллага магадлан итгэмжлэгдсэн хөтөлбөрөөр багшийг бэлтгэнэ. Багшаас бусад мэргэжилтэй иргэн багш бэлтгэх хувилбарт сургалтад хамрагдан багшаар ажиллаж болно

12.6 Багш бэлтгэх сургалтын хөтөлбөр нь энэ хуулийн 5.1.4-д заасан зарчимд үндэслэсэн Хөдөлмөрийн тухай хуулийн 17.6-д заасан ажил мэргэжлийн стандартад нийцсэн байна

12.7 Багш бэлтгэх сургалтын хөтөлбөрөөр амжилттай суралцсан суралцагчид сургалтын төлбөрийн хөнгөлөлт, дэмжлэг төрөөс үзүүлнэ

12.8 Сургуулийн өмнөх ерөнхий боловсрол, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын багш нь багшлах эрхийн гэрчилгээтэй байна

12.9 Багшийн хөгжлийг дэмжих тухай хуулийн 8.5-д заасан багшлах эрхийг энэ хуулийн 12.8-д заасан багшлах эрхийн гэрчилгээтэйд тооцно

12.10 Цэцэрлэг, Ерөнхий боловсролын сургуулийн сул орон тоонд аймаг, сум, баг, дүүрэг, тосгоны

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 28-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

удирдлагын захиалгаар, эсхүл өөрийн хүсэлтээр 3-аас доошгүй жил мэргэжлээрээ ажиллах гэрээ байгуулсан багшид төрөөс дэмжлэг үзүүлнэ

12.11 Багшийн мэргэжлийн хөгжлийн үйл ажиллагааг үндэсний болон орон нутгийн түвшинд тухайн түвшний боловсролын сургалтын байгууллага багш бэлтгэх дээд боловсролын сургалтын байгууллагыг түшиглэн боловсролын харилцаанд оролцогч талуудтай хамтран зохион байгуулна

12.12 Багшийн мэргэжлийн хөгжлийн цахим системтэй байна

12.13 Багшийн хөгжлийг дэмжих тухай хуулийн 3.1.3-д заасан төв нь багш, ажилтны мэргэжлийн хөгжлийн үйл ажиллагааг зохион байгуулах бие даасан нэгжтэй байх бөгөөд нэгжийн жишиг бүтэц орон тоог боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална

12.14 Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, Ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсролын сургууль, Политехникийн коллежийн багш, удирдах ажилтныг өөртэй нь тохиролцсон тухайн аймаг, сум, дүүрэг, баг, тосгоны боловсролын сургалтын байгууллагын адил чанарын өөр ажилд шилжүүлэн ажиллуулж болно

12.15 Энэ хуулийн 12.14-т заасан багш, удирдах ажилтныг шилжүүлэн ажиллуулах хугацаа журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална

12.16 Багш бэлтгэл дээд боловсролын сургалтын байгууллагын төгсөх ангийн суралцагчийг цэцэрлэг, Ерөнхий боловсролын сургуулийн багшийн сул орон тоонд Хөдөлмөрийн тухай хуулийн 62 дугаар зүйлд заасан дагалдан багшаар ажиллуулж болно.

12.17 Багш нь үндсэн ажлын цагаас бусад цагт өөр ажил олгогчтой

зэрэгцсэн хөдөлмөрийн гэрээ байгуулж, нэмэлт орлого олж болно. Энэ харилцааг Хөдөлмөрийн тухай хуулийн 57 дугаар зүйлд заасны дагуу зохицуулна. Санал гаргасан Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо, санал хураалт явуулъя. Санал хураалт.

61 хувийн саналаар дэмжлээ.

Боловсролын яамны Хуягцогт яагаад хоцроод байна? Хуягцогт гуай. Энэ ажлын хэсэг Боловсролын хуулийн ажлын хэсэг харин их сүрхий, боловсролын багшийн үнэлэмжийг сайжруулах бэлтгэх талаар бас сүрхий санал, санаачилгууд гарч бас сайн ажилласан байгаа шүү. Бас ч гэж.

2 төслийн 13 дугаар зүйлийн 12.2.11 дэх заалтын “ажил хаялт” гэснийг “суралцагчийн эрхийг зөрчих” гэж өөрчилж, мөн заалтын “удирдах ажилтан” гэсний өмнө “багш” гэж, 13.2.12 дахь заалтын “асран хамгаалагч” гэсний дараа “харгалзан дэмжигч” гэж, 13.3.3 дахь заалтын “нийгмийн ажилтан” гэсний дараа “хоол зүйч, сэтгэл зүйч” гэж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 13.2.17, 13.2.18, 13.2.19, 13.3.7, 13.3.8 дахь заалт, 13.9 дэх хэсэг нэмэх:

“13.2.17 Суралцагч болон сургалтын мэдээллийг цахим мэдээллийн санд хугацаанд нь бүртгэх, тайлагнах;

13.2.18 Ажлын гүйцэтгэлийн үнэлгээнд хамрагдах үр дүнд үндэслэн мэргэжлийн хөгжлийн хэрэгцээг тодорхойлж, төлөвлөх, хэрэгжүүлэх;

13.2.19 Суралцагч, эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчтэй хамтран ажиллах, зөвлөн туслах;

13.3.7. Дээд боловсролын сургалтын байгууллагын багш, ажилтан өндөр насны тэтгэвэр тогтоолгоход Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу тэтгэмжийг тухайн боловсролын сургалтын байгууллагаас олгох;

13.3.8. Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, Ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн Боловсролын сургууль, Политехник коллежид 15-аас доошгүй жил тасралтгүй ажилласан багш, ажилтны нэг хүүхдийг тэргүүлэх эрэлттэй мэргэжлээр төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагад үнэ төлбөргүй, хөнгөлөлттэй нөхцөлөөр суралцуулах бөгөөд холбогдох журмыг Засгийн газар батлах;

13.9. Боловсролын болон хөдөлмөрийн хууль тогтоомжид зааснаас бусад чиг үүргийг багшаар гүйцэтгүүлэхийг хориглоно.

Санал гаргасан Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо, санал хураалт.

65,9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3. Төслийн “ГУРАВДУГААР БҮЛЭГ”-ийн нэрийг “БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА” гэж өөрчилж, 17 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 19, 20 дугаар зүйлийг төслөөс хасах.

17.1 Боловсролын байгууллага нь боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн үнэлгээний, чанарын баталгаажуулалт-магадлан итгэмжлэлийн, боловсролын сургалтын насан туршийн суралцахуйн төвөөс бүрдэнэ

17.2. Боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллага нь боловсролын бодлогын суурь, хавсарга судалгаа, шинжилгээ, инновац, арга зүйн болон сургалт эрхлэх чиг үүргийг хэрэгжүүлнэ

17.3. Боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллагыг Шинжлэх ухаан технологийн тухай хуульд заасны дагуу байгуулна

17.4. Энэ хуулийн 17.2-т заасан байгууллага нь сургуулийн өмнөх ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, арга зүй, үнэлгээ, сурах бичгийн тохирч нийцлийг шалган турших түшиц цэцэрлэг, Ерөнхий боловсролын сургуультай байж болно

17.5. Боловсролын эрдэм шинжилгээ арга зүйн байгууллага энэ хуулийн 17.4-д заасан түшиц цэцэрлэг, Ерөнхий боловсролын сургуулийг сонгон туршилт зохион байгуулж болно

17.6. Насан туршийн суралцахуйн төв нь иргэний албан, албан бус сургалтаар боловсрол эзэмших, бие даан суралцахад мэдээллээр ханган, зөвлөн туслах, удирдан зохион байгуулах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Насан туршийн суралцахуйн төв нь боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын харьяанд байна

17.7. Насан туршийн суралцахуйн төв нь бичиг үсгийн болон ерөнхий боловсрол нөхөн эзэмшүүлэх сургалтыг төлбөргүй зохион байгуулна

17.8. Энэ хуулийн 17.6-д заасан төв нь танхимын сургалтад хамрагдах боломжгүй Хөгжлийн бэрхиээлтэй хүүхдэд боловсрол, эрүүл мэнд, нийгмийн халамжийн цогц үйлчилгээг төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд заасан түншлэлийн гэрээгээр гүйц хэрэгжүүлж болно

17.8. Боловсролын болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хөдөлмөр нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран хөгжлийн бэрхиээлтэй хүний боловсрол эзэмшихэд дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий дэмжих төв ажиллуулж болно

17.9. Энэ хуулийн 17.8-д заасан дэмжих төвийн үйл ажиллагааны зардлыг боловсролын болон эрүүл мэндийн

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 28-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран санхүүжүүлнэ

17.10. Боловсролын үнэлгээ арга зүйн байгуулга нь боловсролын бүх түвшний үнэлгээ, элсэлтийн шалгалт зохион байгуулах, хүний мэдлэг, чадвар, чадамжийг үнэлэх, хүлээн зөвшөөрөх, баталгаажуулах, үнэлгээний хөгжлийг хангах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

17.11 Энэ хуулийн 17.10-д заасан үнэлгээ, элсэлтийн шалгалтын журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална

17.12. Боловсролын чанарын баталгаажуулалт-магадлан итгэмжлэлийн байгууллага нь боловсролын сургалтын байгууллага, сургалтын хөдөлмөрийн чанарыг эрх бүхий байгууллагын баталсан стандарт шаардлагын дагуу магадлан итгэмжлэх, чанарын баталгаажуулалтыг удирдлага, арга зүйгээр хангах, мэргэжлийн үндэсний шаталсан бүтцийг эрхлэн хариуцах чиг үүргийг хэрэгжүүлнэ

17.13. Энэ хуулийн 17.12-т заасан байгууллага нь магадлан итгэмжлэх хийх эрхийг дотоодын байгууллагад олгох, зөвшөөрлийн тухай хуулийн 8.2 дугаар зүйлийн 7.9-д заасны дагуу гадаадын хуулийн этгээдэд зөвшөөрөл олгох, гадаад улсын болон олон улсын эрх бүхий байгууллагатай хамтран магадлан итгэмжлэл хийх, олон улсад магадлан итгэмжлэгдсэн хөтөлбөрийг баталгаажуулах бүртгэх үйл ажиллагааг хэрэгжүүлнэ

17.14. Энэ хуулийн 17.12-т заасан байгууллага олон улсын гэрээ, хэлэлцээрийн хүрээнд боловсролын зэрэг, баримт бичгийг харилцан хүлээн зөвшөөрөх, судалгаа, үнэлгээ хийх, баталгаажуулах сантай байна.

Санал гаргасан Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо, санал хураалт.

68,3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4. Төслийн 21-26 дугаар зүйлийг 21-24 дүгээр зүйл болон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“21 дүгээр зүйл. Зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгох

21.1. Боловсролын сургалтын байгууллагыг энэ хууль, Зөвшөөрлийн тухай хууль болон холбогдох стандарт, техникийн зохицуулалт, шаардлагад хангасан этгээд байгуулж болно

21.2. Боловсролын сургалт эрхлэх үйл ажиллагаатай холбогдох зөвшөөрлийг Зөвшөөрлийн тухай хуульд заасны дагуу эрх бүхийн этгээд олгоно

21.3 Орон нутгийн өмчийн цэцэрлэг, Ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежийг байгуулах, өөрчлөх, татан буулгах асуудлыг Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд заасны дагуу шийдвэрлэнэ

21.4. Зөвшөөрөл олгосон эрх бүхий этгээд нь Зөвшөөрлийн тухай хуульд заасан үндэслэлээр зөвшөөрлийг түдгэлзүүлж, хүчингүй болгоно

21.5. Гадаад улсад Монгол Улсын үндэсний сургалтын хөтөлбөрөөр боловсролын сургалтын үйл ажиллагаа эрхлэх асуудлыг тухайн улсын эрх бүхий байгууллагын шийдвэрийг үндэслэн Монгол Улсын хилийн чанадад ажиллаж байгаа Дипломат төлөөлөгчийн газар, Гадаад хэргийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

Энэ ингээд зүйл, зүйлээр нь санал хураахгүй ингээд 21-24 гэж Нийгмийн бодлогын байнгын хороо 3 заалтыг нэг хурааж болдог юм уу? Боловсролын

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 28-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

байнгын хороо. Референт нь хэн юм? Үгүй ээ, энэ дэг зөрчиж байгаа юм биш үү? Зүйл, заалт болгоноор. Референт нь байгаа юм уу. Дэгийн тухай хуулиар зүйл, заалт тус бүрээр хэлэлцэж, санал хураалт явуулна гэж байгаа шүү дээ. Энэ чинь 3 зүйлийг нэгтгэж, санал хураалгах гээд байна шүү дээ. 21, 22, 23, 24 гээд 4 зүйл заалтыг нэг заалтаар өөрчилж болох юм уу?

Бусад Байнгын хороо хэрвээ 42.2-оор санал хураалт явуулсан бол дээр нь тэмдэглэдэг юм. 42.2-т заасны дагуу санал хураалт, гүйцээн байгуулах чиглэлийн дагуу санал хураалт. Эсвэл 3-ны 2-оор босгосон гэдгээ дээр нь ингэж бичигдэж байх ёстой.

Энэ зүйлүүдийг багцалж хураадаг ийм саналыг хэн гаргасан юм бэ? Хууль тогтоох ажлыг арай бөөндөөд, хялбарчлаад, арай юу яаж байгаа юм биш үү, энэ чинь. 21-26 дугаар зүйлийг 21-24 дүгээр зүйл болгож өөрчилнө гэдэг ийм санал хураалт хэзээ, яаж, явуулж байсан юм бэ?

Үнэнбат дарга нааш ир.

Мөнхбаатар дарга аа. Гүйцээн боловсруулах чиглэл өгөөгүй юм байна л даа. Тэгэхээр үүнийг та хараадхаач. Байнгын хороон дээрээ тус тусад нь хураасан мөртөө энд ингээд нэгтгээд оруулаад ирсэн гээд байх юм. Байнгын хорооны протоколыг нь үзэх юм уу.

Протоколыг нь үзээд. Тэгээд энэ чинь эцсийн хэлэлцүүлэг байдаг. Үүнийг чинь ингээд орхи. Үүнийг тус тусад нь болгоод хэрвээ Байнгын хороон дээрээ яг тус тусдаа хураасан байна уу гэдгийг Үнэнбат даргын юун дээр. 5 дахь өдөр ирэх 7 хоногт батална. Үүний учрыг олъё.

5 дахь өдөр хүртэл хойшлуулах уу? Үгүй ээ, энэ чинь ингээд. Горимын санал гаргаад яах вэ дээ.

Танайх өмнө нь завсарлага авчихсан, ахиж завсарлага авах эрхгүй байхгүй. 1 удаа сунгана л гэж байгаа болохоос дахиж авах эрх байхгүй.

Дэг л зөрчүүлэх гээд байна.

Ингээд 21 дүгээр зүйлээр санал гаргасан Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо. Сая санал хураалт явуулсан. Тус тусад нь санал хураалт явуулж болохгүй л гээд байна. Тэгээд. Үүнийг түр орхиод энэ магадалгаагаа аваад ир.

Тэгээд дараагийн санал хураалтдаа оръё.

Энэ 3-ыг сүүлд нь хураалгая, болохгүй бол тэгээд бүр хойшлуулъя.

5. Төслийн 33 дугаар зүйлийн 33.1.4, 33.1.6, 33.1.7, 33.1.9 дэх заалт 33.3, 33.4 дэх хэсэг, 33.5.3, 33.6.3 дахь заалтыг хасаж, 33.1.5 дахь заалтын “боловсролын” гэсний дараа “сургалтын” гэж, 33.1.12 дахь заалтад доор дурдсан агуулгатай тайлбар, 33.1.19 дэх заалт, 33.7, 33.8, 33.9 дэх хэсэг нэмж, 33.5.1, 33.6.1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“Тайлбар: Ерөнхий боловсролын сургуулийн хоол, үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн 3.1.4-д заасан “сургуулийн орчин” гэсэн тодорхойлолт, бүх түвшний боловсролын сургалтын байгууллагын орчин хамаарна

33.1.19. зайн болон цахим сургалтын чанар, үр дүнг сайжруулах үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах

33.7 Аймаг, Нийслэлийн боловсролын газрын дарга сонгон шалгаруулалтын дүнг үндэслэн харьяа нутаг дэвсгэр дэх төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэгийн эрхлэгч, Ерөнхий боловсролын сургуулийн захирлыг

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 28-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

томилж, хуульд заасан үндэслэлээр чөлөөлнө

33.8 Нийслэлийн боловсролын газрын дарга дүүргийн боловсролын хэлтсийн даргыг сонгон шалгаруулалтын дүнг үндэслэн томилж, хуульд заасан үндэслэлээр чөлөөлнө

33.9. Боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас баталсан аргачлалын дагуу хамран сургах тойргийг боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллага тогтооно

33.5.1 Боловсролын сургалтын байгууллагад 10-аас доошгүй жил, үүнээс боловсролын сургалтын байгууллагын багш, удирдах эсхүл нийгмийн ажилтнаар 5-аас доошгүй жил ажилласан магистр зэрэгтэй байх

33.6.1 Боловсролын сургалтын байгууллагад 10-аас доошгүй жил, үүнээс боловсролын сургалтын байгууллагын багш, удирдах эсхүл нийгмийн ажилтнаар 5-аас доошгүй жил ажилласан байх

Санал гаргасан Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо.

Дуламдоржийн Тогтохсүрэн Жигжидийн Батжаргал нарын гишүүдээр тасаллаа. Дуламдоржийн Тогтохсүрэн гишүүн үг хэлнэ.

Д.Тогтохсүрэн: Баярлалаа. Энэ саналыг бол яах вэ, дэмжиж байна. Энэ 5 дугаар саналыг.

Би эхлээд 30 дугаар зүйл дээр санал хэлсэн. Дахин боловсруулах чиглэлийг хурал даргалагчаас өгсөн. Тэр юу байна вэ гэхээр бид нар нэг л зүйл тохирсон шүү дээ. Боловсролын салбарын бүх томилгоо төрийн захиргааны томилгоо байна. Боловсролын томилгоог бүгдээрээ улс төрөөс салгана гэсэн. Тэгээд тэр сайд томилж байгаа аймаг, Нийслэлийн боловсролын газрын даргыг Боловсролын

агентлаг томилдог болгож оруулж ирье гээд ингээд ярьсан. Үүнээс бусад нь бол болчхоод байгаа юм. Сургууль, цэцэрлэгийн эрхлэгчийг сонгон шалгаруулалтын дүнг үндэслээд аймаг, Нийслэлийн боловсролын газрын дарга томилж байгаа. Дүүргийнхийгээ нийслэлийнхэн томилж байгаа, энэ болж байгаа юм. Ганцхан нөгөө ТЗ-ийн томилгоо хийгээд байгаа хүмүүсээ улс төр болгочхож байгаа байхгүй юу, буцаагаад. Эргээд дээш нь татаад сайдын харьяанд. Сайд л томилох юм бол энэнээс улс төр арилахгүй байхгүй юу. Бид нарын ганц хүсээж байгаа юм энэ хуулийн шинэчлэл бол бүх боловсролын томилгоо зөвхөн төрийн захиргааны байгууллагынхаа томилгоо явъя. Улс төрөөс салгая гэж ярьчихаад хамгийн сүүлийнхээ томилгоог сайдаар хийгээд.

Энэ дээр би 30 дугаар зүйл дээр санал хэлсэн. Сандаг-Очир гишүүн хэлсэн санагдаж байна. Батжаргал гишүүн хэлсэн санагдаж байна. Хэд хэдэн гишүүн хэлсэн. Хурал даргалагч Мөнхбаатар дэд дарга даргалж байгаад үүнийг чиглэл өгөөд ТЗ-ийн томилгоо болгоё оо гээд чиглэл өгчихсөн байхгүй юу. Гэтэл тэрийг огт оруулж ирээгүй. Хурал даргалагчаас чиглэл өгсөн, Улсын Их Хурлын гишүүд яах гэж үг хэлж байгаа юм гэхээр ажлын хэсэгт дараагийн хэлэлцүүлэг дээр энэ саналыг авч үз гэж бид нар санал хэлж байгаа болохоос биш орхи гэж санал хэлээгүй шүү дээ. Тэгээд энэ нь Боловсролын хууль дээр ажиллаж байгаа бүхэн их гоё шинэчлэл ярьдаг юм байна лээ. Тэгэхээр үндсэн том шинэчлэлийн гол суурь юмаа эвдэх юмаа хийчхээд тэгээд тэрийгээ ингээд оруулж ирэхгүй байгаа байхгүй юу.

Энэ 5 дугаар санал дээр бол ярих юм байхгүй байна л даа. Гэтэл нөгөө чиглэл өгүүлсэн санал огт орж ирээгүй байгаа байхгүй юу.

Г.Занданшатар: Тэгээд чиглэл өгөөгүй санал ороод ирж байгаа юм уу? Жигжидийн Батжаргал гишүүн үг хэлнэ.

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 28-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

Ж.Батжаргал: Энэ саналыг дэмжиж байгаа юм аа. Одоо ер нь ингээд ийм зарчмаараа явах нь зөв гэж. Гэхдээ эрх мэдлийг хэн нэгэнд өгөх бол хамгийн амархан зүйл. Нөгөө талд нь энэ эрх мэдлүүдийн тэнцлийн баланс гэж нэг юм байгаад байгаа юм. Боловсролын газрын дарга чинь сургуулиудынхаа захирлыг томилж болдог юм байж. Сургуулиуд чинь нэгж дээрээ ажиллаж байгаа шүү. Нэгжийнхээ нутгийн удирдлагын байгууллагуудтай яаж ажиллаж, яаж тэр нөхдийг мэдээллээр хангаж, хариуцлага үүрч ажиллах юм гэдэг асуудлыг нь тэнд нь тэнцвэржүүлж өгөхгүй бол болохгүй болчихоод байгаа байхгүй юу. Үүнээс болоод энэ аливаа байгууллагуудын үйл ажиллагаанд харилцан мэдээлэл дутсан, доголдол үүссэн ийм зүйлүүд гарч ирээд болж өгөхгүй байгаа юм. Энэ манайхан нэг юм хийхээрээ ер нь бол хэн нэгэн рүүгээ эрх мэдэл авах сонирхол нь байгаад байдаг. Нөгөө талд нь тэр тэнцэл гэдэг юмыг нь ерөөсөө олж хийж өгдөггүй яваад байдаг. Нэг ийм л зүйл байгаад байгаа. Үүнийгээ та бүхэн тэр нэгжийн хуульдаа дагуулж бодвол жоохон өөрчлөлт хийж байгаа байлгүй дээ, энэ чинь. Би Нэгжийн хуулийг боловсруулахад энэ хэвтээ тогтолцооны удирдлагын бүтцийг их л анхаарал хандуулж баталсан шүү дээ. Тэгээд түүнийг одоо яаж өөрчилж байгаа юм. Энэ хууль дотроо тэр боловсролын байгууллагууд нь нутгийн удирдлагын байгууллагуудынхаа өмнө ямар үүрэг хариуцлагатай ажиллах юм энэ тэр гэдэг юмнууд нь яаж балансжчихсан юм гэдэг юмаа эргэж нэг сайн хараарай. Ер нь үүнийг л би хэлмээр байна

Г.Занданшатар: Мягмар дарга аа, одоо эд нар яг нөгөө гүйцээн босуулах чиглэл өгсөн байна уу гэдгийг бүгдийг нь нягталж шалга. Өөр заалт ороод ирсэн юм шиг ингээд ийм ойлголт явчихлаа шүү дээ.

Энэ дээрээ өгсөн гэдэг нөгөө 44.2-т заасан чиглэлийн дагуу аль эсвэл 3-ны 2-оор энэ тэр гээд заавал бичиж орж ирдэг юм л даа. Энэ ингээд ерөөсөө маш

замбараагүй юм. Шаардлагыг нь бууруулсан юм уу.

Санал хураалт явуулъя. Тэгээд энэ дэмжихгүй үг л хэлээд байх юм. Санал хураалт явуулъя.

Энэ заалтыг нь бол дэмжээд л явах нь зүйтэй гэж хэлсэн шүү дээ, сая Батжаргал гишүүн.

Санал дэмжигдлээ.

6. Төслийн 43 дугаар зүйлийн 43.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“43.2 Хувьсах зардлын хэмжээ, бүрэлдэхүүнийг сургуулийн байриил, мэргэжлийн чиглэл, сургалтын хөтөлбөр, суралцагчийн ялгаатай хэрэгцээг харгалзан суралцах тэгш боломж олгох зорилгоор боловсролын сургалтын байгууллагын түвшин бүрээр тогтоож санхүүжүүлэх журмыг Засгийн газар батална.

Санал гаргасан Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо, санал хураалт.

67,5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

7. Төслийн 43 дугаар зүйлийн 43.4.1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“43.4.1. Холбогдох хууль тогтоомжид заасны дагуу өмчийн хэлбэр үл харгалзан цэцэрлэг, Ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсролын сургууль, политехникийн коллежийн нэг суралцагчид олгох хувьсах зардал.

Санал гаргасан Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо, санал хураалт.

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 28-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

Байнгын хорооны референт нь хэн юм бэ? Зөвлөх референт нь.

67,5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

8. Төсөлд доор дурдсан агуулгатай 43.11 дэх хэсгийг нэмэх:

“43.11. Энэ хуулийн 43.4.1-д заасан зардлыг үндэсний хөтөлбөр хэрэгжүүлж байгаа төрийн бус өмчийн ерөнхий боловсролын сургуульд гэрээний гүйцэтгэлд үндэслэн олгох бөгөөд гэрээний үр дүнгийн шалгуурыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

Санал гаргасан Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо, санал хураалт.

Ер нь сайдын эрх мэдэл бол маш их нэмэгдлээ шүү дээ. Тэгээд тэгэхдээ хариуцлага дагаад л нэмэгдэх байх даа.

67,5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

9. Төслийн 6 дугаар зүйлийн 6.2.1, 6.2.2, 6.2.3 дахь заалт, 6.3 дахь хэсгийг төслөөс хасаж, 6 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 6.5, 6.6 дахь хэсэг нэмэх:

“6.5 Сонсголгүй суралцагчийн боловсрол эзэмших сургалт үйл ажиллагааны хэл нь Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан хэл байна

6.6 Боловсролын сургалтын байгууллага судлах гадаад хэлний сургалтын үндэсний хөтөлбөрийн үзэл баримтлалд заасан хэл байна.

Санал гаргасан Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо, санал хураалт.

Үг хэлье. Аубакир, Дамдинням, Чинбүрэн, Цогтгэрэл гишүүдээр тасаллаа.

Ингээд Дамдинням гишүүн үг хэлнэ. Дамдинням, Чинбүрэн, Аубакир, Цогтгэрэл.

Г.Дамдинням: Энэ 6.6 буюу англи хэл Монгол Улсын Засгийн газраас өргөн баригдсан төсөл дээрээ байгаа. Аубакир гишүүн ээ, би Аубакир гишүүн ээ, хөөе Бакир чи чимээгүй байж бай, би үг хэлж байна шүү дээ. Минутаа дахиад эхэлдэг юм уу, яадаг юм.

Энэ 6.6 дугаар заалт англи хэл Монголын боловсролын үндсэн гадаад хэл байна гэдэг энэ заалт дээр бид нар үндсэндээ хагас сар л үзэж тарцгаалаа даа. Тэгээд би яах вэ, би зүгээр л байгаа цаас баримтуудаа хэлье. Хуулийн төсөл 2021 оны 06 сарын 24-нд өргөн баригдаад Засгийн газраас орж ирсэн энэ танилцуулга байна. Засгийн газраас орж ирсэн танилцуулгын ар тал дээр хамгийн төгсгөлд нь биччихсэн байгаа юм. Англи хэлний боловсрол олгохтой холбоотойгоор үндсэн гадаад хэл нь англи хэл байна гэсэн эрх зүйн зохицуулалтыг тусгах гээд ингээд Засгийн газрын танилцуулга энд байна. Бас хар хайрцгийн бодлого. Тэгээд л геополитик гэж яриад байгаа. Энд бол манай Монгол Улсын Засгийн газрын Гадаад хэргийн яам хариуцлагатай хандах ёстой л доо. Тэгэхээр Гадаад харилцааны сайд буюу Гадаад харилцааны яамнаас 2020 оны 12 сарын 23-ны өдөр 09 5799 тоот бичгээр Боловсролын ерөнхий хууль болон түүнтэй хамт өргөн мэдүүлсэн хуулиудад Гадаад хэргийн сайдаас өгсөн, яамнаас өгсөн санал дээр англи хэлтэй холбоотой ямар ч зүйл байхгүй байгаа юм. Ямар ч зүйл байхгүй байгаа юм.

Дараа нь 2021 оны 06 сарын 21, 2022 оны 10 дугаар сарын 04-ний өдрүүдэд бол манай МАН-ын бүлгээр ороод ингээд дэмжигдээд явчихсан юм байгаа юм. Энэ төсөл багцаараа, тэгээд

яха вэ? Гишүүд маань анзаарсан, анзаараагүй юмнууд гарсан байж магадгүй. Яах вэ, би нэг хэдэн тоо л хэлчихье дээ.

2022 оны статистикаар англи хэлээр ярьдаг 86 орон байна. Энэ 86 орноос 55-д нь англи хэлийг 2 дахь гадаад хэл гэж үзээд боловсролдоо зааж байна. 13-14 улсад үндэсний цөөнхийн хэлний дараа оруулаад 3 дахь хэл болгоод явж байна. Өөрөөр хэлбэл үндсэндээ бараг 100 оронд англи хэл ингээд 2 дахь хэл байна. Хуульдаа байдаггүй гэж яриад байгаа, байгаа юм гэдгийг хэлж байгаа юм.

Дараа нь англи хэлний чанараар энэ бол манай Боловсролын хүрээлэнгээс өгсөн тооцоо юу, судалгаа шүү. Тэгээд яах вэ, Азид манайх 45 орноос 43 дугаар байранд байна. Англи хэлний чанараар. Дэлхийд үнэлгээнд орсон 136 орноос 72 дугаар байранд байна.

Тэгээд эрхэм гишүүд ээ, бие биеийгээ янз янзаар яаж, элдэв буруу ойлголт өгсөн бол бас уучлаарай. Тэгэхдээ яах вэ, зарчмын энэ том өөрчлөлтийг бид нар хийчих хэрэгтэй л байна л даа. Засгийн газрын танилцуулга дээрээ байгаа. Засгийн газрын гадаад харилцаатай холбоотой асуудал дээр байр сууриа илэрхийлэх ёстой Гадаад харилцааны яамнаас дэмжсэн бичиг нь ирчихсэн байж байдаг юм, хуулийн төсөл дээр. Тэгээд Монголын хүүхдүүдэд боловсрол тэгш хүрэхгүй байна гэдэг ийм л дүгнэлтэд бид нар хүрч байгаа. Нэг хэсэг нь элит боловсролтой болоод нөгөө хэсэг нь ингээд л улны гэж яригддаг боловсрол руугаа л яваад байна. Энэ нийгмийг хуваагаад байна гэдэг ийм л зарчмын байр суурь дээрээ би бол зогсоод байгаа юм.

Тэгээд Засгийн газраас өргөн барьсан төсөл. Тэгээд шат шатын 1 дүгээр хэлэлцүүлгээр Байнгын хороо, Их Хурал дээр дэмжигдээд гараад ирсэн санал юм байгаа юм. Тэгэхээр эрхэм гишүүд та бүхэн минь бас Монгол орны ирээдүйд, хувь заяанд оруулах гэж байгаа

томоохон өөрчлөлт гэж хараад Байнгын хорооноос дэмжигдээд ороод ирчихсэн байгаа энэ саналыг дэмжихгүй санал өгч тус болооч ээ л гэж гуйя даа. Өөр юу ярих вэ дээ. Байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжихгүй байна гэдэг нь кнопдоо хүрэхгүй байх эсрэг санал өгөх л гэсэн үг. Баярлалаа, та бүхэнд.

Г.Занданшатар:

Жигжидсүрэнгийн Чинбүрэн гишүүн.

Ж.Чинбүрэн: Баярлалаа. Бид чухал асуудал ярьж байгаа юм. Энд бол бид илүү улс төрч гэхээсээ илүү төрийн зүтгэлтэн байх энэ асуудлыг бид ярих ёстой. Өнөөдөр бид 200 жил манжийн дарангуйлалд байхдаа бид гадаад үндсэн хэл манж хэл гэж сонгоогүй Монголчууд. 70 жил ЗХУ-ын эдийн засаг болон улс төрийн хамааралтай байхдаа бид орос хэлийг үндсэн хэлээ болгоогүй Монголчууд. Монгол хүний зүрх сэтгэлд байдаг энэ эх оронч сэтгэлийг бид хар хайрцгийн бодлого гэж яриад байгаа юм. Тэртээх Монголын дэлгэсэн тэрлэг шиг энэ сайхан газар нутагт таран бутарсан Монголчууд бид амьдрахдаа хилийн захад байгаа айл өрх болгон эх орныхоо хилийг хамгаалдаг энэ сэтгэлгээг хар хайрцгийн бодлого гэж яриад байгаа юм. Түүнээс битгий хар хайрцаг хайгаарай. Тийм юм байхгүй. Монгол хүний зүрх сэтгэлд байгаа тэр эх оронч сэтгэл бол хар хайрцгийн бодлого.

Нөгөө талаасаа ер нь бол бид энэ хэл соёлоороо бид эх орноо Монгол Улсаа өдий зэрэгтэй авч яваа. Дэлхий даяар суурьшин байрлаж байгаа 15 сая Монголчууд байгаа. Түүний гал голомт бол Монгол Улс. Өнөөдөр Монголчууд бид хэлтэй байгаа, МАА-гаа хөгжүүлснээрээ өнөөдөр Монгол соёл одоо хүртэл оршин тогтнож байгаа. Та бүхэн зөвхөн англи хэлийг сургахыг болиулах гэж байна гэдэг өнцгөөсөө битгий ярь. Энэ зааланд сууж байгаа бүх гишүүд Монгол хүүхэд болгоныг англи хэлтэй болгохын төлөө энд сууж байгаа. Нэг ч үгүй гэж хэлэх гишүүн эндээс гарахгүй. Тийм учраас

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 28-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

үндэсний боловсролын бодлогодоо ороод түүнийг нь хуулиар бид хамгаалж өгөөд байхад заавал хуульчлах гээд байгаа санаа ямар зорилго вэ? Үүнийг бас асуумаар байгаа юм.

Өнөөдөр бид Оросын бодлогыг дагах гээд байна гэж байгаа. Үгүй ээ, манай өвөг дээдүүд тэр хүчирхэг эзэрхий байх үед Монгол хэлийг алдахгүйн тулд орос хэлний тэр тулгалтыг бичгээ кирилл үсэг болгоод үндсэн орос хэлээ аваагүй оршиж чадсан Монголчууд. Өнөөдөр та бүхэн хараарай, Буриадууд, Якутууд бүгд үндсэн хэл нь орос хэл болчихсон, сэтгэлгээ нь орос болчихсон. Бид үгүй шүү, бид Монголоороо сэтгэж байгаа. Тийм учраас бид өсвөр үеийнхэн, залуучуудаа Монгол сэтгэлгээгээр үндэсний бахархал болсон энэ Монгол сэтгэлгээ, Монгол хэлээрээ дамжина. Тийм учраас бага насны хүүхдүүдээ балчир наснаас нь авхуулаад өнөөдөр Монгол хэлээ мэдэхгүй, Монголоороо ярьж чадахгүй болж байгаа бол эмгэнэл. Энэ бол эмгэнэл.

Бид шинэ Монгол хүн бий болгоё гэж байгаа бол бид Монголоор сэтгэдэг, Монгол хэлтэй Монголчуудаа бэлдэнэ. Бид ойрын улс төр хийж болохгүй. Бид 100 жил, 500 жил Монгол Улсыг тусгаар тогтнол, энэ биеэ даасан энэ үндэстэн гэдэг энэ соёлыг бид хадгалах тухай яриад байгаа юм. Тийм ээ, би бол таны энэ бодлыг дэмжиж байна. Бид Монголчууд бүгд ижил тэгш сургах боломжийг олгох ёстой. Тэр ч утгаараа энэ хуулийн төсөл бол Монголын хүүхдүүдийг мэдлэгтэй, тэгш сургах боломжийг олгох асуудал юм. Энд ганцхан англи хэлний асуудал биш гэж Энх-Амгалан сайд хэлээд байгаатай би санал 100 хувь нийлж байна. Бид энэ тэгш боломжийг олгохын төлөө энэ том хуулийг ярьж байгаа болохоос бид бага насны хүүхдэд англи хэл сургах нь өнөөдөр чухал асуудал болчихсон юм уу? Ингээж нийгмийг талцуулж болохгүй ээ, бид хариуцлагатай улс төр хийнэ. Үүний төлөө бид энд бас хариуцлагатай суух ёстой л гэж бодож байна.

Магадгүй олон нийтэд таалагдахгүй Чинбүрэнг муулж болно. Тэгэхдээ тусгаар тогтнол, улс эх орныхоо төлөө би муудуулсан ч тоохгүй. Бид 10 жил, 20 жил, 50 жил, 100 жилийн дараа бид Монгол хэлтэйгээ Монголоос нүүдэг Монголчууд биш, Монголдоо цугладаг Монголчууд болохын төлөө бид амьдрах ёстой шүү. Тийм шийдвэр гаргах нь бид нарын, Их Хурлын гишүүний олон түмнээ төлөөлж байгаа Монгол Улсаа төлөөлж сууж байгаа гишүүн болгоны үүрэг хариуцлага гэж харж байгаа.

Өвөр Монголчуудыг та бүхэн хар даа, ямар гутамшигтай байж байна. Хөөрхий, Өвөр Монголчууд уйлж байна шүү дээ. Хичээл нь Хятад хэл дээр, Монголоороо, Монгол хэлээрээ хичээлээ заах боломжгүй болчихсон байж байна шүү дээ. Энэ зөөлөн бодлого үнэхээр геополитикийн бодлого байхгүй юу. Бид үүнийг ярихгүй байж болохгүй шүү дээ. Ярих ёстой. Өнөөдөр бид Монголчууд Монгол хэлтэй байж байж өнөөдөр оршин тогтнож байгаа шүү.

Тэгээд би төгсгөлд нь Зундуйн Дорж гуайн үгийг бүр зориуд хэлье гэж бодож байна. Хэн баян бэ? Хэлтэй, хилтэй, малтай Монголчууд бид баян гэж хэлсэн шүү. Үүнийг бүү мартаарай. Баярлалаа.

Г.Занданшатар: Одонгийн Цогтгэрэл гишүүн.

О.Цогтгэрэл: АН, АН-ын бүлэг анхнаасаа яагаад энэ англи хэлийг үндсэн гадаад хэл байх ёстой гэдэг бодлогыг анхнаасаа яагаад тууштай дэмжээд байна вэ? Энэ дээр би нэг 2 зүйл хэлье.

Монголчууд бид нар цөөхүүлээ, дэлхийгээс алслагдсан байна. Сая тэр Чинбүрэн гишүүний хэлээд байгаагийн нь эсрэг Монгол Улсын энэ тусгаар тогтнол, бүрэн эрхийн баталгаа чинь энэ цөөхөн хүн амд мэдлэгтэй, чадвартай, боловсролтой энэ иргэд тэр мэдлэгтэй, чадвартай, боловсролтой болох,

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 28-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

дэлхийтэй хөл нийлүүлэн алхана гэдэг чинь яалт ч үгүй англи хэлтэй холбоотой болчихжээ. Тэгэхээр энэ Монгол Улсын тусгаар тогтнолын энэ бүрэн эрхт байдлын эрх чөлөөт иргэдийн баталгаа чинь магадгүй яван явсаар энэ англи хэлтэй бүрэн дүүрэн холбоотой болчихжээ. Ийм учраас АН үүнийг бүрэн дүүрэн дэмжиж байгаа юм.

2 дугаарт нь, боловсролын ялгаа чинь явсаар явсаар байгаад ажил амьдралын ялгаа бүр нийгмийн анги, давхарга үүсэх ийм үндэс суурь аа. Тэгэхээр тэр боловсролын ялгаа үүсэх тэр суурь нөхцөл байдал чинь яг энэ хууль батлагдахгүй бол боловсролын ялгаагаар дамжиж амьдралын ялгаа үүсэх нөхцөл байдал чинь яг эндээс үүсэх гээд байна. Нийгмийн ялгаралд картын систем рүү Монгол Улсыг маш хүчтэйгээр түлхүү оруулах ийм бодлого бодлого болоод ийм үр дагавар үүний цаана гарах гэж байна.

Хэдийгээр мэдээж бэлтгэл ажлын хувьд олон зүйл мэдээж байгаа байх. Баги боловсон хүчний хувьд. Тэгэхдээ бүхэл бүтэн улсын магадгүй бараг хамгийн тэргүүлэх бодлогын хөгжил дэвшлийн үндэс чинь үүний цаана л байна гэж бид бүгд бас үзэж байгаа. Ийм учраас яг энд чуулганд оролцож байгаа энэ олонхын бүлгийн гишүүд бас яг кнопдоо хүрэхгүй байж, одоо орж ирж байгаа энэ заалтыг унагааж, англи хэлийг үндсэн гадаад хэл байх бодлогыг та бүхэн бас дэмжиж өгөөч.

Нөгөө талаараа энэ хэрвээ ингээд дэмжигдэхгүй бол намын бодлогын хүрээнд танай хувьд дэмжигдэхгүй бол 2024 оны Улсын Их Хурлын сонгуульд магадгүй энэ АН-ын мөрийн хөтөлбөрийн үндсэн амлалт заалтуудын нэг нь англи хэл. Үндсэн гадаад хэл байна. Үүнийг бага ангиасаа орно оо. Энэ нь Монгол төрийн бодлого маш хүчтэйгээр шингэж төсөв санхүү бүхий л зүйлийг ийшээ чиглүүлэх болно.

Хэрвээ АН засаглах, ийм учраас АН бас засаглах ёстой. Энэ бодлого хэрэгжих ёстой гэдэг ийм үүрэг амлалтыг авах нь зүйтэй гэж хүртэл манай АН-ын удирдлага бүлгийн хүрээнд энэ асуудлыг ярилцаж байгаа. Тийм болохоор энэ бодлогыг кнопдоо хүрэхгүй байж энэ орж ирж байсан энэ заалтыг унагааж өгөөч ээ гэж хүсэж байна.

Г.Занданшатар: Аубакир гишүүн.

Т.Аубакир: Баярлалаа. Энэ хэлний асуудал бас яах аргагүй чухал л даа. Яагаад гэвэл бид нар чинь Баян-Өлгий аймагтаа бас үндэсний цөөнхтэй. Одоо ухаандаа 1 дүгээр ангид орсон хүүхэд маань тэр хугацаанд 1, 2, 3, 4 дүгээр ангидаа 3 цагаан толгой л үзэх нь л дээ, манай аймгийн хүүхдүүд. Эхлээд эх хэл дээрээ 1 дүгээр ангидаа орно. Тэрнийхээ цагаан толгойг цээжлээд дөнгөж байж байтал албан ёсны хэл төрийн хэл гээд Монгол хэл маань бас давхар орж байгаа. Ингээд залгаад дахиад англи хэл орж ирэх нь л дээ. Энэ маань яг эрдэм, одоо юу гэдэг юм? Эрдэмтдийн хэлж байгаагаар яг шинжлэх ухаанчаар гарсан ийм шийдвэр янз бүрийн юмнууд бий юу? Бид нар энийгээ тал талаа бодохгүй бол англи хэлтэй байх нь зөв. Одоо бид нар жишээлбэл 10 жилдээ орос хэл үзээд л явсан, муудсан барьсан юм алга. Тийм учраас энэ бас давхар 2 хэл ордог бас үндэсний онцлогийг бас харгалзаж үзсэн тооцоо янз бүрийн юмнууд байгаа юу.

Тийм учраас энэ асуудалд бас бодлоготой, бодолтой хандаач ээ гэсэн ийм санал хэлэх гээд байгаа юм. 3 цагаан толгой л цээжлэх нь байна шүү дээ. Тийм, казах хэлээ үзэхгүй байна гэж бол байхгүй л дээ. Тэгвэл Үндсэн хууль зөрчинө. 8.1, 2 дугаар заалтыг бүдүүлгээр зөрчинө гэсэн үг. Эх хэл дээрээ боловсролоо авна. Төрийн хэл Монгол хэлийг заавал сурна. Ингээд англи хэл орж ирэх нь ээ гэсэн асуудал байгаа юм. Тийм учраас энэ дээр гишүүд маань бас бодолтой хандаарай гэж хэлье.

Г.Занданшатар: Ер нь энэ улс төржүүлээд энэ олон улсын цаг байдал хурцадмал үед олон улсын асуудал болгоод байх асуудал биш. Энэ шинжлэх ухааны асуудал. Энэ дээр бас дэгийн зөрчлүүд ч гэсэн ингээд гарч байна. Энэ Үндсэн хуулийн энэ асуудал яагаад үүсээд байгаа вэ гэхээр Үндсэн хуулийн 16.7, 8.1, 22 дугаар зүйлийн Үндсэн хуулийн 2 дугаар зүйлийн 1 дэх хэсгүүдтэй зөрчил үүсгэж болзошгүй байна. Өөрөөр хэлбэл төрөөс тавьсан шаардлагад нийцүүлж хувийн сургууль ажиллуулж болно гэж байгаа юм жишээлбэл. Ингэх юм бол англи хэл гээд заавал бүх хүн тулга, англи хэлийг бол бүгд дэмжиж байгаа. Дэлхий нийтийн хэл, англи хэлийг дэмжихгүй гэсэн хүнд энд нэг ч хүн байхгүй, нэг ч нам байхгүй, нэг ч боловсрол, соёл, ухааны юм байхгүй. Харин үүнийг улс төржүүлээд тэмээ, бух 2-ыг зодолдуулж байгаа юм шиг ингэж ярьж байгаа нь өөрөө харин энэ үндэсний эрх ашигт нийцэхгүй асуудал.

1 дүгээрт, энэ Монгол хэлийг хүн сурах ёстой. 1 дүгээр ангиасаа англи хэл үзээд эхлэх юм бол Монгол цагаан толгой, англи цагаан толгой, аль эсвэл кирилл үсгээ латин үсэгт шилжих юм уу гэж асуудал. Цаашлах юм бол үндэсний цөөнхийн асуудал гарч байна. Казах хэл үзэхгүй англи хэл үзэх юм уу аль эсвэл казах хэлээ үзээд, англи хэл үзээд, Монгол хэл үзэхээ боль гэж байгаа юм уу.

Монгол хэлээ л дэмжье гэсэн тийм үндэсний аюулгүй байдал, үндэсний бодлого байдаг болохоос биш энэ чинь дэлхий нийт технологийн 4 дүгээр хувьсгалд хэл сурах асуудал ч гэсэн хамаагүй хялбарчлагдаж байгаа. Энэ харин ямар бодлого вэ гэдэг асуудал үүсэж байна гэж энэ яриад байгаа юм л даа. Тийм учраас жишээлбэл Монгол Улсад явж байгаа 2 дахь хэл, гадаад хэл, үндсэн хэлээ ингээд хуульчлаад шууд тулган шаардчих юм бол Монгол Улсад явуулж байгаа Герман, Франц, Хятад, Орос, Япон, Солонгос сургуулиуд бүгд хаагдахад хүрнэ гэж байгаа юм. Үүнийг л олон улсын асуудлууд ярьж байгаа юм.

Яагаад гэвэл тэр улсууд чинь Хятад хэл заахгүй, англи хэл заагаад тэгээд дараа нь Хятад хэл заана гэх юм уу аль эсвэл Хятад, англи хэл заагаад 3-д нь Монгол хэл үзүүлнэ гэх гэж байгаа юм уу. Ийм Үндсэн хуулийн зөрчилтэй асуудал үүсгээд байгаа учраас энэ чинь бүлгийн хурлаар Үндсэн хууль зөрчиж болохгүй юм. Харин энэ дэлхий нийтээрээ сургалтын хөтөлбөрөөр энэ асуудлыг шийдэж байна. Технологийн 4 дүгээр хувьсгал дээр орчуулдаг тоног төхөөрөмж гарчихсан байна. Тэгэхдээ орчуулагчийг орлож чадахгүй. Яагаад гэвэл эх хэлний нюансыг орчуулж чадахгүй, эх хэлээ эхлээд сайн сурах ёстой гэсэн ийм шаардлагууд тавигдаж байгаа юм.

Ийм учраас үүнийг ярьж байгаа учраас үүнийг нэг аль нэг хэлэнд хайртай, аль эсвэл аль нэг улсын тулган шаардалт болгож байгаа юм шиг ингэж улс төржүүлж, өөрсдийнхөө улсыг энэ олон улсын асуудалд оруулж ингэж хайруулын таваг дээр шарж ингэж олон түмнийг талцуулах ёсгүй. Ийм учраас үүнийг тал талдаа их зөв ойлгож, үүнийг англи хэлээ дэмжинэ. Тэгэхдээ тэнд хүүхэд франц хэл сурахыг, энд хүүхэд солонгос хэл сурахыг, энд япон хэл сурахыг шууд хориглож болохгүй, бас. Сургалтын хөтөлбөрөөрөө тэр сургалтын хөтөлбөрөө өөрийн онцлогт сурсан сургуулиуд байж болно гэж үзэж байна шүү дээ.

Цөөнхийн хэлээ бид нар үгүйсгэж болохгүй. Цөөнхийг хүндэтгэх ёстой ардчиллын зарчим. Ийм олон нюанс дотор чинь дэлхий нийт даяараа энэ сургалтын хэлийг, сургалтыг хөтөлбөрөөрөө зохицуулаад 1-ээс нь заах ёстой юу, 2-оос нь заах ёстой юу, 3-аас нь заах ёстой юу гэдгийг. Харин энэ сургалтын тэгш боломжийн асуудал. Энэ хүүхэд болгонд энэ хэлийг ч бай боловсролыг тэгш боломжоор хангах асуудал. Яагаад тэр Баян-Өлгийд ч бай, Увсад сурч байгаа хүүхдүүд энэ хотод сурч байгаа хүүхэдтэй адил боломж боловсрол эдэлж болохгүй байгаа юм. Энэ боловсролын реформын гол чиглэл байх ёстой. Хүүхэд

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 28-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

болгонд тэгш боломж олгох, ардын хүүхдийг илүү сургах тэгш боломжоор хангах энэ асуудал чинь зөвхөн хэл гэлтгүй математик, физик, танин мэдэхүйн шинжлэх ухаантай холбоотой асуудал л даа. Тэгээд үүнийг ингээд улс төрийн сэдэв болгоод улс төржүүлээд байх шаардлагагүй. Энэ бол шинжлэх ухааны асуудал юм гэдгийг бас тодруулж хэлмээр байна.

Тамгын газар сая юу ирүүлээ. Энэ хуулийн зөрчилтэй сая 26-аас 21-ээс зүйл заалт болгоноор хэлэлцэх ёстой асуудлыг бөөнд нь оруулж ирсэн байна, тийм ээ. Энэ Боловсролын байнгын хороо энэ асуудлууд дээр маш хариуцлагагүй хандсан байна шүү. Ерөөсөө дандаа ингээд багц багцаар нь баахан саналууд оруулаад ирчихсэн. Аль нь аль дотроо явж байгаа. Энэ санал дээр ч гэсэн жишээлбэл Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг оруулаад ирчихсэн. Энэ саналыг дэмжихгүй унагаалаа гэхэд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжихгүй болгох саналтай болгох юм, зөрчилтэй.

Ийм учраас энэ асуудлууд чинь ерөөсөө, тэр 21-ийн ,26 чинь зөрчилтэй байгаа биз. Үнэнбат аа. Үнэнбат дарга аа. 21-26 тэгж багцалж санал хураадаг, багцалж зүйл, заалт болгоноор санал хураалт явуулна гэсэн дэгийн хуультай, тийм зарчимтай тэгж мөрдөгдөж ирсэн.

Тийм учраас энэ хуулийн зөрчилтэй асуудал учраас үүнийг хойшлуулъя.

Энэ өмнөх 3 заалттайгаа хамтдаа энэ дэгийн зөрчлөө гаргаж, Байнгын хороо ахиж хуралд, шаардлагатай бол.

Ингээд дараагийн асуудалд орно.

Ер нь бол Монгол хүн бэлтгэх сургалтын хөтөлбөр дэлхийн түвшний боловсролтой Монгол хүн бэлтгэх ёстой шүү.

17.01 цаг

Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Жадамбын Бат-Эрдэнэ танилцуулна.

Ж.Бат-Эрдэнэ: Улсын Их хурлын дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 05 дугаар сарын 25-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн

Г.Занданшатар: Уучлаарай, Бат-Эрдэнэ дарга аа. Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үргэлжлүүлэн явуулах юм байна.

Дарааллаараа тэр байгаа биз, тийм ээ. **Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулна.**

2023 оны дөрөвдүгээр сарын 27-ны өдөр Ардчилсан намын бүлэг 1 хоногийн завсарлага авсан. Завсарлагын хугацаа дууссан байна. Үүнтэй холбогдуулж үг хэлэх үү? Үг хэлэх хүн алга байна.

Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрөөтэй саналын томьёоллоор үргэлжлүүлэн санал хураана.

Төмөр замын тээврийн тухай хуулийн 7 дахь саналаас эхэлж санал хураалт явуулах байх. Тийм ээ. 7 дахь санал дээр зогссон юм байна.

7 төслийн 11 дүгээр зүйлийн 11.1.27 дахь заалтын Төмөр замын тээвэр

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 28-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

зуучлалын гэснийг хасаж, 11.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

11.2.Энэ хуулийн 11.1.1, 11.1.2, 11.1.3-д заасан дүрэм, 11.1.4, 11.1.5, 11.1.7-д 11.1.8, 11.1.9, 11.1.12, 11.1.14, 11.1.17, 11.1.25, 11.1.27-д заасан журам, 11.1.20-д заасан аргачлал, 11.1.21-д заасан нормыг Төмөр замын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн. Энэ хуулийн 11.1.6, 11.1.10, 11.1.11, 11.1.13, 11.1.16, 11.1.18, 11.1.19-д заасан журмыг төрийн захиргааны байгууллага тус тус батална. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт явуулъя.

Бат-Эрдэнэ дарга маань өөрөө хаачив байна.

Ер нь энэ Боловсролын хууль. Тэгээд л ер нь Боловсролын сайдын эрх мэдлийг нэмэгдүүлсэн хууль биш. 9 том б реформ хийж байгаа хууль гэсэн шүү дээ. Тэгээд тэр нь биш ингээд нэг юу тойрсоор байгаад л энэ тэгээд 1 нөгөө б реформ болоод нэг хэлний хууль болоод л, хэлний хууль болсоор байгаад л ингээд байна. Ардын хүүхдийг л тэгш боловсролтой болгоё л гэсэн хууль гэж ойлгоод байгаа шүү дээ.

Өглөөний ирцээрээ хурал үргэлжилнэ.

Үнэнбатаа нааш ир дээ. Энэ Байнгын хороонд өөрчлөлт оруулах тогтоол.

Бат-Эрдэнэ дарга аа, яасан, энэ хариуцсан сайд байхгүй. Хууль санаачлагч байхгүй бол хуулийн төслийг хойшлуулж болж байгаа тийм ээ. Хойшлууллаа.

Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцүүлэг явуулахад хууль санаачлагч үгүй учраас бас хойшлууллаа. Сайд нар нь байх ёстой л доо.

Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Хувийн тэтгэврийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг үргэлжлүүлж явуулна.

Ажлын хэсгийг оруулъя.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүдийн нэрийг бүртгэж авсан байгаа. Нэрийг сэргээе. Асуулттай гишүүдийн нэрийг сэргээе.

Үргэлжлүүлж явуулж байгаа, анхны хэлэлцүүлгийг. Анхны хэлэлцүүлэг танилцагдсан. Асуулт, хариулт үргэлжилж байгаа. Асуулт асуух гишүүдийн нэрсийг бүртгэж авсан. Сэргээж байгаа. 2 гишүүн байгаа юу.

Баттөмөрийн Энхбаяр гишүүн асуулт асууна.

Б.Энхбаяр: Баярлалаа. Энэ хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөл Учрал нарын гишүүдээс 2 жил гаруйн өмнө өргөн баригдаж байсан. Тухайн үед хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэж байх үед миний бие хэлэлцэх эсэхийг нь дэмжиж байна. Тэгэхдээ энэ хувийн тэтгэврийн санг байгуулахдаа одоо байгаа заавал хамруулах нийгмийн даатгалын хувь хэмжээн дээр нэмэх нь сайн дураар 4 хувийн шимтгэл нэмээд тэр нь хувийн даатгалын сан руу орох агуулга яригдаж байсан санагдаж байна. Одоо би 2 жил хагасын юмыг ярьж байна л даа. Тэр үед ярьж байх үед энэ нэмэх 4 хувийн шимтгэл нь заавал хүнээс авах юм уу, сайн дураар байх юм уу гэдэг асуудал яригдаж байсан. Хэрвээ заавал авах бол энэ нөгөө нийгмийн даатгалын хувьд шимтгэл хэмжээ чинь бүр нэмэгдлээ. Татвар нэмэгдлээ гэдэг ийм асуудал руу орно. Тийм учраас энэ хувийн нэмэлт тэтгэврийн тогтолцоог, хувийн

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 28-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

даатгалын энэ бас салбарыг сайн дурын үндсэн дээр заавал нийгмийн даатгалын сангаас татаас өгөх байдлаар шийдэх гэж байна уу? Ямар байдлаар ер нь ажлын хэсэг дээр ярьсан бол. Мэдээж тухайн үед нөгөө Булгантуяа сайд энэ хуулийг санаачлагч байгаагүй. Тийм. Тэгэхээр энд одоо тухайн үеийн хууль санаачлагч Ариунзаяа сайд маань байхгүй байгаа. Тэгээд Булгаа сайд л хариулах болж байна, тийм үү? Байнгын хороо хариулах юм байна шүү дээ. Энэ ер нь яг юу болж орж ирж байгаа вэ гэдэг ийм асуулт байна.

Г.Занданшатар: Пүрэв-Очирын Анужин Байнгын хорооны дарга, ажлын хэсгийн ахлагч хариулъя.

П.Анужин: Энхбаяр гишүүний асуултад хариулъя. Маш чухал асуулт байна. Үнэхээрийн 2, 3 жилийн өмнө өмнөх парламентын үед Хувийн нэмэлт тэтгэврийн тухай асуудал яригдахад тухайн үеийн хууль санаачлагч нар нь бас энэ албан журмын шимтгэлээс авах тухай ярьж байсан. Энэ удаа Монгол Улсын Засгийн газраас өргөн баригдсан хуулийн концепт нь үүнтэй тэс өөр. Одоо нийгмийн даатгалд шимтгэл төлдөг иргэн өөрөө хүсвэл албан журмын шимтгэлээс орохгүйгээр өөрөө нэмэлт ийм шимтгэл төлөх тухай ийм өөр концепт орж ирсэн байгаа. Үүнийг манай Батжаргал дарга гүйцээгээд яг тодорхой хариулчихъя.

Г.Занданшатар: Содномын Чинзориг гишүүн.

85, Батжаргал байх аа, гүйцээж хариулъя.

Энхбаяр гишүүний асуултад хариулъя. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам Батжаргал. Засгийн газрын одоо хэлэлцэж байгаа өргөн барьсан хуулийн үндсэн концепт бол улсын тэтгэврийн схемтэй холбоогүй. Цэвэр бие даасан шинжтэй, нэмэлтээр, сайн дурын хэлбэртэй даатгуулах ийм үндсэн

зарчмаар бичигдсэн хуулийн төсөл байгаа юм. Баярлалаа.

Г.Занданшатар: Хариулчихсан уу.

Чинзориг гишүүн алга байна, хаслаа.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Зарчмын зөрөөтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна. Зарчмын зөрүүтэй 57 санал байгаа.

Санал хураалт явуулах ирц байхгүй байгаа учраас хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хойшууллаа.

Өнөөдөр нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

17.22 цаг

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ